


**МОНГОЛ ДАХЬ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС
ТӨРИЙН ОРОЛЦОО,
ГАДААД ОРНЫ
ТУРШЛАГА
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2022 он

A decorative graphic consisting of a cluster of small, multi-colored squares (blue, green, yellow, red, purple, pink) arranged in a pattern that suggests movement or data points, located to the left of the main title.

“МОНГОЛ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА”

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2022 он

Энэхүү судалгааг “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд “Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан” ТББ-ын судалгааны баг гүйцэтгэв.

Судалгааны тайланд тусгагдсан дүгнэлтүүд судалгааны багийн байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд төслийн санхүүжүүлэгч БНСУ-ын КОЙКА Олон улсын байгууллага болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байр суурийг илэрхийлээгүй болно.

СУДАЛГААНЫ БАГ

Багийн ахлагч:

Цэдэнхүүгийн БҮЖИДМАА.

Боловсрол судлалын доктор (Ph.D), профессор
“Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан” ТББ-ын
Тэргүүн.

Судлаачид:

Агваанжигмидийн БОЛОРМАА

Менежментийн ухааны доктор (Ph.D)
ШУТИС-ийн БУХС-ийн дэд профессор

Ганболдын ДЭЛГЭРСҮРЭН

Хууль зүйн ухааны магистр.
“Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан” ТББ-ын
Гүйцэтгэх Захирал

Энхсайханы ЭНХЧИМЭГ

Төрийн удирдлагын магистр.

Энхтөрийн МӨНХ-ЭРДЭНЭ

Туслах судлаач

Чулуунбаатарын ТУУЛ

Туслах судлаач

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ӨМНӨХ ҮГ	9
УДИРТГАЛ	10

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛС ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, өнөөгийн байдал	13
1.2. Эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ	25
1.3. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог судалсан байдал	37

БҮЛЭГ 2. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1. Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцоо	47
2.2. Сонгуулийн квот ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцоо	50
2.3. Улс төрийн санхүүжилт ба эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо	66
2.4. Улс орнуудын сайн туршлага, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн бодлого хөтөлбөрүүд	68

ДҮГНЭЛТ	88
САНАЛ ЗӨВЛӨМЖ	91
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	94
ХАВСРАЛТ	99

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ЭАБХУК	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци
БТҮАТ	Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны төлөвлөгөө
ЖЭТБХтХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
УТНтХ	Улс төрийн намын тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сан
УИХ	Улсын Их Хурал
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖҮХАА	Жендэрийн үндэсний хорооны ажлын алба
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МАН	Монгол Ардын Нам
АН	Ардчилсан нам
НАШБ	Намын анхан шатны байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
ТНДБ	Төрийн нарийн бичгийн дарга

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Зураг. 1.1. УИХ-д нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа (сонгуулийн жилээр)
- Зураг. 1.2. УИХ-ын гишүүдийн хүйсийн харьцаа
- Зураг. 1.3. 2020 оны УИХ-ын сонгуульд хамгийн олон эмэгтэйг нэр дэвшүүлсэн улс төрийн намууд
- Зураг. 1.4. УИХ-ын сүүлийн 4 удаагийн сонгуульд орон нутгийн тойргуудад нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тоо
- Зураг. 1.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь (сүүлийн 3 сонгуулиар)
- Зураг. 1.6. Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь сүүлийн 10 жилд
- Зураг. 1.7. Төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа
- Зураг. 1.8. Төрийн улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2016-2020 онд)
- Зураг. 1.9. Төрийн захиргааны албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2016-2020 онд)
- Зураг. 1.10. Төрийн захиргааны албан хаагчдын хүйсийн харьцаа, албан тушаалын ангиллаар
- Зураг. 1.11. Сум, дүүрэг дахь төрийн улс төрийн албан хаагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Зураг. 2.1. Франц улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Зураг. 2.2. Польш улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Зураг. 2.3. Армени улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Зураг. 2.4. Мексик улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Зураг. 2.5. Никарагуа улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Зураг. 2.6. Боливи улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Зураг. 2.7. Коста-Рика улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь

- Хүснэгт 1.1. Чанарын судалгаанд оролцогчдын тоо
- Хүснэгт 1.2. 2012 оны УИХ-ын сонгуульд улс төрийн намуудаас жагсаалтаар нэр дэвшүүлсэн байдал
- Хүснэгт 1.3. УИХ-ын 2008, 2012, 2016, 2020 оны сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо тойргоор
- Хүснэгт 1.4. Аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо, түүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 1.5. Сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо, түүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 1.6. Төрийн захиргааны удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2021 оны 1 сарын 1-ны байдлаар
- Хүснэгт 1.7. Монгол Улсын нэгдэн орсон жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт бүхий олон улсын гэрээ конвенцууд
- Хүснэгт 1.8. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенцийн заалтууд үндэсний хууль тогтоомжид туссан байдал
- Хүснэгт 1.9. Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенцийн заалтууд үндэсний хууль тогтоомжид туссан байдал
- Хүснэгт 1.10. Шийдвэр гаргах түвшинд жендэр тэгш эрхийг хангах зорилтыг дэмжиж буй зохицуулалтууд
- Хүснэгт 1.11 ЖЭТБТХ Огт хэрэгжихгүй байгаа заалтууд
- Хүснэгт 1.12 Зарим талаар хэрэгжихгүй байгаа заалтууд
- Хүснэгт 1.13 Өөрчлөх шаардлагатай болон нэмж оруулах заалтууд
- Хүснэгт 1.14. Намуудын дүрэмд хүйсийн квотыг тусгасан байдал
- Хүснэгт 1.15. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог судалсан судалгааны тайлангууд
- Хүснэгт 1.16. Судалгааны тайлангуудын агуулга, бүтцийн судалгаа
- Хүснэгт 2.1. Хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж буй эхний 10 орон
- Хүснэгт 2.2. Улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны бүсийн дундаж, тэргүүлэгч орны мэдээлэл
- Хүснэгт 2.3. Улс орнуудын сонгуулийн тогтолцоо ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 2.4. Улс орнуудын сонгуулийн тогтолцоо ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, бүс нутгаар
- Хүснэгт 2.5. Улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт засаглалын хэлбэрээр
- Хүснэгт 2.6. Парламентын засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр
- Хүснэгт 2.7. Холимог засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр
- Хүснэгт 2.8. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр

- Хүснэгт 2.9. Хаант засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр
- Хүснэгт 2.10. Сонгуулийн квот ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, бүсээр
- Хүснэгт 2.11. Хуулиар сонгуулийн квот тогтоосон улс орнуудын тоо, хувь хэмжээ
- Хүснэгт 2.12. Хуулиар сонгуулийн квот тогтоосон улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны эрэмбэ
- Хүснэгт 2.13. Хуулиар сонгуулийн квот тогтоосон улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны эрэмбэ бүсээр
- Хүснэгт 2.14. Квотыг хуульчилсан 59 орноос Үндсэн хуулиндаа тусгасан орнууд
- Хүснэгт 2.15. Индонез улсын парламентын дээд танхим дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Хүснэгт 2.16. Франц Улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Хүснэгт 2.17. Польш улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Хүснэгт 2.18. Армени улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Хүснэгт 2.19. Мексик улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Хүснэгт 2.20. Никарагуа улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Хүснэгт 2.21. Бразил улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт
- Хүснэгт 2.22. Боливи улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 2.23. Коста-Рика улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Хүснэгт 2.24. Суудал хадгалах квотыг хэрэгжүүлж буй улс орнууд
- Хүснэгт 2.25. Суудал хадгалах квотыг хуульчилсан улс орнуудын эрэмбэ, бүсээр
- Хүснэгт 2.26. Улс төрийн намын сайн дурын квотыг хэрэгжүүлэгч орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт, бүс нутгаар
- Хүснэгт 2.27. Квот хэрэглэдэггүй улс орнуудын эрэмбэ
- Хүснэгт 2.28. Квот хэрэглэдэггүй улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт, бүсээр
- Хүснэгт 2.29. Туршлага судалсан улс орнуудыг сонгосон үндэслэл
- Хүснэгт 2.30. БНСУ-ын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт, хууль эрх зүйн зарим мэдээлэл
- Хүснэгт 2.31. БНСУ-ын Гэр бүл, жендэрийн яамнаас жендэрийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөө
- Хүснэгт 2.32. Узбекистан улсын ерөнхий мэдээлэл

Хүснэгт 2.33	Зүүн Тимор улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт, хууль эрх зүйн зарим мэдээлэл
Хүснэгт 2.34	Балба улсын хууль эрх зүйн зарим мэдээлэл
Хүснэгт 2.35	Швед улсын хууль эрх зүйн зарим мэдээлэл
Хүснэгт 2.36	Испани улсын хууль эрх зүйн зарим мэдээлэл
Хүснэгт 2.37	Канадын улс төрийн зарим мэдээлэл
Хүснэгт 2.38	Гайана улсын улс төрийн зарим мэдээлэл
Хүснэгт 2.39	Шинэ Зеланд улсын улс төрийн зарим мэдээлэл
Хүснэгт 2.40	Фижи улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс
Хүснэгт 2.41	АНЭУ-ын улс төрийн зарим мэдээлэл
Хүснэгт 2.42	Тунис улсын улс төрийн зарим мэдээлэл
Хүснэгт 2.43	Өмнөд Африк улсын улс төрийн зарим мэдээлэл
Хүснэгт 2.44	Кабо-Верде улсын улс төрийн зарим мэдээлэл

ӨМНӨХ ҮГ

2021 оны байдлаар манай улсын нийт хүн амын 50.9 хувь¹, нийт сонгогчдын 52 хувь² нь эмэгтэйчүүд байна. Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг жендэрийн зөрүүтэй байдлын индексээр Монгол Улс 2018 онд 149 орноос 58 дугаар байранд³, 2020 онд 153 орноос 79 дүгээр байранд орсон байна⁴. Харин 2021 онд 156 орноос 69 дүгээр байранд эрэмбэлэгджээ. Гэвч улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр 156 орноос 116 дугаар байранд жагссан⁵ бөгөөд дэлхийн болон Азийн дунджаас доогуур байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, шийдвэр гаргах түвшин дэх төлөөллийг нэмэгдүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин, олон нийтийн дэмжлэг, нийгмийн тогтсон хандлага, улс төрийн санхүүжилт болон сонгуулийн тогтолцоо, улс төрийн намуудын бодлого, хүчин чармайлт зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байдаг.

Энэхүү судалгаагаар Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчин, олон улсын сайн туршлагыг судлан санал зөвлөмж боловсруулах зорилго тавьсан болно.

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн БНСУ-ын КОЙКА Олон улсын байгууллага болон НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн зөвлөхүүд, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, судалгааны ярилцлагад оролцож, үнэтэй санал өгсөн эрдэмтэн судлаачид, улс төрчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүдэд гүн талархал илэрхийлье.

Судалгааны баг.

¹ Монгол Улсын хүн амын тоо, нэг нас, хүйс, насны бүлгээр. <https://www.1212.mn/>

² 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтад 2 сая 624 иргэн бүртгэгдсэнээс 961 мянга 971 буюу 48 хувь нь эрэгтэй, 1 сая 38 мянга 653 буюу 52 хувь нь эмэгтэй байна. СЕХ-ний мэдээлэл.

³ World Economic Forum “The Global Gender Gap Index 2018”

⁴ World Economic Forum “The Global Gender Gap Index 2020”

⁵ World Economic Forum “Global Gender Gap Report 2021”

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсад шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгаа нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин, нийгмийн тогтсон хандлага, улс төрийн намуудын хүчин чармайлт, эрэгтэйчүүд давамгайлсан улс төрийн орчин гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Эдгээрийн дотроос эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийх өөрчлөлт нь нэн тэргүүнд судалгаа шинжилгээ шаардлагатай суурь хүчин зүйл юм.

Түүнчлэн дэлхийн улс орнуудын туршлагыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх, түүнийг түгээн дэлгэрүүлэх нь нэн ач холбогдолтой байна.

Улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь бидний дөхөж ядан буй 20 хувиас хол давж, эхний 5 орон 50-аас дээш хувь, 28 орон 40-өөс дээш хувь, 59 орон 30-аас дээш хувь, 117 орон 20-оос дээш хувьтай байна. Харин Монгол Улс 2021 оны 6 сарын 1-ний байдлаар 17.3 хувиар 193 орноос 127 дугаарт, Азийн бүсийн 30 орноос 19 дүгээр байранд эрэмбэлэгдэж байна.

Энэхүү судалгааны ажлаар улс орнуудын сайн туршлагыг судлан, Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулахаар зорьсон болно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО:

- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх олон улсын сайн туршлага, Монгол Улсад одоо үйлчилж буй хууль эрх зүйн орчныг судалж, шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөмж боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино.

ЗОРИЛТУУД:

1. Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, шийдвэр гаргах түвшин дэх өнөөгийн байдлыг судлах
2. Өмнө хийгдсэн судалгааны ажлуудын үр дүнг судлах
3. Монгол Улсад үйлчилж буй хууль эрх зүйн орчинд шинжилгээ хийх
4. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх олон улсын сайн туршлагыг судлах
5. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломжит шийдлүүдийг санал болгох, зөвлөмж боловсруулах

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ:

- Баримт бичгийн судалгаанд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах аргуудыг ашиглав.
- Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн баримт бичгүүдэд шинжилгээ хийж, харьцуулан судлав.
- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх асуудлаар Монгол Улсад хийгдсэн судалгааны тайлангууд, тэдгээрийн дүгнэлтийг харьцуулан судлав.
- Олон улсын туршлагыг харьцуулан судлахдаа улс орнуудад хэрэглэж буй сонгуулийн тогтолцоо, хүйсийн квотыг хэрэглэж буй туршлага, нийтлэг жишээ, баримт, манай улсад тохирохуйц боломжит загвар, туршлагыг авч үзсэн болно.
- Судалгааны дүгнэлтэд тулгуурлан шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх санал, зөвлөмж боловсруулав.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭР:

Судалгааны хүрээнд олон улсын туршлагыг судлахдаа нийт 18 орны туршлагыг авч үзсэн. Ингэхдээ “Олон Улсын парламентын холбоо”-ны ангиллаар а) Ази, б) Америк, в) Европ, г) Номхон далайн, д) Ойрх Дорнод ба Хойд Африк, е) Сахараас урагш Африкийн 6 бүс⁶ тус бүрээс сайн туршлага, содон жишээтэй улс орнуудыг сонгож судлав.

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдал, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар хийсэн судалгаа, шинжилгээний ажил нэлээдгүй байна. Эдгээрээс шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог судалсан 10 судалгааны тайланд (2012 оноос хойш) шинжилгээ хийсэн болно.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд УИХ-ын гишүүд, улс төрийн намуудын төлөөлөл, орон нутгийн улс төрч эмэгтэйчүүд, эрдэмтэн судлаачид, ИНБ-ын төлөөллийг хамруулсан 4 бүлгийн ярилцлага зохион байгуулж, 48 хүнийг хамруулав.

Эрдэмтэн, судлаачид, улс төрчид нийт 14 экспертээс ганцаарчилсан ярилцлага авч, мэдээллийг нэгтгэв. Ийнхүү нийт 62 оролцогчоос чанарын судалгааны мэдээллийг цуглуулсан болно.

Хүснэгт 1.1. Чанарын судалгаанд оролцогчдын тоо

Чанарын судалгаа	Ганцаарчилсан ярилцлага	Судлаач	n = 5 хүн
	Ганцаарчилсан ярилцлага	Улс төрч	n = 6 хүн
	Ганцаарчилсан ярилцлага	ИНБ	n = 3 хүн
	Бүлгийн ярилцлага		n = 48 хүн
Нийт			62 оролцогч

⁶ <https://data.ipu.org> “Олон Улсын парламентын холбоо” –ны бүсчилсэн ангилал

Мэдээлэл цуглуулах, боловсруулах:

Судалгааны мэдээллийг судалгааны багийн үндсэн судлаач 4, туслах судлаач 2 нийт 6 хүн ажлын 43 хоногт цуглуулав.

Ажлын даалгаврын дагуу тоон мэдээлэл цуглуулаагүй. Ярилцлагын судалгааг Zoom us программ ашиглан мөн биечлэн уулзаж цуглуулсан. Баримт бичгийн шинжилгээ болон ярилцлагын судалгааны мэдээллийг Microsoft Word 2010 программ ашиглан боловсруулав.

Мэдээллийг шинжлэх, тайлан боловсруулах:

Судалгааны хүрээнд цуглуулсан чанарын судалгааны мэдээллийг шинжилгээнд авч, нэгтгэн дүгнэх (analyzing), харьцуулах (comparing), эрс тэс ялгааг илрүүлэх (contrasting), тайлбарлах (interpreting) зэрэг аргыг ашиглав.

Чанарын судалгааны хэд хэдэн ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлагын үр дүнг нэгтгэн шинжилсэн (Cross-case analyses) бөгөөд тоон судалгаа, анкетын судалгаа хийгээгүй тул ярилцлагын судалгааны дүгнэлт, кейсүүдийг судалгааны эх олонлогт тархаан тайлбарлах боломжгүй болно.

Судалгааны тайланг ажлын даалгавар, судалгааны ажлын удирдамжид нийцүүлэн бүтэцчилж, судалгааны дүгнэлтэд тулгуурлан санал, зөвлөмж боловсруулав.

Судалгааны ишлэл, баримтад ижил утгатай хэт олон мэдээллийг давтан оруулаагүй бөгөөд шинжилгээнд бодит түлхэц болохуйц оновчтой цөөн ишлэл, хэрэгтэй жишээг тусгахыг зорьсон болно.

1 БҮЛЭГ МОНГОЛ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улс эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар нэлээдгүй хүчин чармайлт гаргаж, НҮБ болон бусад олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, тэдгээрийн зарчим, заалтуудыг үндэсний хууль тогтоомж, бодлого хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлж ирлээ. 2013 оноос жендэрийн тусгайлсан бодлого, төлөвлөлтийг хөгжүүлж, салбар бүрд жендэрийн бодлого стратеги, аймаг, нийслэл, дүүрэгт жендэрийн дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

Өнөөдөр Монгол Улсын нийт хүн амын 50.9 хувь нь эмэгтэйчүүд (2021 оны байдлаар) байна.

2020 оны байдлаар дэлхийн улс орнуудын жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтийн дундаж 68.6 хувь байх бөгөөд Монгол Улс 70.6 хувиар нийт 153 орноос 79 дүгээр байранд орж байна. Уг үзүүлэлт 2010 онд 71.9 хувь байснаас 1.3 нэгжээр буурчээ⁷. Харин 2021 онд 71.6 хувиар 156 орноос 69 дүгээр байранд эрэмбэлэгджээ. Гэвч улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр 156 орноос 116 дугаар байранд жагссан нь дэлхийн болон Азийн улс орнуудын дунджаас

доогуур байна⁸.

2021 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улс парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувиар нийт 193 орноос (17.3 хувь) 127 дугаарт жагсаж байна⁹.

Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн оролцоо:

2020 онд УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх сонгуулийн үр дүнгээ бататгасан хэдий ч нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тоо буурсан төдийгүй, дэлхийн дунджаас¹⁰ доогуур хэвээр байна.

Анх 1990-1992 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын 430 депутатаас Улсын Бага Хуралд сонгогдсон 50 гишүүний 2 нь эмэгтэй гишүүн байсан бол 1992 оны Монгол Улсын Их Хурлын сонгуульд 293 хүн нэр дэвшиж, сонгогдсон гишүүдийн 5.3 хувь буюу 4 нь эмэгтэй гишүүн байв.

УИХ-ын сонгуулийн дараагийн жилүүдийг авч үзвэл, 2000 онд нийт нэр дэвшигчдийн 2.5 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2004-2016 оны сонгуулиар нэр дэвшигчдийн дотор


⁷ Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. ЖҮХ, НҮБ-ын Хүн амын сан, “Эм Эм Си Жи” ХХК. 2020 он

⁸ World Economic Forum “Global Gender Gap Report 2021”

⁹ Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

¹⁰ Дэлхийн дундаж 2021 оны 1 сарын байдлаар 25.5 хувь байна. Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

эмэгтэйчүүдийн эзлэх хувь 25.9 хувь хүртэл өссөн бөгөөд харин 2020 оны сонгуулиар 24.9 хувь болж, 1 хувиар буурчээ.



Зураг 1.1. УИХ-д нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа (сонгуулийн жилээр)


2020 оны УИХ-ын сонгуульд нийт 606 хүн нэр дэвшиж өрсөлдсөн бөгөөд тэдгээрийн 151 нь эмэгтэй нэр дэвшигчид байснаас сонгуулийн үр дүнд 13 нь УИХ-ын гишүүнээр сонгогдсон.

1992 оноос хойших УИХ-ын 8 удаагийн сонгуулийн дүнд нийт 608 гишүүн сонгогдсоноос давхардсан тоогоор 64 нь эмэгтэй гишүүд байжээ. Эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 1992 онд 5.3 хувь байсан бол 2016, 2020 онуудад 17.1 хувь болж өссөн байна.

Сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон төлөөлөгчдийн дунд залуучууд, эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага боловч нэмэгдэж, 2020 оноос УИХ-ын дэд даргаар эмэгтэй гишүүн томилогдон ажиллаж байгаа ч энэ нь хангалттай биш бөгөөд 1990 оноос өнөөг хүртэл УИХ-ын даргаар ажилласан эмэгтэй гишүүн байхгүй байна.

Түүнчлэн 2020 оны байдлаар УИХ-ын гишүүдийн 7.8 хувь нь буюу 6 гишүүн 40-өөс доош насны залуу гишүүд, түүний дотор 35 хүртэлх насны залуу гишүүн 1 сонгогдсон байна. 1992 оноос хойших УИХ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл нэг ч удаа сонгогдож байсангүй.

Энэ бүхнээс үзэхэд Монгол Улс шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх (30.0 хувь болгох МХЗ-ын зорилтоо 2015 онд хангаж чадаагүй) “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын шалгуур үзүүлэлтийг хангаж чадах эсэх нь эргэлзээтэй байна.




Зураг 1.2. УИХ-ийн гишүүдийн хүйсийн харьцаа

Сүүлийн сонгуулиудад хуулиар тогтоосон квотыг хэрэглэж байгаа ч дан ганц квотыг хуульчилснаар улс төрд жендэрийн эрх тэгш байдал хангагдахгүй болох нь улам бүр батлагдсаар байна. 1996 онд УИХ-д нэр дэвшигчдийн 2.6 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2000 онд 1.5 хувь болж, 2016 онд 25.9 хувь байсан бол 2020 онд 24.9 хувь болж тус тус буурсан нь үүнийг гэрчлэх тод жишээ юм.

2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн хүйсийн харьцааг авч үзвэл хамгийн олон эмэгтэйг Зон олны нам, Хөгжлийн хөтөлбөр нам, Гэр хороолол хөгжлийн нам дэвшүүлсэн байна. Зон олны намын нэр дэвшигчдийн 77 хувь, Хөгжлийн хөтөлбөр намын нэр дэвшигчдийн 57 хувь, Гэр хороолол хөгжлийн намын нэр дэвшигчдийн 50 хувь нь эмэгтэйчүүд байжээ.

Харин эрх баригч МАН-ын нэр дэвшигчдийн 21 хувь, сөрөг хүчин АН-ын нэр дэвшигчдийн 22 хувь, “Та бүхний эвсэл”-ийн нэр

дэвшигчдийн 23 хувь, “Зөв хүн электорат” эвслийн нэр дэвшигчдийн 24.5 хувь нь эмэгтэйчүүд байсан байна.



Зураг 1.3. 2020 оны УИХ-ын сонгуульд хамгийн олон эмэгтэйг нэр дэвшүүлсэн улс төрийн намууд

Монгол Ардын нам (МАН)-ын Бага хурал болон Ардчилсан нам (АН)-ын Үндэсний бодлогын хороо (ҮБХ)-ны гишүүдийн 22 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол 2020 оны байдлаар аймаг, нийслэл, дүүргийн намын дарга нарын дотор нэг ч эмэгтэй байхгүй ажээ. Бусад намуудын дунд болон анхан шатны байгууллага дахь хүйсийн харьцааг харуулсан мэдээлэл байхгүй байна.

2012 оны УИХ-ын сонгуулийн баримт,

мэдээллийг шинжилж үзвэл тойрогт нэр дэвшүүлсэн 354 хүний 84 нь буюу 23.7 хувь нь л эмэгтэйчүүд байна¹¹.

Харин жагсаалтаар нэр дэвшүүлсэн 190 хүний 90 нь буюу 46.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд чухамдаа жагсаалтын хэд дээр эмэгтэй нэр дэвшигчдийг жагсаасан нь сонирхол татаж байна. Сонгогдсон 11 эмэгтэйгээс 6 нь мажоритар тойргоос, 5 нь намын жагсаалтаас сонгогдсон байдаг.

Хүснэгт 1.2. 2012 оны УИХ-ын сонгуульд улс төрийн намуудаас жагсаалтаар нэр дэвшүүлсэн байдал¹²

№	Улс төрийн намын нэр	Нийт нэр дэвшигчид	Эрэгтэй нэр дэвшигчид	Эмэгтэй нэр дэвшигчид		Эмэгтэй нэр дэвшигчдийг жагсаалтад байршуулсан байдал
				Тоо	Хувь	
1	Монгол ардын нам	28	18	10	35.7	10,12,14,16-18,20-23,
2	Ардчилсан нам	28	20	8	28.6	7,10,13,15,19,21,25,27
3	Гуравдагч хүчин эвсэл	26	12	14	53.8	8,9,13-15,17-23,25-26
4	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвсэл	24	14	10	41.7	4,10,12-13,15-16,18,21-22,24
5	Иргэний зориг ногоон нам	24	15	9	37.5	1,8-10,12-13,17,21-22
6	Иргэний хөдөлгөөн нам	18	0	18	100.0	1-18,
7	Монголын ногоон нам	16	8	8	50.0	6-7,10-15

¹¹ Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

¹² Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

8	Монголын социал демократ нам	7	4	3	42.9	2,4,7,
9	Монголын уламжлалын нэгдсэн нам	6	3	3	50.0	4-6,
10	Эх орон	5	3	2	40.0	3-4,
11	Хөгжлийн хөтөлбөр нам	5	2	3	60.0	1,3,5
12	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	2	1	1	50.0	2,
13	Эх орончдын нэгдсэн нам	1	1	0	0.0	0,
	Нийт	190	101	89	46.8	

Ийнхүү намын жагсаалтаар нэр дэвшигчдийн 46.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа ч хамгийн олон нэр дэвшигчтэй МАН, АН, Гуравдагч хүчин эвсэлийн нэр дэвшигчдийн жагсаалтыг эрэгтэйчүүд өнгөлж байна.


Дээрх хүснэгтээс харахад МАН 10 эмэгтэй нэр дэвшүүлж, жагсаалтын 10, 12, 14, 16-18 дугаарт жагсаасан бол, АН 8 эмэгтэй нэр дэвшигчээ 7, 10, 13, 15, 19, 21, 25, 27 дугаарт бичжээ. Монголын уламжлалын нэгдсэн нам 6 хүн жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ эхний 3-т эрэгтэй нэр дэвшигчийг сүүлийн 3-т эмэгтэй нэр дэвшигчдийг жагсаасан байна.

Эндээс үзэхэд пропорционал тогтолцооны хувьд нэр дэвшигчдийн жагсаалтад цахилгаан товчны зарчмыг баримтлах, эсвэл 1-3 дахь жагсаалтад 1, 4-7 дахь жагсаалтад 3 гэх мэтчилэн хүйсийн тэгш байдлын зарчмыг баримтлах талаар улс орнуудын туршлагыг судлан хэрэгжүүлэх, хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах нь туйлын чухал байна.


Орон нутаг дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо:

УИХ-д нэр дэвшигчдийн тоог авч үзвэл орон нутгийн тойргуудад нийслэл Улаанбаатар хотын тойрогтой харьцуулахад харьцангуй цөөн тооны эмэгтэйчүүд нэр дэвшиж байна.

Сүүлийн 4 удаагийн УИХ-ын сонгуульд давхардсан тоогоор нийтдээ 1814 хүн нэр дэвшсэнээс 430 нь буюу 23.7 хувь нь эмэгтэйчүүд байжээ.



Зураг 1.4. УИХ-ын сүүлийн 4 удаагийн сонгуульд орон нутгийн тойргуудад нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тоо



Үүнээс орон нутгийн тойрогт нэр дэвшигчдийн 18 хувь нь л эмэгтэйчүүд байгаа бол, нийслэл Улаанбаатар хотын тойргуудад нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ийнхүү хуульд заасан квотыг хангаж байгаа ч орон нутгийн тойргуудад УИХ-д нэр дэвшигч эмэгтэйчүүд 20 хувьд хүрэхгүй байна.

Үүнээс үүдэн орон нутгийн иргэдийн хувьд сонгох, сонгогдох эрх зөрчигдөж байгаа төдийгүй бүлгийн (эмэгтэй хүйсийн) төлөөллийг хангах төлөөллийн ардчиллын нэг үндсэн зарчим хэрэгжихгүй байна.

Сүүлийн 4 удаагийн орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн тоо түүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь дараах байдалтай байна.

Хүснэгт 1.3. УИХ-ын 2008, 2012, 2016, 2020 оны сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо тойргоор¹³

		2008			2012			2016			2020		
		НИЙТ	Эмэгтэй	ХУВЬ	НИЙТ	Эмэгтэй	ХУВЬ	НИЙТ	Эмэгтэй	ХУВЬ	НИЙТ	Эмэгтэй	ХУВЬ
1	Архангай	11	2	18.18	13	3	23.1	13	3	23.1	19	4	21.05
2	Баян-Өлгий	8	0	0	7	1	14.3	8	0	0.0	15	0	0
3	Баянхонгор	10	1	10	12	3	25.0	12	2	16.7	20	3	15
4	Булган	7	0	0	10	2	20.0	4	1	25.0	14	3	21.43
5	Говь-Алтай	6	1	16.67	8	1	12.5	6	0	0.0	10	5	50
6	Дорноговь/ГС	8	1	12.5	9	2	22.2	8	1	12.5	14	2	14.29
7	Дорнод	11	1	9.091	14	3	21.4	9	1	11.1	16	3	18.75
8	Дундговь	6	2	33.33	8	3	37.5	7	0	0.0	12	2	16.67
9	Завхан	14	3	21.43	12	3	25.0	10	3	30.0	14	3	21.43
10	Өвөрхангай	11	1	9.091	13	3	23.1	16	2	12.5	14	2	14.29
11	Өмнөговь	10	1	10	9	2	22.2	6	1	16.7	16	1	6.25
12	Сүхбаатар	7	1	14.29	6	2	33.3	4	0	0.0	10	4	40
13	Сэлэнгэ	10	1	10	14	4	28.6	14	2	14.3	23	6	26.09
14	Төв	13	3	23.08	11		0.0	10	3	30.0	18	6	33.33
15	Увс	7	0	0	12	3	25.0	9	1	11.1	23	5	21.74
16	Ховд	14	0	0	15	3	20.0	15	1	6.7	17	4	23.53
17	Хөвсгөл	13	2	15.38	13	1	7.7	14	4	28.6	21	5	23.81
18	Хэнтий	12	3	25	13	3	23.1	11	0	0.0	13	3	23.08
19	Дархан-Уул	18	3	16.67	15	3	20.0	18	1	5.6	25	6	24
20	Орхон	14	3	21.43	15	1	6.7	21	7	33.3	27	8	29.63
Аймгийн дүн		210	29	13.81	229	46	20.1	215	33	15.3	341	75	21.99
21	Хан-Уул,Багануур, Багахангай	14	4	28.57	16	5	31.3	40	14	35.0	14	5	35.71
22	БЗД,Налайх	34	11	32.35	28	9	32.1	69	22	31.9	64	21	32.81
23	Сүхбаатар	22	5	22.73	17	4	23.5	36	17	47.2	38	10	26.32
24	Чингэлтэй	22	4	18.18	19	6	31.6	46	13	28.3	33	10	30.3
25	Баянгол	31	8	25.81	18	8	44.4	34	10	29.4	36	8	22.22
26	СХД	23	5	21.74	27	6	22.2	58	20	34.5	50	15	30
27	Хан-Уул										30	7	23.33
Нийслэл/дүн		146	37	25.34	125	38	30.4	283	96	33.9	265	76	28.68
Тойрог дахь улсын дүн		356	66	18.54	354	84	23.7	498	129	25.9	606	151	24.92
Жагсаалтаар					190	90	47.4						
УЛСЫН ДҮН					544	174	32.0						

¹³ Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

Баян-Өлгий аймагт сүүлийн 4 удаагийн УИХ-ын сонгуульд нийт 38 хүн нэр дэвшсэн ч зөвхөн 2012 онд л 1 эмэгтэй нэр дэвшсэн байгааг дээрх хүснэгтээс харж болно. Түүнчлэн Өмнөговь, Ховд аймгууд хамгийн цөөн эмэгтэй нэр дэвшигчээр жагсаалтыг удаалж байна.

Харин нийслэл Улаанбаатар хотын дүүргүүдийн хувьд нэр дэвшигчдийн 25-33 хүртэл хувь нь

эмэгтэйчүүд байх бөгөөд ялангуяа Баянзүрх, Багахангай, Налайх, Сүхбаатар дүүрэгт сүүлийн 4 удаагийн УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 31-33 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Тэгвэл орон нутгийн сонгууль буюу аймаг, нийслэлийн ИТХ дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж дөнгөж 15 хувьтай байна.

Хүснэгт 1.4. Аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо, түүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь¹⁴

Аймаг, нийслэл	2012			2016			2020		
	Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй	
		Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь
Архангай	37	6	6.22	39	6	15.38	39	9	23.08
Баян-өлгий	33	4	2.12	39	4	10.26	39	5	12.82
Баянхонгор	41	5	2.20	41	10	24.39	41	5	12.20
Булган	33	10	30.30	33	6	18.18	33	6	18.18
Говь-алтай	35	3	8.57	41	7	17.07	41	6	14.63
Дорнод	35	3	8.57	35	3	8.57	37	5	13.51
Дорноговь	27	3	1.11	31	5	16.13	33	7	21.21
Дундговь	35	5	14.29	35	4	11.43	35	6	17.14
Завхан	41	8	9.51	41	9	21.95	41	6	14.63
Өвөрхангай	41	8	9.51	41	7	17.07	41	7	17.07
Өмнөговь	33	6	18.18	33	1	3.03	33	4	12.12
Сүхбаатар	33	6	8.18	33	5	15.15	33	6	18.18
Сэлэнгэ	37	9	4.32	37	7	18.92	37	5	13.51
Төв	41	8	19.51	41	7	17.07	41	10	24.39
Увс	41	7	17.07	41	5	12.20	41	4	9.76
Ховд	41	4	9.76	41	9	21.95	41	7	17.07
Хөвсгөл	41	7	17.07	41	8	19.51	41	7	17.07
Хэнтий	39	7	17.95	39	8	20.51	39	5	12.82
Дархан	33	3	9.09	33	6	18.18	33	3	9.09
Орхон	31	5	16.13	33	2	6.06	35	5	14.29
Говьсүмбэр	17	3	17.65	17	1	5.88	17	2	11.76
Улаанбаатар	45	6	13.33	45	10	22.22	45	8	17.78
Бүгд	790	126		810	130		816	128	
Хувь			15.94			15.51		15.7	15.56

Дээрх хүснэгтээс харахад 2012 оны сонгуулиар аймгийн ИТХ-д сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдийн тоо 20-оос дээш хувьд хүрсэн ганцхан аймаг (Булган 30.3 хувь) байсан бөгөөд 2016 онд 4 аймаг (Баянхонгор, Завхан, Ховд, Хэнтий) болсон бол 2020 онд эдгээр 4 аймгийн хувьд сонгогдсон

эмэгтэйчүүдийн тоо буурсан төдийгүй улсын хэмжээнд 3 хан (Архангай, Дорноговь, Төв) аймгийн ИТХ-д 20-оос дээш хувьд нь эмэгтэй төлөөлөгчид сонгогджээ.

Харин Төв, Хөвсгөл, Булган 3 аймагт хэдийгээр 2016 онд бууралт ажиглагдаж байгаа ч сүүлийн 3 удаагийн аймгийн ИТХ-ын

¹⁴ Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

сонгуульд хамгийн өндөр буюу 17-24 хувьд нь эмэгтэй төлөөлөгчид сонгогдож иржээ.

Архангай (6-23 хувь), Баян-Өлгий (2-12 хувь), Дорнод (8-13 хувь), Дорноговь (1-21 хувь), Өвөрхангай (9-17 хувь), Сүхбаатар (8-18 хувь) гэсэн 6 аймагт сүүлийн 3 удаагийн

аймгийн ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо тасралтгүй өссөн байна.

Харин Увс аймгийн ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо 2012 оноос тасралтгүй буурсаар 2012 онд 17 хувь, 2016 онд 12.2 хувь, 2020 онд 9.76 хувь болжээ.

Хүснэгт 1.5. Сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо, түүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь¹⁵

Аймаг, нийслэл	2012			2016			2020		
	Нийт	эмэгтэй	Хувь	Нийт	эмэгтэй	Хувь	Нийт	Эмэгтэй	Хувь
Архангай	439	111	25.28	433	104	24.02	433	112	25.87
Баян-өлгий	313	39	12.46	329	46	13.98	329	51	15.50
Баянхонгор	418	111	26.56	418	93	22.25	418	98	23.44
Булган	334	109	32.63	340	117	34.41	340	107	31.47
Говь-алтай	358	114	31.84	363	72	19.83	364	79	21.70
Дорнод	280	70	25.00	274	69	25.18	278	112	40.29
Дорноговь	272	92	33.82	272	100	36.76	280	73	26.07
Дундговь	295	98	33.22	295	98	33.22	295	94	31.86
Завхан	448	108	24.11	442	104	23.53	452	139	30.75
Өвөрхангай	447	145	32.44	447	132	29.53	447	127	28.41
Өмнөговь	295	92	31.19	305	112	36.72	313	85	27.16
Сүхбаатар	271	88	32.47	271	107	39.48	277	88	31.77
Сэлэнгэ	389	134	34.45	387	147	37.98	393	141	35.88
Төв	535	212	39.63	523	202	38.62	541	201	37.15
Увс	403	72	17.87	403	84	20.84	403	97	24.07
Ховд	377	73	19.36	371	66	17.79	371	83	22.37
Хөвсгөл	517	123	23.79	517	132	25.53	517	120	23.21
Хэнтий	374	186	49.73	388	127	32.73	386	131	33.94
Дархан	106	38	35.85	106	33	31.13	106	42	39.62
Орхон	52	13	25.00	52	8	15.38	52	12	23.08
Говьсүмбэр	67	19	28.36	67	18	26.87	67	18	26.87
Улаанбаатар	295	89	30.17	291	82	28.18	291	85	29.21
Бүгд	7285	2136		7294	2053		7353	2095	
Хувь			29.33			27.91			28.62

Сум, дүүргийн ИТХ-ын хувьд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь 2012 онтой харьцуулахад буурсан төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл 2012 онд 29.33 хувь, 2016 онд 27.1 хувь, 2020 онд 28.62 хувь болжээ.

Аймгаар авч үзвэл мөн л Баян-Өлгий аймагт хамгийн цөөн тооны эмэгтэй төлөөлөгч сонгогдсон төдийгүй 2020 оны сонгуулиар 20-оос бага хувьтай эмэгтэй төлөөлөгч бүхий


цорын ганц аймаг болж байна. Сумдын ИТХ дахь эмэгтэй төлөөлөгчдийн тоо сүүлийн 3 сонгуулийн дунджаар Говь-Алтай, Ховд аймгуудад хамгийн бага хувийг эзэлж байна.

2012 оны сонгуулиар 12 аймгийн сумдын ИТХ-д 30-аас дээш хувьд нь эмэгтэй төлөөлөгч сонгогдсон бол 2016, 2020 онд энэ үзүүлэлт буурч 9 аймаг болжээ.

¹⁵ Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

Энэ бүхнээс дүгнэвэл Монгол Улсад орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагад шат ахих тусам эмэгтэйчүүдийн төлөөлөл багасаж байна.

Цаашид аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасан хүйсийн квотыг нэмэгдүүлэх, эмэгтэй нэр дэвшигч, төлөөлөгчдийг дэмжих бодлого хөтөлбөрийг улс төрийн намууд дотооддоо авч хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.




Зураг 1.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь (сүүлийн 3 сонгуулиар)

Төрийн удирдах албан тушаал дахь эмэгтэйчүүдийн оролцоо:

2021 оны байдлаар Төрийн албан хаагчдын дийлэнх буюу 61.65 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд дунджаар 0.58 хувиар өсчээ¹⁶.

Энэ тоо 2020 онд 0.81 хувиар өссөн ч төрийн улс төрийн албан тушаалд ажиллаж буй нийт албан хаагчдын 23.9 хувь, төрийн захиргааны тэргүүн түшмэлийн албан тушаалд ажиллаж буй нийт албан хаагчдын 25.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ нь төрийн нийт албан хаагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх буй дунджаас 37.7–35.9 хувиар бага байна.¹⁷

Төрийн нийт албан хаагчдын тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (10 жилээр)¹⁸



Зураг 1.6. Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь сүүлийн 10 жилд

¹⁶ Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан. УБ. 2021.

¹⁷ Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан. УБ. 2021.

¹⁸ Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан. УБ. 2021.



Зураг 1.7. Төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа

Төрийн удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувийг авч үзвэл 2020 оны байдлаар Яамны сайд, аймаг нийслэлийн Засаг даргын орлогч, дүүргийн ИТХ-ын дарга,

дүүргийн Засаг даргын орлогч, сумын ЗДТГ-ын даргын албан тушаалаас бусад албан тушаалд ЖТБТХ-д заасан квот хангагдахгүй байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1.6. Төрийн захиргааны удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2021 оны 1 сарын 1-ны байдлаар²⁰.

	Нийт	Эмэгтэйчүүдийн тоо	Хувь	Хуульд заасан квот
Төрийн захиргааны албан тушаал				
1. Яамдын Төрийн нарийн бичгийн дарга	14	0	0%	15%
2. Засгийн газрын агентлагийн дарга	36	3	8.3%	15%
3. Аймаг нийслэлийн ИТХ-ын НБ дарга	22	5	22.7%	Квот тогтоогоогүй
4. Дүүргийн ИТХ-ын НБ дарга	9	2	22.2%	
5. Сумын ИТХ-ын НБ дарга	330	200	60.6%	
6. Аймаг нийслэлийн ЗДТГ-ын дарга	22	4	18.2%	40%
7. Дүүргийн ЗДТГ-ын дарга	9	1	11.1%	40%
8. Сумын ЗДТГ-ын дарга	330	157	47.6%	40%


Төрийн улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хууль тогтоох байгууллагад сүүлийн 2 сонгууль дамжин өөрчлөгдөөгүй, яамны сайдын хувьд 2016-2021 онд Засгийн газар солигдсонтой холбоотойгоор өгсөж буурсаар өнөөдөр

хамгийн өндөр буюу 28 хувьд хүрээд байна. Харин дэд сайдын албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүд 2016 онд 5 буюу 38.5 хувь байсан бол 2021 оны байдлаар 14.2 хувь буюу 2 хүн болж буураад байна.

¹⁹ Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан. УБ. 2021.

²⁰ Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан. УБ. 2021.

Төрийн улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2016-2020)




	2016			2017			2018			2019			2020		
	Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй	
		Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь
УИХ-ын гишүүд	76	13	17.1	76	13	17.1	76	13	17.1	76	13	17.1	76	13	17.1
Яамны сайд	16	2	12.5	16	2	12.5	16	2	12.5	16	1	6.3	14	4	28
Дэд сайд	13	5	38.5	13	5	38.5	13	5	38.5	13	5	38.5	14	2	14.2
Аймаг, нийслэлийн ЗД	22	0	0	22	0	0	22	0	0	22	0	-	22	4	18.2
Аймаг, нийслэлийн ЗДО	35	6	17.2	37	5	13.5	37	5	13.5	39	7	17.9	22	4	18.1
Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга	22	0	0	22	0	0	22	0	0	22	0	0	22	2	9

Зураг 1.8. Төрийн улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2016-2020 онд)

2016-2020 онд 14 яамнаас 1 яаманд төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд эмэгтэй хүн ажиллаж байсан бол 2020 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газарт нэг ч эмэгтэй Төрийн нарийн бичгийн дарга томилогдоогүй юм. Харин 2021 оноос

1 яамны (Соёлын яам) Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд эмэгтэй хүн томилогдон ажиллаж байна. 2016-2017 онд агентлагийн дарга нарын дунд эмэгтэй хүн байсангүй.

Төрийн захиргааны албан хаагч



	2016			2017			2018			2019			2020		
	Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй		Нийт	Эмэгтэй	
		Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь
Төрийн нарийн бичгийн дарга	13	1	7.7	13	1	7.7	13	1	7.7	13	1	7.7	14	0	0
Агентлагийн дарга	27	0	0	27	0	0	30	1	3.3	30	1	3.3	36	3	8.3
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	22	2	9.1	22	4	18.2	22	4	18.2	22	4	18.2	22	4	18.2
Аймаг нийслэлийн ИТХ-ын НБД	22	4	18.2	22	4	18.2	22	4	18.2	22	5	22.7	22	5	22.7

Зураг 1.9. Төрийн захиргааны албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2016-2020 онд)

Дээрх зургаас харахад график хэдийгээр өссөн харагдаж байгаа ч, ЖТБтХ-д заасан квотыг хангаж чадахгүй байна.

Албан тушаалын ангилал /хүйсээр/



Зураг 1.10. Төрийн захиргааны албан хаагчдын хүйсийн харьцаа, албан тушаалын ангиллаар²¹


Төрийн захиргааны албан тушаалын ангиллаар авч үзвэл зэрэглэл ахих тусам эмэгтэйчүүдийн тоо буурдаг урвуу хандлага ажиглагдана.

2020 оны байдлаар туслах түшмэлийн албан тушаалын 57 хувь, дэс түшмэлийн албан тушаалын 65 хувьд нь эмэгтэйчүүд ажиллаж байгаа бол эрхэлсэн түшмэлийн албан тушаалтнуудын 40 хувь, тэргүүн түшмэлийн албан тушаалтнуудын 26 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Монгол Улсын ТАЗ-ийн тайлангаас үзэхэд нийслэлийн дүүргүүд болон сумдын түвшин дэх төрийн улс төрийн албан тушаалтнуудын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь ялгаатай байна. Тухайлбал дүүргүүдийн ИТХ-ын

дарга болон Засаг даргын орлогчийн албан тушаалд ЖТБтХ-д заасан квот хангагдсан байхад сумдад огт хангагдаагүй байна. Харин Сумын ЗДТГ-ын дарга нарын 47,6 хувь нь эмэгтэйчүүд байна.

²¹ Монгол Улсын ТАЗ-ийн ажлын албаны мэдээлэл. 2021 оны 1 сарын байдлаар.



Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл

Зураг 1.11. Сум дүүрэг дахь төрийн улс төрийн албан хаагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь.

Энэ бүхнээс дүгнэхэд Монгол Улсад шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй, хуульд заасан квот бүрэн хангагдахгүй байна.

Ялангуяа хууль тогтоох дээд байгууллага болон аймаг, нийслэлийн ИТХ, төрийн улс төрийн

албан тушаал болон төрийн захиргааны тэргүүн түшмэлийн албан тушаалд ЖЭТБХХ-д заасан квотууд хангагдаагүй байна.

Иймд хууль эрх зүйн орчноо эргэн харж, боловсронгуй болгох шаардлага улам бүр хурцаар тавигдаж байна.

1.2. ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцууд:

Монгол Улс 2021 оны 6 сарын байдлаар нийт 294 олон талт гэрээнд нэгдэн орсон бөгөөд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт бүхий дараах олон улсын гэрээ, хэлцлүүдэд гарын үсэг зурж, нэгдэн орсон байна.

Хүснэгт 1.7. Монгол Улсын нэгдэн орсон жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт бүхий олон улсын гэрээ конвенцууд

№	Нэгдэн орсон гэрээ конвенцуудын нэр	МУ соёрхон баталсан он
1	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1981
2	Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол	2001
3	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	1974
4	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол	2010
5	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	1974
6	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол	1991
7	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протокол	2012
8	Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц	1965
9	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1969
10	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн орчин нөхцөлийг дээшлүүлэх тухай конвенц	2019
11	Хүүхдийн эрхийн тухай конвенц	1990
12	Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахгүй байх тухай ОУХБ-ын конвенц	
13	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	2008
14	Боловсролын салбар дахь алагчлах үзлийн эсрэг конвенц	1966
15	Амаржсан эхийн эрхийг хамгаалах ОУХБ-ын 103 дугаар конвенц	
16	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, 190 дүгээр зөвлөмж	
17	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн конвенцид оруулах нэмэлт протокол	2002
18	Тэгш шан, хөлс олгох тухай ОУХБ-ын конвенц	1969

Жендэрийн эрх тэгш байдлын асуудлаар гарсан олон улсын хоёр гол баримт бичиг нь “Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенци” (ЭАБХУК-СЕ-DAW) болон Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны төлөвлөгөө (БТУАТ - BPFA) юм.

“Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенц” (ЭАБХУК): 1979 онд батлагдсан энэхүү конвенцийг “эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулсан хамгийн иж бүрэн олон улсын гэрээ” гэж үздэг.²² Уг гэрээг соёрхон баталснаар Засгийн газрууд “жендэрийн эрх тэгш

²² “Монгол Улсын төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцоо” Төрийн захиргааны байгууллагуудад зориулсан гарын авлага, НҮБХХ, УБ, 2020 он. НҮБ-Эмэгтэйчүүд: <https://asiapacific.unwomen.org/media/field%20office%20eseasia/docs/publications/2016/04/national%20women%20machineries.pdf?la=en&vs=4214>, (2020 оны 8-р сарын 20). Хуудас 5

байдлыг хангах асуудлыг дотоодын хууль тогтоомжид тусгах, хууль тогтоомж дахь бүхий л алагчилсан заалтуудыг хүчингүй болгох, өөрчлөх болон эмэгтэйчүүдийг алагчлахын эсрэг шинэ заалт хуульд нэмж оруулах үүрэг хүлээсэн”²³

Засгийн газрууд конвенцийн хэрэгжилтийг Конвенцийн хороонд дөрвөн жил тутам тайлагнадаг. Хороо тайланг хянаж үзээд, зөвлөлдсөний эцэст “ажиглалтын дүгнэлт” гарган, түүнд үндэслэсэн конвенцийн хэрэгжилтийг хэрхэн эрчимжүүлэх тухай зөвлөмж гаргаж, Засгийн газруудад хүргүүлдэг.

Монгол Улс энэхүү конвенцийг 1981 оны 5 сарын 11-ний өдөр соёрхон баталж, 1981 оны 9 сарын 11-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд бусад улс орнууд, Засгийн газрын нэгэн адилаар хэрэгжилтийн тайланг НҮБ-д хүргүүлж, түүний зэрэгцээ хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-аас сүүдэр илтгэлийг хүргүүлэн ажиллаж байна.

2020 оны байдлаар ЭАБХУК-ийн зөвлөмжийн 90 хувийг Монгол Улсын Засгийн газар

хүлээн авч, одоогоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд голчлон хэрэгжүүлж байна.

“Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны төлөвлөгөө” (БҮАТ - BPFA): 1995 онд зохион байгуулсан Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурлаар батлагдсан БҮАТ-нд “эмэгтэйчүүдийг жинхэнэ тэгш эрх болон эрх мэдлээр хангах” 23 зорилтыг биелүүлэхтэй холбоотой 12 тэргүүлэх чиглэлийг зааж өгсөн.

Ийнхүү Монгол Улс эмэгтэйчүүдийн улс төрийн эрхтэй холбоотой 3 конвенцт нэгдэн орсон бөгөөд конвенцийн заалтууд үндэсний хууль тогтоомжид дараах байдлаар тусгалаа олжээ.

а) Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц

Монгол улс 1981 онд элсэн орсон. 3 үндсэн заалт байдаг бөгөөд Монгол Улс үндэсний хууль тогтоомждоо дараах байдлаар тусган хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1.8. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенцийн заалтууд үндэсний хууль тогтоомжид туссан байдал

Конвенцийн заалт	1 дүгээр зүйл Эмэгтэйчүүд аливаа алагчлалгүйгээр эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх тэгш байдлаар бүх сонгуульд саналаа өгөх эрхтэй	2 дугаар зүйл Эмэгтэйчүүд аливаа алагчлалгүйгээр эрэгтэйчүүдийн нэгэн адил үндэсний хууль тогтоомжийн дагуу тогтоосон бөгөөд нийтээр сонгогдвол зохих бүх байгууллагад сонгогдох эрхтэй	3 дугаар зүйл Эмэгтэйчүүд аливаа алагчлалгүйгээр эрэгтэйчүүдийн нэгэн адил төрийн алба хаших болон үндэсний хууль тогтоомжийн дагуу тогтоосон төрийн бүхий л үүргийг гүйцэтгэх эрхтэй.
Монгол Улсын Үндсэн хууль 1992 он	+	+	+
“Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль”	+	+	+
Төрийн албаны тухай хууль			+
Улс төрийн намын тухай хууль		+	
УИХ-ын Сонгуулийн тухай хууль		+	
“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль” (МУИХ, 2020)	+	+	
“Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль” (МУИХ, 2020)		+	+

²³ Мөн тэнд

б) Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц

Конвенцийн 7 дугаар зүйлд “Оролцогч улсууд тухайн улсын улс төр, олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг

устгах үүднээс зохистой бүхий л арга хэмжээг авна, тухайлбал, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил нөхцөлд дараах эрхээр хангана хэмээх заалтыг үндэсний хууль тогтоомждоо дараах байдлаар тусган хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1.9. Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенцийн заалтууд үндэсний хууль тогтоомжид туссан байдал

Конвенцийн 7 дугаар зүйлийн заалт	а)бүх сонгууль,ард нийтийн санал хураалтад санал өгөх болон нийтээр сонгох бүх байгууллагад сонгогдох;	б)төрийн бодлогыг боловсруулах,хэрэгжүүлэхэд оролцох,төрийн алба хаах, түүнчлэн төрийн захиргааны бүх түвшинд үүрэг гүйцэтгэх;	с)тухайн улсын олон нийтийн болон улс төрийн амьдралтай холбогдол бүхий төрийн бус байгууллага,нийгэмлэгэд оролцох.
Монгол Улсын Үндсэн хууль 1992 он	+	+	+
“Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль”	+	+	+
Төрийн албаны тухай хууль		+	
Улс төрийн намын тухай хууль	+		
УИХ-ын Сонгуулийн тухай хууль	+		
“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль” (МУИХ, 2020)	+		
“Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль” (МУИХ, 2020)	+	+	+

ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТЭДГЭЭРИЙН ЗОХИЦУУЛАЛТ:

Монгол Улс анх 1924 онд БНМАУ-ын анхны Үндсэн хуульдаа эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш шударга хандах талаар тусгаж, 1992 оны шинэ Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлан хэрэгжүүлж ирлээ.

Монгол Улсын Үндсэн хууль (1992)

Монгол Улс 1992 оны шинэ үндсэн хуулиараа улс төрийн эрх, эрх чөлөөнд шууд буюу төлөөллийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах үйл хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж

шийдвэрлүүлэх, тайван замаар жагсаал цуглаан хийх эрхийг хуульчилсан.

Үндсэн хуулийн Арван зургаа дугаар зүйлд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхах үл болно гэж заажээ.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” (2011)

2011 оноос өмнө Монгол Улсад жендэрийн асуудлыг зохицуулсан, тусгайлсан хууль байгаагүй учир энэ хуулийг батлан гаргасан явдал нь жендэрийн эрх тэгш байдлыг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн маш чухал алхам болж чадсан гэж үздэг. Энэхүү хуулиар улс төр, эрх

зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн үндсийг баталгаажуулж, хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хүлээх хариуцлагыг тодорхойлж, улс төрийн намын өөрийн төлөөллийн байгууллагын бүрэлдэхүүн болон төрийн албаны шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх квотын хувь хэмжээг зааж өгсөн.

“Улс төрийн намын тухай хууль” (2005)

Улс төрийн намууд гишүүддээ намын удирдах байгууллага болон сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох, сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгоход хүйсийн тэгш байдлыг хангах зарчим баримтлахыг хуульчилжээ.

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль” (2019)

Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх тухай мөн энэ заалтыг хангаагүй бол СЕХ бүртгэж авахгүй байх заалтыг оруулжээ.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль” (2020)

Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэж хуульчилсан. Энэ заалтыг хангаагүй бол СЕХ бүртгэж авахгүй байх заалтыг оруулжээ.

“Төрийн албаны тухай хууль” (2017)

Төрийн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэхэд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно хэмээн заасан.

“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль” (2020)

Комиссын гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар тусгасан.

Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилтыг дэмжиж байгаа дараах хуулийн зохицуулалтууд байна.

Хүснэгт 1.10. Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилтыг дэмжиж буй зохицуулалтууд.

1	МУ-ын Үндсэн Хууль (1992)	14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.
		16 дугаар зүйлийн 9 дэх хэсэг	Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.
		16 дугаар зүйлийн 11 дэх хэсэг	Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;
2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)	6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно.
		7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Энэ хуулийн 5.2-т заасан төрийн бодлогын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм, гэр бүлийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгах, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх бөгөөд эдгээр тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.
		7 дугаар зүйлийн 7.2.2.	Улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх;
		7 дугаар зүйлийн 7.2.3.	Тодорхой салбар дахь хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ авах, эсхүл аль нэг ажил, мэргэжлийн хүйсийн тэгш бус төлөөллийг тэнцвэржүүлэхэд түлхэц өгөхүйц хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, эсхүл тэтгэлэг тогтоох;
		8 дугаар зүйлийн 8.1.	Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.

2	8 дугаар зүйлийн 8.2.	Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй,эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.	
	8 дугаар зүйлийн 8.3.	Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна	
	8 дугаар зүйлийн 8.4.	Улс төрийн нам нь энэ хуулийн 8.2,8.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийн тайланг энэ хуулийн 18.1-д заасан Жендэрийн үндэсний хороонд хоёр жил тутам хүргүүлж байна.	
	10 дугаар зүйлийн 10.1.1	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар,аймаг,нийслэлд 15 хувиас,дүүрэгт 20 хувиас,суманд 25 хувиас,хороонд 30 хувиас доошгүй байх;	
	10 дугаар зүйлийн 10.1.2	Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга,Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас,бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас,яамдын газар,хэлтсийн даргын 30 хувиас,аймаг,нийслэл,сум,дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс,албадын даргын 40 хувиас доошгүй байх;	
	10 дугаар зүйлийн 10.1.3	Зэвсэгт хүчин,хилийн ба дотоодын цэрэг,тагнуул,цагдаа,шүүхийн шийдвэр гүйцэтгэх,авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх;	
	10 дугаар зүйлийн 10.1.4	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах бодлого,арга хэмжээг тусгай хөтөлбөр,төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.	
10 дугаар зүйлийн 10.2.	Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо,зөвлөл,комисс (цаашид “хороо” гэх)ээрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна.		
Нийт 16 заалт			
3	“Төрийн албаны тухай хууль” (2017)	31 дүгээр зүйлийн 31.4	Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс,угсаа,арьсны өнгө,нас,хүйс,нийгмийн гарал,байдал,хөрөнгө чинээ,эрхэлсэн ажил,албан тушаал,шашин шүтлэг,үзэл бодол,нам,олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.
4	“Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль” (2020)	12 дугаар зүйлийн 12.9	Комиссын гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар тусгасан.
5	УИХ-ын сонгуулийн тухай (2019)	30 дугаар зүйлийн 30.2	...нам,эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
6	“Аймаг,нийслэл, сум,дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль” (2020)	29 дүгээр зүйлийн 29.2	Нам,эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.
7	Улс төрийн намын тухай хууль (2005)	3 дугаар зүйлийн 3.3.	Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу аль нэг намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд иргэнийг мөшгөн хавчих,заналхийх,гүтгэх,доромжлох, дарамтлахыг хориглоно.
		5 дугаар зүйлийн 5.1.3	Гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох,сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс,угсаа,арьсны өнгө,нас,хүйс,хөрөнгө чинээ,эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох
		11 дүгээр зүйлийн 11.2.8	Сонгуульд нэр дэвшүүлэх,боловсон хүчнийг шилж сонгох,хүйсийн тэгш байдлыг хангах зарчим баримтлах
8	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” (2016)	4 дүгээр зүйлийн 4.1.11	“Бие даан амьдрах эрх” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах,сонголт хийх,оролцох боломжийг олгох, Хуулийн 6.3-т хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай,аюулгүй орчинд амьдрах,сүрч боловсрох,шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох,улс төрийн эрхээ эдэлнэ.

Огт хэрэгжихгүй байгаа заалтууд:

Хүснэгт 1.11. ЖЭТБтХ-ийн огт хэрэгжихгүй байгаа заалтууд

	Хуулийн заалт	Огт хэрэгжихгүй байгаа тухай тайлбар
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль.		
1	7.2.3. Тодорхой салбар дахь хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ авах, эсхүл аль нэг ажил, мэргэжлийн хүйсийн тэгш бус төлөөллийг тэнцвэржүүлэхэд түлхэц өгөхүйц хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, эсхүл тэтгэлэг тогтоох;	(Судалгааны ярилцлагын тэмдэглэлээс) Хүйсийн тэгш бус төлөөллийг тэнцвэржүүлэхэд түлхэц өгөхүйц хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, эсхүл тэтгэлэг тогтоосон практик одоогоор байхгүй байна.
2	8.4. Улс төрийн нам нь энэ хуулийн 8.2, 8.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийн тайланг энэ хуулийн 18.1-д заасан Жендэрийн үндэсний хороонд хоёр жил тутам хүргүүлж байна.	Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд дурдсанаар ЖЭТБтХ батлагдсанаас хойш өнгөрсөн 9 жилийн хугацаанд улс төрийн намуудаас хуулийн 8.2, 8.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийн тайланг ЖҮХ-нд огт ирүүлээгүй байна.

Зарим талаар хэрэгжихгүй байгаа заалтууд:

Хүснэгт 1.12. Зарим талаар хэрэгжихгүй байгаа заалтууд

	Хуулийн заалт	Огт хэрэгжихгүй байгаа тухай тайлбар		
1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль				
1	8.3. Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна.	Чанарын судалгаанд оролцогчдын мэдээллээс үзэхэд Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд 25 хувьд бараг хүрдэггүй байна.		
2	10.1.1. Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх ²⁴	<ul style="list-style-type: none"> - Яамны сайд нар (28%) Аймаг, нийслэлийн засаг даргын орлогч (18.1%), Дүүргийн ИТХ-ын дарга (22.3%), Дүүргийн Засаг даргын орлогчийн түвшинд (33.3%) хуульд заасан квот хангагдсан. - УИХ-ын гишүүд (17.1%), Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга (9%), Дүүргийн Засаг дарга (11.2%) –ын албан тушаалд хуульд заасан квотод хүрээгүй. - Дэд сайд, Аймаг нийслэлийн Засаг дарга нарын дотор эмэгтэй хүн байхгүй байна. 		
3	10.1.2. Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;	ТЗ-ны албан тушаал	Хуульд заасан квот	Хүрсэн түвшин
		Яамдын Төрийн нарийн бичгийн дарга	15%	7.1%
		Засгийн газрын агентлагийн дарга	15%	8.3%
		Аймаг нийслэлийн ИТХ-ын НБ дарга	Квотгүй	22.7%
		Дүүргийн ИТХ-ын НБД		22.2%
		Сумын ИТХ-ын НБД		60.6%
		Аймаг нийслэлийн ЗДТГ-ын дарга	40%	18.2%
		Дүүргийн ЗДТГ-ын дарга	40%	11.1%
		Сумын ЗДТГ-ын дарга	40%	47.6%
2. Улс төрийн намын тухай хууль				

²⁴ Суманд томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны доторх аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна гэсэн квотыг хангасангүй. Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч нарын бүх түвшинд хуульд заасан квот хангагдсангүй. Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 2021 он.

<p>3.3. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу аль нэг намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд иргэнийг мөшгөн хавчих, заналхийх, гүтгэх, доромжлох, дарамтлахыг хориглоно.</p>	<p>Улс төрийн намын харьяаллаар эсвэл өмнө нь намын гишүүн байсных нь төлөө ялгаварлан гадуурхах, албан тушаалаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэхгүй байх, заналхийлэх, доромжлох байдал түгээмэл байгааг чанарын судалгаанд оролцогчдын мэдээлэлээс харж болно²⁵.</p>
<p>3.5. Намд албадан элсүүлэх болон намаас гарахыг шаардах, шахалт үзүүлэхийг хориглоно.</p>	<ul style="list-style-type: none"> - Ямар нэгэн албан тушаалд томилогдоход заввал намын гишүүн байх шаардлага тавьдаг, эсвэл гишүүнээр элсүүлдэг тухай мэдээллийг чанарын судалгаанд оролцогчид мэдээлж байна. - Намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход маш их ялгаварлан гадуурхалт байна. - Улс төрийн намуудын сонгуульд нэр дэвшигчидэд тавьдаг “дэнчин” мөнгөний хэмжээ нь хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхах үндэс болж байна.
<p>7.1. Намын зүгээс төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцохыг хориглоно.</p>	<p>Чанарын судалгааны мэдээллээс үзэхэд энэ заалт зөрчигдөх байдал түгээмэл байна.</p>
<p>3. Төрийн албаны тухай хууль</p>	
<p>31.4. Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, орьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Улс төрийн намын харьяаллаар эсвэл өмнө нь намын гишүүн байсных нь төлөө ялгаварлан гадуурхаж, албан тушаалаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэхгүй байх, заналхийлэх, доромжлох байдал түгээмэл байгааг чанарын судалгаанд оролцогчдын мэдээлэлээс харж болно²⁶. - 2020 онд Төрийн албаны зөвлөлд төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн болон цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар иргэд, байгууллага, төрийн албан хаагчдаас нийт 445 өргөдөл, гомдол, мэдээллийг ирүүлжээ. Хүлээн авсан гомдол, мэдээллийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал, 22 нэгжээр буюу 5.2 хувиар өссөн²⁷ тухай Төрийн албаны зөвлөлийн тайланд дурджээ. Энд улс төрийн намын харьяаллаар ажил албан тушаалаас халагдсан тухай нарийвчилсан мэдээлэл байхгүй байгаа боловч, төрийн албаны халаа сэлгээ УИХ-ын сонгуулийн жилүүдэд нэмэгдсэн байдаг. - Энэ тухай “Улс төрийн намаас түдгэлзсэн ч урьд нь гишүүнчлэлтэй байсан намын болон улс төрчдийн оролцоотойгоор төрийн жинхэнэ албанд томилогдон хууль зөрчиж болдог гэдэг хуучин ойлголтоосоо салаагүй байгаагаас, хууль зөрчих үйлдлийг санаатай гаргаж байна” хэмээн Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланд дурджээ.

²⁵ Гэвч энэ асуудлаар ямар нэгэн байдлаар гомдол гаргадаггүй байна.

²⁶ Гэвч энэ асуудлаар ямар нэгэн байдлаар гомдол гаргадаггүй байна.

²⁷ Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

Өөрчлөх шаардлагатай заалт:

Хүснэгт 1.13. Өөрчлөх шаардлагатай болон нэмж оруулах заалтууд

Хуулийн заалт	Одоо байгаа	Өөрчлөх буюу нэмэлт оруулах санал
1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)		
8 дугаар зүйлийн 8.2. дахь хэсэг	Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.	Бүх шатны сонгуульд намаас нэр дэвшсэн эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг тодорхой хувиар нэмж олгох.
8 дугаар зүйлийн 8.3.	Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна	Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна
10 дугаар зүйлийн 10.1.1	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх;	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газарт 25, аймаг, нийслэл, сум, дүүрэгт 40 хувиас, хороонд 50 хувиас доошгүй байх;
10 дугаар зүйлийн 10.1.2	Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;	Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 30 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 30 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 50 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 50 хувиас доошгүй байх;
Нэмж оруулах шаардлагатай заалт		
1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)		
Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга нарын 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар нэмж оруулах		
2. УИХ-ын сонгуулийн тухай хууль (2019)		
30 дугаар зүйлийн 30.2	...нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.	...нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 30-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
3. Улс төрийн намын тухай хууль (2005)		
11 дүгээр зүйлийн 11.2.8	Сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах зарчим баримтлах	намын зохион байгуулалтын аливаа удирдах байгууллагад сонгогдох аль нэг хүйсийн төлөөлөл 50 хувь байх зарчмыг баримтлах
4. Төрийн албаны тухай хууль		
68 дугаар зүйлийн 68.1	Зөвлөлийн гишүүн. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны таван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.	Зөвлөлийн гишүүн. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны таван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд энэ хуулийн 68.1-д заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.
5. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль		
4 дүгээр зүйлийн 4.1.	4.1. Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны, долоо нь орон тооны бус байна.	4.1. Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны, долоо нь орон тооны бус байна. Хорооны гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд энэ хуулийн 4.1-д заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮД

“Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр” (1996)

1995 онд Бээжин хотноо болсон дэлхийн эмэгтэйчүүдийн асуудлаарх НҮБ-ын IY бага хуралд эмэгтэй удирдагчид эрх тэгш байдал, хөгжил энх тайвны төлөөх “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийг баталсан. Монгол Улс 1996 онд “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлээд 2002 онд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг баталснаар эмэгтэйчүүдэд чиглэсэн цогц бодлого дахин батлагдаагүй байна.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах Дунд хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө” (2013-2016)

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах Дунд хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг 2013 оны 1 сарын 26-ны өдөр баталжээ.

Энэхүү стратегийн гол зорилгууд нь: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хуулийг хэрэгжүүлэх салбарын болон орон нутгийн чадавхыг бүрдүүлэх, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бүх түвшний бодлого, үйл явцад нэвтрүүлэх, хуулийн хэрэгжилтэд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн олон талт оролцоог хангах, нөөц бололцоо, санхүүжилтийн тогтвортой байдлыг бий болгох, олон улсын хамтын ажиллагааг уялдуулахад оршино²⁸.

Дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр

зорилтын хүрээнд хүлээгдэж буй үр дүнг зорилт тус бүрээр тодорхойлж, 2013-2016 оны хооронд хэрэгжүүлэх үүрэг хүлээн ажиллах, тэргүүлэн гүйцэтгэгч талуудыг сонгон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгажээ.

“Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (2000)

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 1995 онд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн олон улсын дөрөв дүгээр бага хурлын дараагаар Бээжингийн тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөрийн үзэл санааг үндэсний онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас баталсан.

Энэхүү хөтөлбөр нь 2002 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” болон шинэчлэгдсэн байна.

Хөтөлбөрт “улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангахад тохиолдож байгаа бэрхшээлийг арилгах, тэдний идэвхтэй хамтын оролцоотойгоор хөгжилд хүрэх, юуны өмнө нийгмийн анхдагч нэгж болох гэр бүлийн хөгжлийг дэмжих, шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангахыг эн тэргүүнд чухалчлахыг зорилт болгоно” гэж тодорхойлсон байдаг.

Хөтөлбөрт бүх шатны шийдвэр гаргах үйл явцад жендэрийн эрх тэгш байдлыг хангах явдлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн нэг байна гэж тодорхойлжээ.

Хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дараах салбаруудад хэрэгжүүлэх нийт 15 зорилтыг хангахад чиглэгдсэн юм. Эдгээрийг багцлан үзүүлбэл:

²⁸ МУЗГ, 2013 оны 1 сарын 26-ны 34 дүгээр тогтоол



“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008-2021)

Монгол Улсын Их Хурал 2005 онд Мянганы хөгжлийн зорилтуудыг дэмжин баталснаар, жендэрийн холбогдолтой зорилтуудыг хөдөлмөр эрхлэлт, боловсрол, улс төрийн оролцоо, эрүүл мэндийн салбарт дэвшүүлэн тавьсан. “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”(2008-2021)-ыг 2008 онд батлан, эдгээр үүрэг амлалтуудыг дахин бататгаж, хүйсийн эрх тэгш байдлыг хангах тусгай хууль боловсруулахыг стратегийн зорилтоо болгон тодорхойлжээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт энэ баримт бичигт дараах байдлаар тусгалаа олсон байдаг. Тухайлбал Жендэрийн тэгш байдлыг гэр бүл, эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, хүний эрхийн хүрээнд хангах бодлогыг хэрэгжүүлэх стратегийн зорилт 1-д жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан төлөвшүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг төрийн бодлого, хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж, бие даасан хуультай болох, бүх шатны боловсролын хөтөлбөрийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох, өмчийн болон хөдөлмөрийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийг адил, тэгш оролцуулах соёлыг хэвшүүлэх, удирдах, шийдвэр гаргах түвшинд

жендэрийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх заалтуудыг оруулжээ²⁹.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр³⁰”

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтлах”, “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангах” зорилтуудыг дэвшүүлжээ.

Холбогдох бусад бодлогын баримт бичгүүд:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний Хөтөлбөр (2005-2015)
- Хүүхэд эмэгтэйчүүдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгт өртөхөөс сэргийлэх Үндэсний хөтөлбөр (2005-2014)
- Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө (2012-2016)
- Эрүүл мэндийн салбарын Мастер төлөвлөгөө (2005-2015)
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 3 дахь хөтөлбөр (2007-2011)

²⁹ Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого. УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол 2008-01-31.

³⁰ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр. УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол 2020-08-28.

- Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого (2004-2015)
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах Үндэсний стратеги (2014-2018)
- Ядуурлыг бууруулж, ажил эрхлэлтийг дэмжих бодлого (2010-2014)
- Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого (2011-2015)
- Боловсролыг хөгжүүлэх бодлого (2009-2013)
- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого (2012-2016)
- Нийгмийн халамж, хөдөлмөрийн бодлого (2011-2015)
- Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлого, Улсын төсвийн бодлого (2013- 2014)
- Хот төлөвлөлт, барилгын хөгжлийн бодлого (2013-2014)

Улс төрийн намуудын дүрэмд хүйсийн квотыг тусгасан байдал

Монгол Улс 1990 онд олон намын тогтолцоонд шилжсэнээс хойш улс төрийн олон нам байгуулагдаж, нэгдэж, тарж явсаар өнөөдрийн байдлаар Дээд Шүүхэд улс төрийн 35³¹ нам бүртгэлтэй байна.

2021 оны байдлаар Монгол Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намуудын дотор эмэгтэй хүн даргалж байгаа 1 нам бүртгэлтэй байна³².

Монгол Ардын Нам (МАН) Монголын улс төрийн ууган хүчин болох Монгол Ардын Нам нь Монгол Улсын тусгаар тогтнол-эрх чөлөө-шударга ёс-эв нэгдэл-үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн нийгмийн ардчиллын (социал демократ) үзэл баримтлал бүхий нам.

Монгол Ардын Намын үндсэн дүрэм³³ нь 13 бүлэг 46 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйл Монгол Ардын Намын зорилго, үйл

ажиллагааны нийтлэг зарчмын 1.5.8³⁴ дахь хэсэгт намын бүх шатны сонгуульд байгууллагад 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Санал хураалтыг энэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулна³⁵ хэмээн заажээ.

Монгол Ардын Намын үндсэн дүрмийн 36 дугаар зүйлд намаас УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдэд тавих нийтлэг шаардлагад “намаас сонгуульд нэр дэвшигчид тавих шалгуур болон бусад асуудлыг Бага хурлаас баталсан журмыг баримтлан шийдвэрлэнэ” хэмээн заажээ³⁶.

Түүнчлэн уг дүрмийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт НАШБ нь Ерөнхийлөгчийн, УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвших боломжтой гишүүнийг намын Бага хурлаас баталсан журмын дагуу намын гишүүд, гишүүн бус иргэдийн өргөн оролцоотой чөлөөт, ардчилсан, шударга өрсөлдөөнт хэлэлцүүлгийн үндсэн дээр тодруулна хэмээн заажээ.

“Ардчилсан нам” (АН) Ардчилсан нам нь Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульд ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн нам байна хэмээн дүрмэндээ заасан байна.

Ардчилсан намын дүрэм нь 9 бүлэгтэй бөгөөд 5 дугаар бүлгийн 5.10,11.3 дахь хэсэгт “Тухайн шатны ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг батлах хэсэг”-т “нийт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна” хэмээн заажээ.

Түүнчлэн 5 дугаар бүлгийн 5.9.5 дахь хэсэгт Намын анхан шатны байгууллагын тэргүүлэгчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна гэж тус тус заасан байна.

³¹ Улс төрийн намуудын бүртгэл. Улсын Дээд Шүүх. <http://www.supremecourt.mn/nam> 2021 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

³² <http://www.supremecourt.mn/nam/10> Монголын эмэгтэйчүүдийн нам

³³ Монгол Ардын Намын XXVIII Их хурлын 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 10 тоот Тогтоолоор батлагдсан.

³⁴ Монгол Ардын Намын үндсэн дүрэм . 1.5.8

³⁵ Монгол Ардын Намын үндсэн дүрэм . 1.5.8

³⁶ МАН-ын үндсэн зүрэм. 36 дугаар зүйлийн 36.2

Хүснэгт 1.14. Улс төрийн намуудын дүрэмд хүйсийн квотыг тусгасан байдал

Нам	Хүйсийн квот тусгасан заалт
МАН	1.5.8. намын бүх шатны сонгуульд байгууллагад 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Санал хураалтыг энэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулна.
АН	5.10.11.3. “Тухайн шатны ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг батлах; “Нийт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.
	5.9.5-д Намын анхан шатны байгууллагын тэргүүлэгчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.
	6.4.1. УБХ-ны гишүүний суудлын тоо 410 байна. Үүнээс 90-ээс доошгүй суудал нь эмэгтэй гишүүдэд ноогдоно.
ХҮН	4-р бүлэг: Намын их хурлын төлөөлөгчдийг сонгохдоо 30-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүн байх зарчмыг баримтална.
ИЗНН	20.4 Үндэсний хорооны нийт гишүүдийн 30-аас доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөлөл /суудал хадгалах квот/ бүрдүүлнэ. Энэ заалт Улс төрийн зөвлөлийг сонгож бүрдүүлэхэд нэг адил хамаарна.
МҮАН	9.2.10 Сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгохдоо хүйсийн тэгш байдлыг хангах зарчмыг баримтална.

Улс төрийн намууд эмэгтэйчүүдийг УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвших, сонгогдоход дэмжлэг үзүүлэх гол субъект боловч энэ үүргээ хангалтгүй биелүүлж байгаа төдийгүй энэ талаар илүү их хүчин чармайлт, санаачилга гаргах хэрэгтэй гэдэгтэй олон нийт санал нэг байна. 2017 онд БХОУХ-ээс хийсэн судалгаагаар “Эмэгтэйчүүдийг улс төрийн удирдлагын түвшинд гаргахын тулд намууд илүү ихийг хийх ёстой” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 66 хувь нь, “Эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх, томилох талаар намууд илүү ихийг хийх

ёстой” гэдэгтэй 65 хувь нь санал нийлсэн байна³⁷.

Цаашид улс төрийн намын бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох, ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, улс төрийн намын дүрэмд намын өөрийн аливаа удирдах байгууллагад эмэгтэйчүүдийн суудал хадгалах квотыг 50 хувиас доошгүйгээр тогтоож, хэрэгжүүлэх шаардлага байна.

³⁷ БНОУХ, “Олон нийтийн санаа бодлын тандалт судалгаа”, 2017

1.3. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ СУДАЛСАН БАЙДАЛ

Манай улсын эрдэмтэн судлаачид, судалгааны байгууллагууд болон ТББ-уудаас шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар нэлээдгүй судалгаа

шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэжээ. Энэхүү судалгааны ажлын хүрээнд дараах судалгааны тайлангуудад шинжилгээ, дүгнэлт хийлээ.

Хүснэгт 1.15. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог судалсан судалгааны тайлангууд

№	Судалгааны нэр	Гүйцэтгэгч	Он	Судалгааны ажлын онцлог
1	Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо: олон нийтийн санаа бодлын судалгаа	Жендэрийн Үндэсний хороо, НҮБХХ	2012	<ul style="list-style-type: none"> Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн санаа бодол, хандлагыг судалсан. Энэхүү судалгаа нь 2010 оны судалгааны үргэлжлэл болон давтамжтай хийгджээ.
2	Монгол Улс: Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдал, бодлогын зөвлөмж	Дэлхийн банк	2013	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгаатай байдлыг бусад улсуудтай харьцуулан судалж, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо болон хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн стратеги, бодлогын асуудлуудыг хөндөж, зөвлөмж боловсруулсан. Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар товч дурдаж, санал зөвлөмжид тусгасан.
3	Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа	IRIM судалгааны хүрээлэн	2014	<ul style="list-style-type: none"> Монгол дахь жендэрийн эрх тэгш байдлын бодлого, эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдал, Монгол улсын эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, үйлчилгээ, эрх мэдлийн хуваарилалт, хүртээмжийн хувьд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд, охид болон хөвгүүдийн хооронд оршин буй ялгаа буюу жендэрийн тэнцвэргүй харьцааг баримт бичигт үндэслэн тодорхойлж, судалсан. Тайлангийн “Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо, боломж” гэсэн 3.2 дахь хэсэгт парламент, орон нутгийн төлөөллийн байгууллага болон төрийн албан дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаар статистик мэдээлэлд үндэслэн дүнэлт гаргаж, харин сонгуульд өрсөлдөж буй эмэгтэйчүүдийн талаарх олон нийтийн санаа бодлыг өмнө хийгдсэн судалгаануудад үндэслэн дүгнэжээ.
4	Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж	Монгол улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо	2019	<ul style="list-style-type: none"> Тайланд 2005 оноос хойш Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр гаргасан ололт амжилт, сургамжийг нэгтгэн дүгнэж, эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хамтын ажиллагааны чиглэл, цар хүрээг тодорхойлон, зөвлөмж гаргажээ. “Нийгмийн хөгжил ба жендэр” хэмээх 2 дугаар бүлгийн “Улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн манлайлал” гэсэн хэсэгт шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн асуудлыг авч үзсэн байна.

5	Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо	ҮСХ	2019	<ul style="list-style-type: none"> Төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдын тоон мэдээллийг хүйс, албан тушаал, төв болон орон нутгийн төрийн байгууллагын түвшнээр, байгууллагын ангиллаар харьцуулан шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо ямар байгааг гаргасан бөгөөд ямар нэгэн дүгнэлт, санал, зөвлөмж өгөөгүй.
6	“Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015-2019 он”	Монголын Эмэгтэйчүүдийн сан	2020	<ul style="list-style-type: none"> Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийг үнэлэх альтернатив илтгэл боловсруулах суурь судалгаа Тус судалгааг жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн улс төр дэх болон шийдвэр гаргах түвшний оролцоо, хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн асуудлууд,эрүүл мэнд, боловсрол, гэрлэлт, гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дахь эмэгтэйчүүдийн эрх,жендэрийн тэгш байдлын талаарх өнөөгийн нөхцөл байдал,статусыг тодорхойлох,э рхийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах зорилгын хүрээнд хийсэн байна. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог бүлгийн эрхийн хүрээнд авч үзсэн.
7	Залуучуудын санал бодлын судалгаа	IRIM судалгааны хүрээлэн	2020	<ul style="list-style-type: none"> Нийгмийн тулгамдсан асуудал,ардчилал,улс төрийн институт,засаглал,улс төр дэх эмэгтэйчүүд,залуучуудын оролцооны талаар залуучуудын санаа бодлыг тандах зорилгоор уг судалгааг хийжээ. Судалгааны үр дүнг иргэдийн хэрэгцээ шаардлагыг улс төрийн яриа хэлэлцүүлэгт тусгах,хүрээлэнгийн төсөл хөтөлбөрийг удирдан чиглүүлэхэд ашиглах зорилгоор хийдэг байна.
8	Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс	Судлаач Л.Бямбаханд	2020	<ul style="list-style-type: none"> Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, гадаад орнуудын туршлагыг судлах,санал, зөвлөмж боловсруулах зорилгоор хийсэн судалгааны ажил юм. Уг судалгаанд бусад орны туршлага, Монгол Улс дахь нөхцөл байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны нийгэмд үзүүлэх нөлөө,оролцоог хязгаарлаж буй хүчин зүйлсийг нэлээд өргөн хүрээнд судалсан байна.
9	Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	ЖҮХ,НҮБ-ын Хүн амын сан, “Эм Эм Си Жи” ХХК	2020	<ul style="list-style-type: none"> Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны захиалгаар судалгаа,зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн. Тайлангийн “Төрийн байгуулал,эдийн засаг,нийгэм, соёлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлын баталгааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” гэсэн 2 дугаар хэсэгт улс төрийн хүрээ болон төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа, түүний хэрэгжилтэд шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулжээ.
10	Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл	Цогц Хөгжлийн Үндэсний Төв ТББ	2021	<ul style="list-style-type: none"> Уг судалгааг залуу болон эмэгтэй улс төрчдөд тулгамдаж буй сорилт бэрхшээлүүдийг хувь хүн, институт, нийгэм соёлын хүчин зүйл тус бүрээр судлах, УИХ, орон нутгийн сонгуульд тэдний нэр дэвших боломж, сонгогдсон байдал, төрийн захиргааны удирдах албан тушаалд эзлэх хувь, залуу болон эмэгтэй улс төрчдөд тулгамддаг асуудлуудад нийтийн анхаарлыг хандуулах зорилгын хүрээнд хийж гүйцэтгэсэн байна.

Судалгаа тус бүр өөрийн зорилго, зорилтуудын хүрээнд хийгдсэн онцлогтой байна. Судалгаа тус бүрийг тоймлон авч үзвэл:

1. Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Олон нийтийн санаа бодлын судалгаа (2012):

Уг судалгааг Жендэрийн үндэсний хороо НҮБХХ-ны дэмжлэгтэйгээр хийсэн. Судалгаанд 1014 хүн хамрагджээ. Судалгаагаар улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөлд олон нийтийн хандах хандлагыг судлахад эерэг хандлагын хувь өссөн үр дүн гарсан байна. Гэхдээ эмэгтэй улс төрчдийг олон нийт хүлээн зөвшөөрч байгаа ч УИХ-ын гишүүнээр олон удаа сонгогдсон, төрийн алба хашдаг, ИНБ, иргэдийн хөдөлгөөнд манлайлан оролцдог эмэгтэйчүүдээр л улс төр дэх эмэгтэйчүүдийн тухай төсөөлөл хязгаарлагдаж байгаа үр дүн гарчээ. Эмэгтэй улс төрчдийн олон нийтэд танигдаагүй энэ байдал нь сонгогчид эмэгтэйчүүдийг дэмжиж саналаа өгөхөд сөргөөр нөлөөлж байна хэмээн дүгнэсэн.

Судалгааны үр дүнд эмэгтэйчүүдийн төлөөлөл хууль тогтоох байгууллагад хангалтгүй байгаа шалтгааныг олон нийт дараах шалтгаануудтай холбон үзэж байна гэжээ. Үүнд:



Судалгаанд үндэслэн Жендэрийн Үндэсний хороо, улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага, эмэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд тус бүрд нь зөвлөмж гаргасан байна.

2. Монгол Улс: Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдал, бодлогын зөвлөмж (2013):

Хөдөлмөрийн зах зээл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоо, тэдний цалин хөлсний болон ажил мэргэжлийн ялгарал их, мөн дээд түвшний удирдах албан тушаалд болон аж ахуй эрхлэх ажилд эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн, хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад гэр орны болон асран сувилах үүрэг хариуцлагын дийлэнхийг мөн үүрч байгааг судалгаанд дурдсан байна. Мөн Монгол Улсад улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо маш муу байгааг дүгнэн бичжээ. Уг бодлогын баримт бичгийн зөвлөмжид шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаа, эмэгтэйчүүд удирдах албан тушаалд хүрэхэд саад болж байгаа асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэжээ. Энэхүү тайланд улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээнд жендэрийн тэгш бус байдал байгааг хөндөж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар бодлогын зөвлөмжид тусгаснаараа онцлогтой байна.

3. Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: (Нөхцөл байдлын товч үнэлгээ-Баримт бичгийн судалгаа):

Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжсэн “Монгол Улс дахь жендэрийн тэгш байдлын талаарх үзэл хандлага: Олон нийтийн тандалтын судалгаа”-ны төслийн нэг хэсэг болох “Монгол Улс дахь жендэрийн тулгамдсан асуудлууд: Баримт бичгийн судалгаа”-г IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэсэн байна. Уг судалгаагаар жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, эрх зүйн орчны шинжилгээ, жендэрийн нөхцөл байдлын шинжилгээг улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн салбар тус бүрээр гаргаж, дүгнэлт гарган салбарын бодлого, хөтөлбөрт жендэрийн үзэл баримтлалыг тусгах санал дэвшүүлсэн байна. Энэхүү судалгааны тайланд ашигласан, иш татсан материалуудад дараа дараагийн судлаачдад хэрэг болохуйц эх сурвалжууд багтсан нь ололттой тал байв.

4. Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж (2019):

Уг тайланг Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлсэн “Салбар орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа” техникийн туслалцааны төслийн хүрээнд боловсруулсан байна. Тайланд эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил, байгаль орчны хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах талаар арга хэмжээг дүгнэн, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой зөвлөмж өгчээ.

5. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо (2019):

Тайланд УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн, сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг статистик мэдээлэлд үндэслэн гаргасан бөгөөд ямар нэгэн дүгнэлт, зөвлөмж өгөөгүй байна.

6. “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015–2019 он” судалгааны тайлан (2020):

Уг судалгааг Women’s Fund Asia (Азийн эмэгтэйчүүдийн сан) байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Монгол Улсад Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын Конвенцийн (ЭАБХУТК) хэрэгжилтийг хангах зорилгоор оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Монголын Эмэгтэйчүүдийн Сан ТББ-аас зохион байгуулж, Иргэний нийгмийн байгууллагын судлаачид гүйцэтгэсэн байна.

Уг судалгааны тайланд дараах агуулгаар судалгаа хийж, үр дүнг нэгтгэн зөвлөмж боловсруулжээ. Үүнд:

- Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ;
- Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, сайжруулах үндэсний тогтолцооны шинжилгээ;
- Бодлогын орчны шинжилгээ: дэмжиж буй болон дэмжихгүй байгаа зохицуулалтууд;

- Асуудал үүсэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн шинжилгээ;
- 2015- 2019 онд Монгол улсын Засгийн газраас шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны судалгаа;
- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий бодлогын хэрэгжилтэд тулгамдаж байгаа бэрхшээл, цаашид авах арга хэмжээ;
- Улс төрийн намын хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудал болон шийдэл;
- Эмэгтэйчүүдэд шаардлагатай байгаа дэмжлэгүүдийг тодорхойлох;

Асуудал үүсэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг соёл уламжлал, бодлогын орчин, улс төрийн намын дотоод зохион байгуулалт, нийгмийн хүчин зүйлс, эдийн засгийн хүчин зүйлсийн хүрээнд тодорхойлон, эрх зүйн зохицуулалтын хүрээнд дэмжиж байгаа болон дэмжихгүй байгаа зохицуулалтыг судлан тодорхойлсон.

7. Залуучуудын санал бодлын судалгаа (2020):

Энэхүү судалгааг Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (БНОУХ)-гийн Асуулга судалгааны төвийг төлөөлөн хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)-гээс гүйцэтгэсэн байна. БНОУХ-гийн Азийн бүсийн захирал Жоанна Као “Монголчууд цар тахал, ажилгүйдлийн талаар зовниж буй энэ үед иргэдийн хэрэгцээ, шаардлагыг бодлогод тусгахын тулд улс төрчид иргэдийн бүх төлөөллийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах нь чухал юм” гэсэн байна.

Энэхүү санал асуулгад Монгол Улсын 18-40 насны нийт 2494 иргэнийг түүврийн аргаар сонгон хамруулжээ. Асуулгаар улс төрийн институц, засаглал, залуучууд болон эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, сонгууль болон улс төрийн намууд, ардчиллын хөгжил, авлига, гадаад бодлого, хэвлэл мэдээллийн асуудлаар залуучуудын санаа бодлыг судалсан байна. Судалгаанд оролцогчид сонгуульд албан тушаалд өрсөлдөж байгаа эмэгтэйчүүдийн тоо цөөн байгаа шалтгааныг тодорхойлохдоо ар гэрийн ажил их, тэднийг

дэмжих танил танилын хүрээ бага, гэр бүлийн болон улс төрийн намын дэмжлэг муу, эмэгтэйчүүд улс төрд орох зориг дутдаг, сонгуульд өрсөлдсөнөөр хүчирхийлэлд өртөхөөс эмээдэг гэсэн хариултыг дийлэнх нь сонгожээ. Аливаа улс ардчиллыг бий болгоход нөлөөлдөг чухал элементүүдээс “улс төрийн шийдвэр гаргалтад эмэгтэйчүүд оролцдог байх” нь маш чухал гэж 63 хувь нь үзжээ. Судалгаанд үндэслэн дүгнэлт, зөвлөмж гаргаагүй байна.

8. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс (2020):

Монгол дахь Конрад-Аденауэр-Сан болон МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим хамтран 2017 оноос хойш жил бүр төрийн бодлогын экспертийн зөвлөлийн арга зүйн нэгдсэн удирдлага дор зохион байгуулж байна. Энэхүү ээлжит бодлогын судалгаа нь 2020 онд “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд хийгдсэн. Үүний дэд хэсгийн нэг нь судлаач Л.Бямбахандын “Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс” сэдвээр хийсэн судалгаа юм. Уг судалгаанд олон улсын туршлага, монгол дахь өнөөгийн нөхцөл байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны нийгэмд үзүүлэх нөлөө зэргийг баримт бичгийн судалгаагаар тодруулж, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог хязгаарлаж буй хүчин зүйлсийг асуулга, ярилцлагын аргаар судалж дүгнэлт, зөвлөмж боловсруулсан байна.

9. Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (2021):

Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба (ЖҮХАА)-ны захиалгаар судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” ХХК Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний хүрээнд энэхүү томоохон судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна. Тайлангийн “Төрийн байгуулал, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлын баталгааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” гэсэн 2 дугаар бүлэгт улс төрийн хүрээнд дэх болон төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааны талаар судалж, энэ чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгсөн.

10. Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл. Судалгааны тайлан (2021):

Уг судалгаанд УИХ, орон нутгийн сонгуульд залуучууд, эмэгтэйчүүдийн нэр дэвших боломжийн талаарх бодлого, эрх зүйн орчин, сонгогдсон байдал, төрийн захиргааны удирдах албан тушаалд эзлэх хувь, залуу болон эмэгтэй улс төрчдөд тулгамддаг асуудлуудыг судлан, эдгээрт олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгын хүрээнд хийж гүйцэтгэсэн байна. Судалгааны хүрээнд баримт бичгийн болон ярилцлагын судалгаа хийсэн. Судалгааны ажлын онцлог нь улс төр дэх залуучууд, эмэгтэйчүүдэд нөлөөлж буй улс төрийн институтийн, хувь хүний, нийгэм соёлын хүчин зүйлсийг тус бүрд нь судлан, дүгнэлт гаргасан байна.

Дээр дурдсан судалгааны тайлангаас гадна шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны асуудлыг хэлэлцсэн удаа дараагийн хурал, чуулганд тавигдсан илтгэл, хэвлэл мэдээллээр нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлүүд нэлээдгүй байна.

Хүснэгт 1.16. Судалгааны тайлангуудын агуулга, бүтцийн судалгаа

№	Судалгааны нэр	Баримт бичгийн судалгаа					Статистик тоон мэдээлэлд боловсруулалт, дүгнэлт хийсэн	Асуулга, ярилцлагын судалгаа, үр дүн	Дүгнэлт, зөвлөмж
		Бодлого, эрх зүйн орчны шинжилгээ	Сонгуулийн тогтолцооны давуу, сул тал	УГН-ын баримталж буй бодлого, үйл ажиллагаа	ОУ-ын туршлага				
1	Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Олон нийтийн санаа бодлын судалгаа. НҮБХХ, Жендэрийн Үндэсний хороо. 2012 он	X	X	✓	X	X	✓	✓	
2	Монгол улс: Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдал, бодлогын зөвлөмж. Дэлхийн банк. 2013 он	X	X	X	✓	✓	✓	✓	
3	Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа. IRIM судалгааны хүрээлэн. 2014 он	✓	X	X	X	✓	X	✓	
4	Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж. 2019 он	✓	X	X	X	✓	X	✓	
5	Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо. ҮСХ. 2019 он	X	X	X	X	✓	✓	X	
6	“Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015 – 2019 он” судалгааны тайлан. Монголын Эмэгтэйчүүдийн сан. 2020 он	✓	X	✓	X	X	✓	✓	
7	Залуучуудын санал бодлын судалгаа. IRIM. 2020 он	✓	X	✓	X	✓	✓	X	
8	“Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс” судалгааны тайлан Судлаач Л.Бямбаханд. 2020 он	✓	X	X	✓	✓	✓	✓	
9	Монгол улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. ЖҮХ, НҮБ-ын Хүн амын сан, “Эм Эм Си Жи” ХХК. 2020 он	✓	✓	✓		✓		✓	
10	Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл. Судалгааны тайлан. Цогц Хөгжлийн Үндэсний Төв ТББ. 2021 он	✓	✓	✓	X	✓	✓		

✓ судалсан
X судлаагүй

Дээр дурдсан судалгааны тайлангуудыг нэгтгэн авч үзвэл дараах нийтлэг зөвлөмжүүдийг санал болгосон байна. Үүнд:

1. Хууль, эрх зүй бодлогын орчныг сайжруулах чиглэлээр:
 - a. Ажлын байранд эмэгтэйчүүдийн квот хадгалах, эрэгтэйжсэн улс төрийн бүтцийг халахад нэр дэвшигчийн квотоос гадна суудал хадгалах квотыг хуульчлах³⁸
 - b. УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь өөр хүйсийн нэр дэвшигч байх хязгаарыг 40 хувь болгох³⁹.
 - c. Улс төрийн намын тухай хуульд жендэртэй холбоотой бүлэг заалтыг тусгах⁴⁰;
 - d. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хуулийг олон нийтэд сурталчлах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, үүний тулд санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, Жендэрийн хуулийн холбогдох зүйл заалтуудыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд байгууллагуудад урамшуулал олгох системийг боловсруулах⁴¹.
 - e. Төрийн албаны тухай хууль, төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын зэрэг журамд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх асуудлыг тусгах⁴²
2. Улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагуудын үйл ажиллагаанд санал болгох чиглэлээр:
 - a. Эрэгтэйчүүдтэй өрсөлдөх стратеги, тактик боловсруулж хэрэгжүүлэх⁴³,
 - b. Эмэгтэйчүүдийг дэмжих нөлөөллийн ажил зохион байгуулах⁴⁴,
 - c. Намын удирдлагад квот тогтоох, сонгуулийн хуулийн квотын хэрэгжүүлэх талаар нам дотроо нөлөөллийн ажил хийх, шийдвэр гаргуулах⁴⁵.
3. Эмэгтэйчүүдийг чадавхжуулах, сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр
 - a. Улс төрийн намууд, төрийн алба, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагууд залуу манлайлагч эмэгтэйчүүдийг бэлтгэх сургалтын байнгын тогтолцоо бүрдүүлж, дагалдуулан сургах (менторшип) хөтөлбөрийг хэрэгжүүлэх⁴⁶.
 - b. Эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалтын тусгай хөтөлбөр боловсруулан, байнгын тасралтгүй сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах⁴⁷;
 - c. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, сэтгүүлчдийн мэргэшсэн баг бий болгох⁴⁸

³⁸ Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Олон нийтийн санаа бодлын судалгаа. НҮБХХ, Жендэрийн Үндэсний хороо. 2012 он

³⁹ Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж. 2019 он

⁴⁰ “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015-2019 он” судалгааны тайлан. Монголын Эмэгтэйчүүдийн сан. 2020 он

⁴¹ Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа. IRIM судалгааны хүрээлэн. 2014 он

⁴² Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. ЖҮХ, НҮБ-ын Хүн амын сан, “Эм Эм Си Жи” ХХК. 2020 он

⁴³ Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Олон нийтийн санаа бодлын судалгаа. НҮБХХ, Жендэрийн Үндэсний хороо. 2012 он¹

⁴⁴ Мөн тэнд

⁴⁵ Мөн тэнд

⁴⁶ Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж. 2019 он

⁴⁷ “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015-2019 он” судалгааны тайлан. Монголын Эмэгтэйчүүдийн сан. 2020 он

⁴⁸ Мөн тэнд

d. Сонгогчдод хандсан нөлөөлөл сурталчилгааны ажил зохион байгуулах⁴⁹, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх эерэг хандлагыг төлөвшүүлэх⁵⁰.

Дээрх дурдсан судалгааны тайлангууд, тэдгээрийн агуулга, бүтцийг (Хүснэгт 1.16) шинжлэн үзэхэд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог зохицуулсан

бодлого, эрх зүйн орчны шинжилгээг ихэнх судалгааны ажлуудад хийсэн бол олон улсын туршлага, сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын бодлого үйл ажиллагаатай холбож судалсан судалгааны ажил цөөхөн байна.

Мөн судалгааны тайлангуудад дурдсан дүгнэлт, зөвлөмжүүдийг төрийн байгууллага, улс төрийн намууд үйл ажиллагаандаа хэрхэн тусган хэрэгжүүлдэг талаар мэдээлэл байхгүй байна.

⁴⁹ Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Олон нийтийн санаа бодлын судалгаа. НҮБХХ, Жендэрийн Үндэсний хороо. 2012 он

⁵⁰ “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн нөхцөл байдал: 2015-2019 он” судалгааны тайлан. Монголын Эмэгтэйчүүдийн сан. 2020 он

2 БҮЛЭГ

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

2.1. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөллөөс үл хамааран парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин дэлхийн түүхэн дэх хамгийн дээд хэмжээ болох 25.5 хувьд хүрч байсан бол 2021 оны 6 дугаар сарын байдлаар 24.6 хувь болж буурчээ. Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувиар Руанда улс 61.6 хувьтай улс орнуудын жагсаалтыг тэргүүлж байна. Эдгээр улс орнуудын эхний 5 орон

50-аас дээш хувь, 28 орон 40-өөс дээш хувь, 59 орон 30-аас дээш хувь, 117 орон 20-оос дээш хувьтай байна. Харин Монгол Улс 2021 оны 6 сарын 1-ний байдлаар 17.3 хувьтай 193 орноос 127-д, Азийн бүсийн 30 орноос 19 дүгээр байранд эрэмбэлэгдэж байна⁵¹.

Дээрх жагсаалтын эхний 10 байрыг дараах улс орнууд тэргүүлж байна.

Хүснэгт 2.1. Хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлтээр тэргүүлж буй эхний 10 орон

№	Улс орон	Нийт суудал	Эмэгтэй суудал Хувь	Засаглалын хэлбэр	Танхим	Сонгуулийн тогтолцоо
1	Руанда	80	49	61.3	Холимог	Пропорционал
2	Куба	586	313	53.4	Нэг намын систем	Олонхын/мажоритар
3	АНЭ Улс	40	20	50	Хаант	Мэдээлэл байхгүй
4	Шинэ Зеланд	120	58	48.3	Парламент	Холимог
5	Мексик	500	241	48.2	Ерөнхийлөгч	Холимог
6	Никарагуа	91	43	47.3	Ерөнхийлөгч	Пропорционал
7	Швед	349	164	47	Парламент	Пропорционал
8	Гренада	15	7	46.7	Парламент	Олонхын/мажоритар
9	Андорра	28	13	46.4	Парламент	Холимог
10	Боливи	130	60	46.2	Ерөнхийлөгч	Холимог

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Энэхүү судалгааны ажилд улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлтийг Ази, Америк, Европ, Номхон далайн, Ойрх Дорнод

ба Хойд Африк болон Сахараас урагш Африкийн бүс гэсэн 6 бүсэд хуваасан “Олон Улсын парламентын холбоо”⁵²-ны ангилал болон “Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх

⁵¹ Олон улсын парламентын холбоо. Women in Parliament in 2020. The year in review. 2021.

⁵² <https://data.ipu.org>

Олон Улсын хүрээлэн⁵³-ийн судалгаа, мэдээлэлд үндэслэн авч үзэв.

Бүс нутгийн дунджаар Европын бүсийн орнуудын хууль тогтоох байгууллага дахь

эмэгтэйчүүдийн оролцооны дундаж хамгийн өндөр буюу 29.7 хувьтай байгаа бол Номхон далайн бүсийн орнууд хамгийн бага буюу 10,8 хувьтай байна.

Хүснэгт 2.2. Улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны бүсийн дундаж, тэргүүлэгч орны мэдээлэл

№	Бүс нутаг	Улс орны тоо	Дундаж хувь	Бүсийн тэргүүлэгч орон	Хувь
1	Ази бүсийн	30	20	Зүүн Тимор	38.5
2	Америк	35	26.6	Куба	53.4
3	Европ	48	29.7	Швед	47
4	Номхон далайн бүс	14	10.8	Шинэ Зеланд	48.3
5	Ойрх Дорнод ба хойд Африкийн бүс	19	17.3	АНЭУ	50
6	Сахараас урагш Африкийн бүс	47	22.7	Руанда	61.3
	Нийт	193	24.6		

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

Сонгуулийн тогтолцоог ангилах хамгийн нийтлэг арга нь сонгогчдын өгсөн саналыг нам, нэр дэвшигчийн хууль тогтоох байгууллагад авах суудлын тоонд хувь тэнцүүлэн хөрвүүлж байгаа үр дүнгээр ангилах явдал юм. Үүний дагуу сонгуулийн тогтолцоог Олонхын/мажоритар (plurality/majority), хагас хувь тэнцүүлэх (semi-proportional), хувь тэнцүүлэх (proportional-PR), холимог (mixed) хэмээн ангилдаг. Эдгээр төрлийг дэлхийн ихэнх улс орон сонгуульдаа ашиглаж байна⁵⁴.

Энэхүү судалгаанд нийт 193 улс орныг мажоритар буюу олонхын, пропорционал буюу хувь тэнцүүлэх, холимог сонгуулийн тогтолцоотой хэмээн 3 ангиллаар сүүлийн сонгуулийн мэдээгээр авч үзлээ.

Сонгуулийн тогтолцоогоор нь харвал хувь тэнцүүлэх (proportional-PR) тогтолцоог хэрэглэж буй улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 27.6 хувьтай байна.

Хүснэгт 2.3. Улс орнуудын сонгуулийн тогтолцоо ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь

№	Сонгуулийн тогтолцоо	Улс орны тоо	Дундаж хувь	Тэргүүлэгч орон	Хувь
1	Олонхи/мажоритар тогтолцоо	71**	18.5	Куба	53.4
2	Пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоо	82**	27.6	Руанда	61.3
3	Холимог тогтолцоо	29	26.1	Шинэ Зеланд	48.3
4	Бусад*	13			
	Нийт	195			

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

* Олон улсын парламентын холбооны Мэдээллийн санд өгөгдөлгүй, эсвэл мэдээлэл хаалттай, бусад сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлэгч улс орнууд.

** Мадагаскар, Конго улсууд мажоритар тогтолцоо, пропорционал тогтолцоог холимог бус зэрэгцүүлсэн хувилбараар ашигладаг тул бүртгэлд давхардаж оруулсан болно.

⁵³ <https://www.idea.int>

⁵⁴ Э.Гэрэлт-Од, Монгол Улсын Их хурлын Сонгуулийн тогтолцоо: Сонголт, Туршлага 2020 он. Улс төрийн Боловсролын академи.

Пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоо:

2021 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар дэлхий нийтэд сүүлийн сонгуульдаа пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоог ашигласан нийт 82/194 орон байна. Эдгээр 82 орны хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн дундаж нь 27.6 хувь байна. Азийн бүсийн дундаж үзүүлэлт 21.7 хувь (6 орон), Америк бүсийнх 26.7 хувь (17 орон), Европ бүсийнх 30.05 хувь (35 орон), Номхон далайн бүс нутаг 21.6 хувь (1 орон) ба Ойрх дорнод ба хойд бүс 19.9 хувь (7 орон), Сахараас урагш Африк бүс нутаг 27.9 хувь (16 орон) тус тус байна.

Холимог тогтолцоо:

2021 оны 6 дугаар сарын байдлаар сүүлийн сонгуульдаа холимог тогтолцоог ашигласан нийт 29/194 орон, тэдгээрийн эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт 26.1 хувьтай

байна. Азийн бүсийн дундаж 21.3 хувь (7 орон), Америк бүсийн дундаж 38.8 хувь (3 орон), Европ бүсийн дундаж 27.1 хувь (9 орон), Номхон далайн бүс нутгийн дундаж 48.3 хувь (1 орон) ба Ойрх дорнод ба хойд бүсийн дундаж 18.1 хувь (3 орон), Сахараас урагш Африкийн бүс нутгийн дундаж 27.3 хувь (6 орон) хувь тус тус байна.

Олонхи/мажоритар тогтолцоо:

Харин олонхын буюу мажоритар тогтолцоогоор сүүлийн сонгуулиа явуулсан нийт 71/194 орон байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн дундаж нь 18.5 хувь байна. Бүс нутгаар авч үзвэл Азийн бүс 18.9 хувь (14 орон), Америк бүс 24.1 хувь (15 орон), Европ 32.9 хувь (4 орон), Номхон далайн бүс нутагт 7.1 хувь (10 орон), Ойрх дорнод ба хойд бүс 11.1 хувь (5 орон), Сахараас урагш Африкийн бүсэд 18.4 хувь (23 орон) байна.

Хүснэгт 2.4. Улс орнуудын сонгуулийн тогтолцоо ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, бүс нутгаар

Бүсчлэл	Сонгуулийн тогтолцоо					
	Пропорционал		Олонхи- Мажоритар		Холимог	
	Улс орон	Хувь	Улс орон	Хувь	Улс орон	Хувь
Ази	6	21.7	14	18.9	7	21.3
Америк	17	26.7	15	24.1	3	38.8
Европ	35	30	4	32.9	9	27.1
Номхон далай	1	21.6	10	7.1	1	48.3
Ойрх Дорнод ба Хойд	7	19.9	5	11.1	3	18.1
Сахараас урагш	16	27.9	23	18.4	6	27.3
Нийт улс орны тоо/дундаж хувь	82	27.6	71	18.75	29	26.1

ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭР БА ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлтээр парламентын засаглалтай улс орнууд тэргүүлсээр ирсэн. Гэсэн ч Олон улсын Парламентын холбооноос коммунист системтэй улс орнуудыг (Хятад, Куба, Лаос, Ардчилсан Солонгос) тусгайлан авч үзсэнээр

2021 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар коммунист системтэй улс орнуудын дундаж хамгийн өндөр буюу 29.6 хувь, парламентын засаглалтай улс орнуудын дундаж 26.2 хувь, хаант засаглалтай улс орнуудын дундаж хамгийн бага буюу 14.2 хувьтай байна.

Хүснэгт. 2.5. Улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт засаглалын хэлбэрээр

№	Засаглалын хэлбэр	Улс орны тоо	Дундаж хувь	Тэргүүлэгч орон	Хувь
1	Парламентын засаглалтай	77	26.2	Шинэ Зеланд	48.3
2	Холимог засаглалтай	46	24.1	Руанда	61.3
3	Ерөнхийлөгчийн засаглалтай	47	20.6	Мексик	48.2
4	Хаант засаглалтай	12	14.2	Арабын нэгдсэн Эмират	50
5	Нэг намын засаглалтай,(коммунист)	5	29.6	Куба	53.4
6	Шилжилтийн үед байгаа улс орнууд	6	13.9	Өмнөд Судан	28.9
	Нийт	193			

Эх сурвалж: Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Парламентын засаглалтай улс орнууд:

2021 оны 6 дугаар сарын байдлаар парламентын засаглалтай нийт 77/193 орон

байгаа бөгөөд тэдгээр улс орнуудын шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн дундаж 26.2 хувь байна.

Хүснэгт. 2.6. Парламентын засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр

Бүсчлэл	Парламентын засаглалын хэлбэр			
	Улс орон	Бүсийн дундаж Хувь	Тэргүүлэгч орон	Хувь
Ази	10	20.6	Зүүн Тимор	38.5
Америк	13	24.9	Гренада	46.7
Европ	37	30.9	Швед	47
Номхон далай	9	13.5	Шинэ Зеланд	48.3
Ойрх Дорнод ба Хойд Африк	2	25.3	Ирак	26.4
Сахараас урагш Африк	6	29.1	Өмнөд Африк	46.1
Нийт улс орны тоо/дундаж хувь	77	26.2		

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Бүсээр нь авч үзвэл Европын бүс 30.9 хувь буюу хамгийн өндөр, Номхон далайн бүс 13.5 хувь буюу хамгийн доод түвшинд байна. (Хавсралт 2. Парламентын засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны үзүүлэлт, бүс нутгаар)

Холимог засаглалтай улс орнууд:

2021 оны 6 дугаар сарын байдлаар холимог хэлбэрийн засаглалтай нийт 46/193 орон байгаа бөгөөд тэдгээр улс орнуудын шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн дундаж 24.1 хувь байна.

Хүснэгт. 2.7. Холимог засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр

Бүсчлэл	Холимог засаглалын хэлбэр			
	Улс орон	Бүсийн дундаж Хувь	Тэргүүлэгч орон	Хувь
Ази	6	19.3	Узбекистан	32.7
Америк	1	35.7	Гаиана	35.7
Европ	10	26.9	Беларусь	40
Номхон далай	1	10.5	Науру	10.5
Ойрх Дорнод ба Хойд Африк	5	20.9	Египет	27.4
Сахараас урагш Африк	23	24.9	Руанда	61.3
Нийт улс орны тоо/дундаж хувь	46	24.1		

Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнууд:

Харин энэ ангилалд Америк бүс 35.7 хувь (1 орон), Европ бүс 26.9% (10 орон) хувиар тэргүүлж, Номхон далайн бүс нутаг 10.5% (1 орон) хамгийн доод түвшинд байна.

2021 оны 6 сарын байдлаар ерөнхийлөгчийн засаглалтай нийт 47 орны шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн дундаж 20.6 хувь байна.

Хүснэгт. 2.8. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр

Бүсчлэл	Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнууд			
	Улс орон	Бүсийн дундаж Хувь	Тэргүүлэгч орон	Хувь
Ази	8	20.6	Филиппин	28
Америк	20	26	Мексик	48.2
Европ	1	14.3	Кипр	14.3
Номхон далай	3	4.1	Палау	6.3
Ойрх Дорнод ба Хойд Африк	0	0	-	-
Сахараас урагш Африк	15	17.1	Бурунди	38.2
Нийт улс орны тоо/дундаж хувь	47	20.6		

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Ерөнхийлөгчийн Засаглалтай улс орнуудын хувьд мөн л Америкийн бүсийн дундаж хамгийн өндөр буюу 26 хувь (20 орон) байгаа бол, Номхон далайн бүс нутаг хамгийн бага буюу 4.1 хувь (3 орон) байна.

Хаант засаглалтай улс орнууд:

Судалгаанд авч үзсэн эх сурвалжаар хэмжээт эрхт хаант засаглалтай нийт 12/193 орон байгаа бөгөөд тэдгээр улс орнуудын шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн дундаж 14.2 хувьтай байна.

Хүснэгт 2.9. Хаант засаглалтай улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт бүсээр

Бүсчлэл	Хаант засаглалтай улс орнууд			
	Улс орон	Бүсийн дундаж Хувь	Тэргүүлэгч орон	Хувь
Ази	2	12	Бутан	14.9
Америк	0	0	-	-
Европ	0	0	-	-
Номхон далай	1	7.4	Тонга	7.4
Ойрх Дорнод ба Хойд Африк	8	16.3	Арабын Нэгдсэн Эмират	50
Сахараас урагш Африк	1	9.6	Свазеланд улс	9.6
Нийт улс орны тоо/дундаж хувь	12	14.2		

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

2.2. СОНГУУЛИЙН КВОТ БА ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

Дэлхийн 100 гаруй улсад сонгуулийн квотыг хэрэглэж байна⁵⁵. Хүйсийн цөөнхийг дэмжих квот нь улс төрийн намууд болон улс төрийн институцуудын практикт өргөн тохиолддог эмэгтэйчүүдийг ялгаварлах, улс төрийн өрсөлдөөнд оруулахгүй байх явдлын эсрэг авч буй түр тусгай арга хэмжээ юм⁵⁶. Дэлхий нийтэд улс орнууд дараах 3 төрлийн квотыг хэрэглэж байна. Үүнд:

1. Хуулиар тогтоосон квот (Legislated Candidate Quotas)

2. Хууль тогтоох байгууллагад суудал хадгалах квот (Reserved Seats)

3. Улс төрийн намын сайн дурын квот (Voluntary Party Quotas)

Судалгаанд хамрагдсан 193 орны хувьд 2021 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар улс төрийн намын сайн дурын квотыг хэрэгжүүлж буй улс орнуудын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн дундаж үзүүлэлт хамгийн өндөр буюу 29.6 хувь байна.

Хүснэгт 2.10. Сонгуулийн квот ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, бүсээр

Бүсчлэл	Квотын систем							
	Хуульчилсан квот		Суудал хадгалах		Намын квот		Квотгүй	
	Улс орон	Хувь	Улс орон	Хувь	Улс орон	Хувь	Улс орон	Хувь
Ази	6	25.9	5	25.1	2	15.3	15	18.3
Америк	16	29.2	2	17.8	2	24.5	11	24.1
Европ	18	30	0	-	17	30	12	27.9
Номхон далай	1	8	1	0	2	39.7	8	8.1
Ойрх Дорнод ба Хойд африк	3	22.7	7	22.7	1	24.2	6	4.9
Сахараас урагш Африк	12	23.1	11	28.1	9	30.5	14	13.5
Нийт улс орны тоо/ дундаж хувь	59	28.01	26	26.2	33	29.6	67	17.4

Хуулиар тогтоосон квот

Судалгаанд хамрагдсан 193 орноос 59 орон квотыг хуульчилан хэрэгжүүлж байгаа бөгөөд

тэдгээр орнуудад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх дундаж үзүүлэлт 28.1 хувь байна⁵⁷.

⁵⁵ Ази, Номхон далайн бүс нутгийн сонгууль албан тушаал дахь жендэрийн тэгш байдал. Бангкок. 2012. 36 дахь тал.

⁵⁶ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон Улсын хүрээлэн. Парламент дахь эмэгтэйчүүд: Тоо ба агуулга. 137 дахь тал.

⁵⁷ Олон улсын парламентын холбоо- Парламент дахь эмэгтэйчүүдийн нэгдсэн сан. 2021 оны 6 дугаар сарын байдлаар.

Квотын хувь хэмжээг улс орнууд харилцан адилгүй тогтоосон хэдий ч 59 орноос 54 орон 30-аас дээш 50 хүртлэх хувиар

хуульчилжээ. Соломоны арлууд улс хамгийн бага квотын хэмжээ болох 10 хувиар тогтоосон нь хамгийн доод үзүүлэлт байна.

Хүснэгт 2.11. Хуулиар сонгуулийн квот тогтоосон улс орнуудын тоо, хувь хэмжээ

Хуулинд заасан квотын хувь	Улс орны тоо	Улсын нэр
10	1	Соломоны арлууд
20-25	4	Өмнөд Судан, Армени, Монгол, Парагвай
30	27	Өмнөд Африк, Аргентин, Португал, Серби, Зүүн Тимор, Доминика, Сан Марино, Узбекистан, Ангола, Польш, БНДУ, Сальвадор, Мали, Казахстан, Словени, Монтенегро, Уругвай, Сан-Томе ба Принсипи, Ирланд, Индонез, Маврики, БНСУ, Колумб, Того, Гвиней, Бразил, Гвиней-Бисау, Либери, Буркина Фасо, Албани, Перу
40	13	Мексик, Испани, Франц, Хойд Македон, Итали, Босни Герцеговина, Молдав, Чили, Венесуэл (Боливиарын Бүгд Найрамдах Улс), Грек, Гондурас Кабо Вердэ
50	14	Никарагуа, Боливи, Коста Рика, Сенегал, Бельги, Эквадор, Хорват, Тунис, Лесото, Панама, Венесуэл (Боливиарын Бүгд Найрамдах Улс), Алжир, Уругвай, Доминиканы Бүгд Найрамдах Улс
Нийт	59	

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Квотыг хуулиар тогтоон хэрэгжүүлж буй 59 орны дунд манайхаас гадна Өмнөд Судан, Армени, Парагвай улсууд квотын хэмжээг 20-25 хувиар тогтоосон байх бөгөөд Армени улс 2021 онд жендэрийн квотыг 3 хүн тутмын

1 нь эмэгтэйчүүд байхаар (33 хувь) болгохоор төлөвлөн ажиллаж байна⁵⁸. Үүний дараа бид дэлхийд 20 хувийн квоттой гурван орны нэг болж үлдэх магадлалтай байна.

Хүснэгт 2.12. Хуулиар сонгуулийн квот тогтоосон улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны эрэмбэ⁵⁹

	Эрэмбэ	Улс орон	Нийт суудал	Эмэгтэй суудал	Эзлэх хувь	Засаглал
1	5	Мексик	500	241	48.2	Ерөнхийлөгч
2	6	Никарагуа	91	43	47.3	Ерөнхийлөгч
3	13	Коста Рика	57	26	45.6	Ерөнхийлөгч
4	16	Испани	350	154	44	Парламент
5	17	Сенегал	165	71	43	Холимог
6	18	Аргентин	257	109	42.4	Парламент
7	20	Бельги	150	63	42	Шилжилтийн
8	23	Португал	230	92	40	Парламент
9	27	Франц	577	228	39.5	Холимог
10	29	Хойд Македон	120	47	39.2	Парламент
11	30	Серби	250	98	39.2	Парламент
12	32	Зүүн Тимор	65	25	38.5	Парламент
13	34	Эквадор	137	52	38	Ерөнхийлөгч
14	36	Кабо Верде	72	26	36.1	Парламент
15	38	Итали	630	225	35.7	Парламент
16	43	Сан Марино	60	20	33.3	Парламент

⁵⁸ UNDP (Ongoing project 2021). "Women in Politics Armenia". <https://www.am.undp.org/content/armenia/en/home/projects/women-in-politics---.html>

⁵⁹ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas/legislative-overview>

17	46	Узбекистан	147	48	32.7	Холимог
18	52	Хорват	151	47	31.1	Парламент
19	55	Ангол	220	65	29.6	Холимог
20	58	Өмнөд Судан	550	159	28.9	Шилжилтийн
21	60	Польш	459	130	28.3	Холимог
22	63	Доминиканы Бүгд Найрамдах Улс	190	53	27.9	Ерөнхийлөгч
23	66	Сальвадор	84	23	27.4	Ерөнхийлөгч
24	68	Мали	121	33	27.3	Шилжилтийн
25	69	Казахстан	107	29	27.1	Холимог
26	71	Словени	90	24	26.7	Парламент
27	73	Тунис	217	57	26.3	Холимог
28	74	Босни ба Херцеговина	42	11	26.2	Парламент
29	77	Алжир	462	120	26	Холимог
30	83	Бүгд Найрамдах Молдав Улс	101	25	24.8	Парламент
31	84	Монтенегро	81	20	24.7	Холимог
32	87	Уругвай	99	24	24.2	Ерөнхийлөгч
33	90	Сан Томе ба Принсипи	55	13	23.6	Холимог
34	91	Лесото	120	28	23.3	Парламент
35	96	Армени	132	30	22.7	Парламент
36	98	Чили	155	35	22.6	Ерөнхийлөгч
37	99	Ирланд	160	36	22.5	Парламент
38	100	Панам	71	16	22.5	Ерөнхийлөгч
39	101	Венесуэл	167	37	22.2	Ерөнхийлөгч
40	103	Грек	300	65	21.7	Парламент
41	107	Гондурас	128	27	21.1	Ерөнхийлөгч
42	108	Индонез	575	121	21	Ерөнхийлөгч
43	119	Бүгд Найрамдах Солонгос Улс	300	57	19	Ерөнхийлөгч
44	120	Колумби	170	32	18.8	Ерөнхийлөгч
45	121	Того	91	17	18.7	Холимог
46	127	Монгол	75	13	17.3	Парламент
47	132	Гвиней	114	19	16.7	Ерөнхийлөгч
48	135	Ливи	188	30	16	Шилжилтийн
49	140	Бразил	513	78	15.2	Ерөнхийлөгч
50	142	Парагвай	80	12	15	Ерөнхийлөгч
51		Палестин	132	17	12.9	
52	161	Либерн	73	8	11	Ерөнхийлөгч
53	170	Соломоны арлууд	50	4	8	Парламент
54	173	Буркина Фасо	127	8	6.3	Холимог
55		Албани	140	-	0	Парламент
56		Перу	130	-	0	Ерөнхийлөгч
	Нийт			59	28.1 хувь	

Эх сурвалж: Олон улсын парламентын холбоо- Парламент дахь жендэрийн нэгдсэн сан. 2021 оны 6 дугаар сарын байдлаар.

Хуулиар тогтоосон квотыг хэрэглэж буй улс орнуудыг бүсээр нь авч үзвэл Европийн бүс хамгийн өндөр буюу 30 хувьтай байна.

Хүснэгт 2.13. Хуулиар сонгуулийн квот тогтоосон улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны эрэмбэ бүсээр

Бүс	Улс орон	Бүсийн дундаж	Тэргүүлэгч улс	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Ази	6	25.9%	Зүүн Тимор	38.5
Америк	16	29.2%	Мексик	48.2
Европ	18	30%	Испани	44
Номхон далай	1	8%	Соломоны арлууд	8
Ойрх Дорнод	3	22.7%	Тунис	26.3
Сахараас урагш Африк	12	23.1%	Сенегал	43

Эх сурвалж: Олон улсын парламентын холбоо- Парламент дахь жендэрийн нэгдсэн сан. 2021 оны 6 дугаар сарын байдлаар.

(Хавсралт 2. Хуулиар тогтоосон квотыг хэрэглэж буй улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны үзүүлэлт, бүсээр)

Сонгуулийн квотыг хуульчилсан 59 орноос 13 нь Үндсэн хуулиндаа квотын хэмжээг заах, тэгш боломж, тэгш оролцооны зарчмыг тусгах замаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог баталгаажуулжээ.

Хүснэгт 2.14. Квотыг хуульчилсан 59 орноос Үндсэн хуулиндаа тусгасан орнууд

Үндсэн хуулинд заасан агуулга	
1. Мексик	Улс төрийн намууд холбооны болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийг тодруулахдаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүрмийг боловсруулах. Үндсэн хуулийн 41-р зүйл ⁶⁰
2. Никарагуа	Улс төрийн намууд пропорционал зарчмын дагуу бүх нийтийн санал хураалтаар сонгогдох нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтийг шударга, хүйсийн харьцааг хадгалсан байхаар эрэгтэй 50%, эмэгтэй 50% ийг агуулан, хүйсээр сөөлжилсөн байх шаардлагатай. Үндсэн хуулийн 131-р зүйл ⁶¹
3. Өмнөд Судан	Бүх шатны засаг захиргаа, хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагуудад эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх, оролцоог доод тал нь 25 хувиар дэмжиж, түүх, ёс заншлаас үүдэлтэй тэнцвэргүй байдлыг арилгах эерэг арга хэмжээ авах. (Шинэ Үндсэн хуулийн 16-зүйл 40А 2011 он ⁶²)
4. Аргентин	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонгогдох, улс төрийн болон намын албан тушаалд ажиллах тэгш эрх, боломжийг улс төрийн намуудын зохицуулалт, сонгуулийн тогтолцоогоор баталгаажуулна. (37.2 зүйл ⁶³)
5. Франц	Сонгуульд нэр дэвших үед эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгийн төлөөлөл тэгш хамрагдах ёстой ⁶⁴ . (1 дүгээр зүйлийн 2) Энэ зарчмыг баримтлах, дэмжих улс төрийн намуудын хариуцлагыг үндсэн хуулинд тусгасан байна. (3,4 дүгээр зүйл)
6. Серби	Үндэсний Ассамблейд хууль тогтоомжийн дагуу эрэгтэй, эмэгтэй хүйсийн, үндэсний цөөнхийн төлөөлөл бүрийг тэгш хамруулна. (100-р зүйл/заалт ⁶⁵)
7. Эквадор	Төр нь олон нийтээс томилогдсон буюу сонгогдсон бүх албан тушаал, гүйцэтгэх болон шийдвэр гаргах байгууллагууд, улс төрийн нам, олон нийтийн хөдөлгөөнүүдэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн төлөөллийг тэгш хангахыг дэмжинэ. Сонгуульд идэвхтэй нэр дэвших, оролцох замаар эрх мэдлийг сэлгэх, ээлжлэх үйл явдлыг дэмжинэ. (65-р зүйл/2008 онд шинэчлэн найруулсан ⁶⁶ .)
8. Танзани	Үндэсний Ассамблейн эмэгтэй гишүүд нийт тооноос 30 хувиас доошгүй байх ёстой. Улс төрийн намууд парламентын суудлын тооны хамаарлын дагуу эмэгтэйчүүдэд зориулан хуваарилах ёстой. (Үндсэн хууль, 66 зүйл (1:b) болон 78 заалт ⁶⁷ (1))

⁶⁰ Constitution of the United Mexican States (rev. 2015) (English Version)

⁶¹ Nicaragua's Constitution of 1987 with Amendments through 2014

⁶² Transitional Constitution of the Republic of South Sudan 2011

⁶³ Constitution of Argentina (rev. 1994) (English, French and Spanish version).

⁶⁴ Constitution du 4 octobre 1958 [Constitution of 4 October 1958], consolidated version of 2009

⁶⁵ Constitution of Serbia (rev. 2006) (English version)

⁶⁶ Constitution of the Republic of Ecuador 2008 (rev. 2011) (English version)

⁶⁷ Constitution of the United Republic of Tanzania

9. Итали	'Аль ч хүйсийн иргэн хуулиар тогтоосон нөхцлийн дагуу төрийн албан тушаалд сонгогдох эрхтэй бөгөөд улс нь эмэгтэй, эрэгтэйчүүдийн тэгш боломж, тэгш эрхийг дэмжих тодорхой арга хэмжээ авах ёстой. (Үндсэн хууль 51-р заалт) ⁶⁸
10. Бүгд Найрамдах Доминик улс	Төр нь олон нийтийн сонгуульд эмэгтэй, эрэгтэй хүмүүс нэр дэвших тэгш эрх, тэгш боломжийг хангаж, баталгаажуулах ёстой. (39-р зүйлийн 5-р заалт) ⁶⁹
11. Тунис	Улс нь бүх салбарын хариуцлагын бүх түвшинд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш төлөөлөл, тэгш хамрагдах боломж, эрх тэгш байдлыг хангах болно. Үндсэн хууль 46-р заалт/2014 он ⁷⁰ .
12. Алжир	Төр нь чуулганд төлөөлөл эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх замаар тэдний улс төрийн эрхийг дэмжих болно, Тус заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг бусад дагалдах хуулиар тогтооно. (Үндсэн хууль 59-р заалт) ⁷¹
13. Грек	Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг дэмжих эерэг үйл хэрэг нь хүйсээр ялгаварлан гадуурхах явдал биш юм. Төр нь эмэгтэйчүүдийг хохироосон тэгш бус байдлыг арилгах арга хэмжээ авах ёстой. (Article 116, para 2) ⁷²

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. *Global data on National Parliaments. June-July 2021 archive site.*

Квотыг хэрэгжүүлж байгаа улс орнууд өөр өөрийн онцлог бүхий арга, зарчмуудыг хэрэглэж байна. Энэхүү судалгааны хүрээнд дараах 11 орны жишээг судлан орууллаа.

ИНДОНЕЗ УЛС

2007 оны 1 сард төлөөлөгчийн танхим дахь эмэгтэйчүүд 11.64 хувийг эзэлж байсан бол 2020 оны 12 сарын байдлаар 21 хувьд хүрч сүүлийн 10 жилд даруй 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төлөөлөгчийн танхимын гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад эмэгтэйчүүдийн төлөөлөл 30-аас доошгүй хувьтай байх ёстой. (Ерөнхий сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйл)⁷³ Нэрсийн жагсаалтын 3 нэр дэвшигч тутамд 1 эмэгтэй нэр дэвшигч байхаар хуульчилжээ. (Ерөнхий сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)⁷⁴

2012 оны 8 дугаар сард квотын тухай заалт

бүхий уг хууль батлагдсан бөгөөд сонгуулийн төв байгууллага нь 2013 онд нэмэлт журам гаргаж мөрдүүлжээ. (Сонгуулийн төв байгууллагын 2013/07 журмын 27 дугаар зүйл)⁷⁵ Энэхүү журамд зааснаар сонгуулийн төв байгууллага нь квотын шаардлагын биелэлтийг хянах үүрэгтэй бөгөөд, нэрсийн жагсаалтад эмэгтэйчүүдийн төлөөлөл 30 хувиас бага байх тохиолдолд улс төрийн намд жагсаалтаа өөрчлөх боломжийг олгоно. (58 дугаар зүйлийн 1 дүгээр заалт, 59 дүгээр зүйлийн 2 дугаар заалт). Хэрэв боломж олгосон хугацаанд тухайн нам квотын шаардлагыг хангаж чадаагүй бол сонгуулийн төв байгууллага нь тухайн тойрогт намаас нэр дэвшүүлэх эрхийг хасдаг байна.

Энэхүү журам батлагдсаны дараа 2014 онд явагдсан сонгуулиар эмэгтэйчүүдийн эзлэх хувь 16.79 болж өсчээ⁷⁶.

Индонез улс энэ хуульдаа 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд 30 хувийн квот болон “цахилгаан товч”-ны системийг огт хөндөлгүй, хэвээр үлдээсээр байна.

Хүснэгт 2.15. Индонез улсын парламентын дээд танхим дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Он	2007-01	2008-01	2014-04	2019-12-02	2020-12
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	11.64%	11.27%	16.79%	20.35%	21.04%

⁶⁸ Constitution of Italy (English version)

⁶⁹ Constitution of Dominican Republic (rev.2015) (English version)

⁷⁰ The Constitution of the Tunisian Republic, 2014

⁷¹ Inter-Parliamentary Union. Algeria

⁷² Constitution of Greece (updated up to 2008);

⁷³ Law 8/2012 on General Election of the Members of House of Representatives, People's Representatives Council and Regional House of Representatives (2012, unofficial translation);

⁷⁴ Indonesian Parliament, 'This is Act Number 7 of 2017 concerning General Elections (2)'

⁷⁵ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

⁷⁶ Sri Adhiati, A., 'Women in Parliament: Quotas and Beyond', Tapol, no. 4 (February 2009)


ФРАНЦ УЛС

Үндсэн хуулиндаа сонгуульд нэр дэвшихэд эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл, тэгш хамрагдах зарчмыг тусгасан⁷⁷ (1 дүгээр зүйлийн 2 дахь заалт) бөгөөд энэ зарчмыг баримтлах, сурталчлах улс төрийн намуудын үүргийг үндсэн хуулиндаа заажээ. (3, 4 дүгээр зүйл)

Нам, эвсэлээс сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүйсийн төлөөллийн зөрүү 2 хувиас хэтрэхгүй байхаар тогтоож⁷⁸, (Хуулийн 88-227 дугаар 9.1 зүйл) зөрчсөн тохиолдолд

санхүүгийн торгууль ногдуулдаг. Ингэхдээ сонгуулийн 1 дүгээр шатанд хүчинтэй саналын тоонд суурилсан тооцооллоос нэр дэвшигчийн хүйсийн зөрүүний дөрөвний гуравтай тэнцэх хувиар улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг бууруулна.(9 дүгээр зүйлийн 1)⁷⁹. Жишээлбэл, нийт нэр дэвшигчдийн 40 хувь нь эмэгтэй байсан бол хүйсийн зөрүүг 20 хувь гэж тооцон улс төрийн намын санхүүжилтийн хувийг 15 хувиар бууруулна⁸⁰.

Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Зураг. 2.1. Франц улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Хүснэгт 2.16. Франц улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Он	2002-06	2007-01	2011-01	2014-01	2017-06	2018-08	2019- 12
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	12.37%	18.54%	18.54%	26.17%	38.82%	39.58%	39.51%

Ийнхүү үндсэн хуулиндаа квотыг зааж өгөхийн зэрэгцээ улс төрийн санхүүжилтийн нарийн тодорхой арга аргачлал ашигласнаар Франц улс 2006 оноос

2019 он хүртэл 13 жилд парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жинг 27 хувиар өсгөж чадсан байна.

⁷⁷ Constitution du 4 octobre 1958 [Constitution of 4 October 1958], consolidated version of 2009

⁷⁸ Inter-Parliamentary Union, IPU Parline France

⁷⁹ Code electoral, Partie Législative

⁸⁰ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>


ПОЛЬШ УЛС

2011 онд Сонгуулийн тухай хуульдаа “Эмэгтэй, эрэгтэй аль ч хүйсийн төлөөлөл жагсаалтад байгаа нийт нэр дэвшигчдийн 35 хувиас бага байж болохгүй” (211 дүгээр зүйлийн 3)⁸¹ гэсэн заалтыг оруулж баталжээ. Энэ хууль батлагдан хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа парламентын, Европын парламентын, орон нутгийн сонгуульд хамаарах шинэ журмыг шинэчлэн баталсан байна⁸². Орон нутгийн сонгуульд хамаарах нэмэлт өөрчлөлт нь нэрсийн жагсаалтад байгаа 3 нэр дэвшигч тутамд

хүйс тус бүрээс дор хаяж нэг төлөөлөл бүхий нэр дэвшигч байх тухай заалт юм. (134 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт)⁸³

Сонгуулийн төв байгууллага нь шаардлага хангаагүй нэрсийн жагсаалтыг Улс төрийн намд буцааж, 3 хоногийн засах хугацааг олгоно. Заасан хугацаанд засварлаагүй тохиолдолд сонгуулийн төв байгууллага нь жагсаалтыг бүхэлд нь бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах ёстой ажээ. (215 дугаар зүйлийн 5 дахь заалт)

Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Зураг. 2.2. Польш улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Хүснэгт 2.17. Польш улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Он	2001-09	2005-09	2008-01	2010-01	2011-11	2014-12	2016-12	2020-12
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	20.22%	20.43%	20.22%	20%	23.91%	24.13%	28.04%	28.32%

АРМЕНИ УЛС

Анх 1999 онд квотыг хуульчилан пропорционал тогтолцоонд 5 хувийн эмэгтэй квотыг тогтоосон байна. Үүний дараа 2007 онд 15 хувь болгон өөрчилж, 2021 онд одоогийн квотыг хуульчилсан байна⁸⁴. Энэ нь нэг улс төрийн намаас нэг хүйсийн төлөөлөл 80 хувиас хэтэрч болохгүй бөгөөд, нэр дэвшигчийн жагсаалтын 5 хүн тутмын 1 нь эмэгтэй төлөөлөл байх юм. Энэ шаардлагыг хангаагүй бол Сонгуулийн төв байгууллага нь

улс төрийн нам, эвслийн нэрсийн жагсаалтыг бүртгэхээс татгалзана.(108 дүгээр зүйлийн 2)⁸⁵

Армени парламент нь нэг мандаттай 41 тойргоос сонгогдсон 41, пропорционал тогтолцоогоор сонгогдсон 90 суудлаас бүрддэг байна⁸⁶. 2021 онд жендэрийн квотыг 3 хүн тутмын 1 нь эмэгтэйчүүд байхаар (33 хувь) болгохоор төлөвлөн ажиллаж байгаа ажээ⁸⁷.

⁸¹ Election Code (2011)

⁸² Council of Europe: <https://www.coe.int/en/web/electoral-assistance/elecdata-poland>

⁸³ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

⁸⁴ UNDP (Ongoing project 2021). “Women in Politics Armenia”. <https://www.am.undp.org/content/armenia/en/home/projects/women-in-politics---.html>

⁸⁵ Electoral Code of Armenia, 2011 (English version)


⁸⁶ Armenian Parliament website, <http://www.parliament.am>

⁸⁷ UNDP (Ongoing project 2021). “Women in Politics Armenia”. <https://www.am.undp.org/content/armenia/en/home/projects/women-in-politics---.html>

Армени улс квотын хувь хэмжээг байнга нэмэгдүүлж 3 удаа хуулиндаа өөрчлөлт оруулсан байх бөгөөд ингэснээр 2007 оноос

өнөөдрийг хүртэлх хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн тоог 14 жилд 21,5 хувиар өсгөж чаджээ.

Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Зураг. 2.3. Армени улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Хүснэгт 2.18. Армени улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Он	2007-05	2009-01	2012-05	2017-05	2019-10	2020-12	2021-06
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	9.16%	9.16%	10.69%	18.1%	23.48%	22.73%	33.64%

МЕКСИК УЛС

Үндсэн хуульдаа (41 дүгээр зүйл) улс төрийн намууд холбооны болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийг тодруулахдаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүрмийг боловсруулах тухай заажээ⁸⁸.

Холбооны төлөөлөгчийн танхим нь 3 жилийн хугацаатай, 500 гишүүнээс бүрддэг. Үүнээс 300 нь нэг мандаттай тойрогт олонхын саналаар сонгогддог бөгөөд үлдсэн 200 гишүүнийг пропорционал тогтолцоогоор сонгогддог байна. Улс төрийн намууд жагсаалтад орсон нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувийг нэг хүйсийн төлөөлөл байлгах, сонгуулийг ямар тогтолцоогоор явуулахаас үл хамааран энэ үүргийг биелүүлэх ёстой байна⁸⁹. (COFIPE, Article 219).

Пропорционал тогтолцооны хувьд жагсаалтад орсон 5 нэр дэвшигч тутамд эрэгтэй эмэгтэй гэж сөөлжлүүлэн, нэг хүйсийн төлөөлөл нь багадаа 2 хүн байх ёстой. (COFIPE, Article 220).

Сонгуулийн тухай хуульд заасан дээрх зүйлийг дагаж мөрдөөгүй улс төрийн намд 48

цагийн засварлах хугацаа олгодог бөгөөд, энэ хугацааны дараа шаардлага хангаагүй хэвээр байвал сонгуулийн төв байгууллага нь олон нийтэд мэдэгдэж, дахин 24 цагийн нэмэлт хугацаа өгдөг байна. Дээрх хугацааны эцэст шаардлага хангагдаагүй бол тухай улс төрийн намын нэрсийн жагсаалтыг хүчингүй болгодог ажээ. (COFIPE, Article 221).

Сонирхолтой нь Мексикийн намуудаас Хувьсгалт нам (Institutional Revolutionary Party) эмэгтэйчүүдийн 50 хувийн квоттой байхаар нам дотроо журамласан байдаг. (Намын дүрэм 38-р заалт)


Мексик улсын хувьд улс төрийн санхүүжилттэй холбож өгснөөрөө эмэгтэйчүүдийн эзлэх хувь тасралтгүй өссөн байх магадлалтай байна. Сүүлийн 20 жилд 34 хувиар өссөн нь улс орнуудын дунд хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ нь улс төрийн намууд жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөр санхүүгийн урамшуулал авах, хэрэв жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа, эмэгтэй манлайллыг хөгжүүлэхэд зориулагдсан

⁸⁸ Constitution of the United Mexican States (rev. 2015) (English Version)

⁸⁹ Federal Code of Electoral Institutions and Procedures of Mexico 2008 (rev.2013)(English version)

төсвийн хөрөнгийг буруу зарцуулсан бол бүртгэлээс хасагдах, улсын төсвөөс хуваарилсан санхүүжилтийн 50 хүртлэх хувийг алдах эрсдэлтэй⁹⁰ зэрэг хатуу заалтуудтай байна.

Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Зураг. 2.4. Мексик улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх

Хүснэгт 2.19. Мексик улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Он	2000-07	2003-07	2006-07	2009-01	2012-07	2015-06	2018-07	2021-06
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	16%	22.6%	22.6%	28.2%	36.8%	42.2%	48.2%	50%

НИКАРАГУА УЛС

Үндсэн хуулиндаа улс төрийн намууд нэр дэвшигчдийн хүйсийн харьцааг тэнцүү хадгалж, нэрсийн жагсаалтад эрэгтэй нэр дэвшигч 50 хувь, эмэгтэй нэр дэвшигч 50 хувь байхаар хүйсээр сөөлжлөн байршуулах тухай хуульчилжээ. (Үндсэн хуулийн 131 дүгээр зүйл⁹¹)

Үндсэн хуулийн энэ зарчмын дагуу Сонгуулийн тухай хуулиндаа 2012 онд өөрчлөлт оруулж, үндэсний Ассамблейн сонгуульд улс төрийн нам, эвсэл 50 хувь эмэгтэй, 50 хувь эрэгтэй нэр дэвшигчдийг жагсаалтад оруулах заалтыг оруулсан байна. (Сонгуулийн тухай хууль 82.4 зүйл 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан⁹²). Ингэхдээ нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг “Цахилгаан товч”-ны системээр эрэгтэй, эмэгтэй хүйсээр сөөлжилсөн байхаар зохион байгуулна⁹³. (82-р зүйлийн 4)

Никарагуа улсад улс төрийн намууд нь квотын зарчмыг дараах байлаар хэрэгжүүлдэг. Үүнд:

- Үндэсний чөлөөлөх Сандинист фронт нам: Эмэгтэйчүүдийн 30 хувийн квоттой⁹⁴.
- Либерал ба Үндсэн хуульч нам: Нэр дэвшигчийн жагсаалтад эмэгтэй, залуучуудад зориулсан 40 хувийн квоттой⁹⁵.
- Сандинистуудыг шинэчлэх хөдөлгөөн нам: Нэр дэвшигчийн жагсаалтад 40-өөс дээш хувийн эмэгтэйчүүдийн квоттой⁹⁶.

⁹⁰ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

⁹¹ Nicaragua's Constitution of 1987 with Amendments through 2014

⁹² Ley no 331, Ley Electoral, 2000 [Law no. 33, Electoral Law, 2000], accessed 03 April 2014;


⁹³ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

⁹⁴ Намын дүрэм 106-р зүйл SAMQUI 2008, хуудас 8.

⁹⁵ Намын дүрэм 76-р зүйл SAMQUI 2008, хуудас 8.

⁹⁶ Намын дүрэм 7-р зүйл SAMQUI 2008, хуудас 8

Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Зураг. 2.5. Никарагуа улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Хүснэгт 2.20. Никарагуа улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Он	1996-01	2001-11	2006-11	2009-01	2011-11	2014-12	2018-01	2021-01
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	9.68%	20.65%	15.22%	20.65%	40.22%	39.13%	44.57%	47.25%

БРАЗИЛ УЛС

Анх 1995 онд орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн 20 хувь нь эмэгтэй байх квотыг баталсан байна. 1997 онд сонгуулийн шинэ хуулиар, нам эвсэлүүд бүх шатны сонгуульд оролцоходоо хүйс бүрийн төлөөллөөс багадаа 30 хувь, дээд тал нь 70 хувь байх ёстой гэж тогтоосон байна⁹⁷. Хэрэв хүйсийн квотын шаардлагыг хангаагүй бол хэт олон

төлөөлөл бүхий хүйсийн нэр дэвшигчдийг хасч болно. Гэхдээ энэ нь тухайн нам нэг тойрогт заагдсан дээд хэмжээнээс илүү нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт ирүүлсэн тохиолдолд л хамаарна. (Энэхүү заалт нь квотын заалтын үр нөлөөг багасгасан гэж үздэг байна⁹⁸.)

Хүснэгт 2.21. Бразил улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт

Он	2002-10	2006-01	2010-10	2014-10	2016-12	2019-12	2020-12
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	8.58%	8.77%	8.58%	9.94%	10.72%	14.62%	15.2%

БОЛИВИ УЛС

Энэ улсын хувьд сонирхолтой нь доод танхимын (Сbтmага de Diputados) олон мандаттай тойрогт нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэй хүйсийн тоог тэнцүү хэмжээгээр багтаасан байх ёстой бөгөөд хэрэв жагсаалтад сондгой тооны нэр дэвшигчтэй байвал эмэгтэйчүүдэд давуу эрх олгодоггоороо онцлог байна.

Харин нэг мандаттай дээд танхимд нэр дэвшигчдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх ёстой ажээ.(Сонгуулийн тухай хууль 11-р зүйлийн 58.2 заалт⁹⁹)

Хэрэв заалтыг зөрчвөл нэр дэвшигчдийн жагсаалтыг түтгэлзүүлдэг байна. Энэ тохиолдолд түтгэлзсэн тухай сонгуулийн комисст мэдэгдэх бөгөөд мэдэгдэл гарснаас

⁹⁷ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

⁹⁸ Олон Улсын парламентын холбоо. Парламент дахь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд: Ардчилалыг бий болгох нь 1997а. A world Comparative Study. Geneva: Inter-Parliamentary Union.

⁹⁹ Electoral Regime Law (2010)


хойш 72 цагийн дотор нэр дэвшигчийн жагсаалтыг засах боломжтой ажээ. (Сонгуулийн тухай хууль 107 дугаар зүйл) Жагсаалтад эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг сөөлжлөн байршуулах ёстой. (Сонгуулийн тухай хууль 11-р зүйлийн 58.2 заалт)

Квотыг анх 1997 онд хуулинд тусгасан боловч 2010 онд Сонгуулийн тухай хуульдаа эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш оролцоотой байх тухай нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Уг хуулийг 2014 онд сонгогдсон депутатын танхимд анхлан хэрэгжүүлжээ¹⁰⁰.

Боливи улсын эрх баригч нам болох Үндэсний нэгдлийн фронт нам дотоод дүрмийнхээ 31 дүгээр зүйлд намын бүх түвшинд эмэгтэйчүүд 50 хувийг төлөөлнө гэж тусгасан байдаг байна¹⁰¹.

Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Зураг. 2.6. Боливи улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Хүснэгт 2.22. Боливи улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Он	1998-01	2002-01	2005-12	2009-12	2011-01	2014-10	2020-10
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	11.54%	18.46%	16.92%	22.31%	22.31%	53.08%	46.15%

КОСТА-РИКА УЛС

2009 онд квотын хэмжээ 50 хувь байх хууль батлагдсан. Нэрсийн жагсаалт дахь хүйсийн төлөөлөл 50 хувьтай байх ёстой бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийт тооны зөрүү нэгээс хэтрэхгүй байх, адил хүйсийн хоёр нэр дэвшигч нэг дор бичигдэж болохгүйг хуульчилжээ. (Сонгуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 8765-т)

Улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигчдийн жагсаалтад хүйсийг сөөлжилсөн байдлаар оруулна. (Сонгуулийн тухай хуулийн 148-р зүйл¹⁰²) Сонгуулийн төв байгууллага нь тэгш эрх, хүйсийн сөөлжилсөн зарчмыг дагаж мөрдөөгүй улс төрийн намын нэр дэвшигчийн жагсаалтыг бүртгэхгүй. (Сонгуулийн тухай хуулийн 148-р зүйл).

Мөн улс төрийн намууд өөрсдийн дотоод дүрэмдээ квотыг тогтоосон байдаг¹⁰³.

Жишээ нь:

- Үндэсний Либерал Нам-Аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх.
- Христ-Нийгмийн нэгдэл нам-Аль нэг хүйсийн төлөөлөл 60 хувиас хэтрэхгүй байх.
- Иргэний хөдөлгөөн Нам-Эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийн харьцаа 50 хувь байх бөгөөд сөөлжилсөн нэрсийн дараалалтай байх.
- Либератор Хөдөлгөөн Нам-Эмэгтэй нэр дэвшигч 40 хувиас багагүй байх¹⁰⁴.

¹⁰⁰ Inter-Parliamentary Union, (2021). "Women in Parliament in 2020 The Year in Review".


¹⁰¹ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

¹⁰² Electoral Code 2009 (Legislative Decree no. 8765)

¹⁰³ Gender Equality Observatory for Latin America and the Caribbean (Official website)

¹⁰⁴ Partido Movimiento Libertario - Statute

Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Зураг. 2.7. Коста-Рика улсын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Хүснэгт 2.23. Коста-Рика улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Он	1998-01	2002-02	2006-02	2010-01	2014-02	2016-12	2018-02
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	19.3%	31.58%	38.6%	36.84%	33.3%	35.09%	45.61%

СОЛОМОНЫ АРЛУУД УЛС

Хуулиндаа 10 хувийн квот заасан нь эмэгтэйчүүдийн парламентад нэр дэвших оролцооны доод түвшинг хангах зорилготой заалт юм¹⁰⁵. Уг заалтыг 2014 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлан хэрэгжүүлж эхэлсэн байна. Хуульд квотын хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд авах хориг арга хэмжээний талаар заагаагүй нь дээрх заалтын үр нөлөөг сулруулж байна гэж судлаачид үздэг байна¹⁰⁶.

Олон улсын парламентын мэдээлснээр тус улсын түүхэнд ердөө гурван эмэгтэй парламентад сонгогдсон байна¹⁰⁷.

Сонирхолтой нь улс төрийн намууд сонгогдсон эмэгтэй гишүүн бүрийн тоог 10000 долларын тэтгэлэгээр нэмэлт санхүүжилт хүртэнэ. (Улс төрийн санхүүжилтийн тухай хууль 58.1.а дугаар зүйл) Харин бие даан нэр дэвшиж, сонгогдсон эмэгтэй гишүүн уг тэтгэлэг авах эрхгүй байна. (Улс төрийн санхүүжилтийн тухай хууль 49.4 дүгээр зүйл)¹⁰⁸

Хууль тогтоох байгууллагад суудал хадгалах зарчим:

Улс орнууд улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах зорилгоор хууль тогтоох дээд байгууллагад суудал хадгалах хүйсийн доод хязгаарыг тогтоох явдал байдаг.

Дараах 26 улс суудал хадгалах квотыг хэрэгжүүлж байгаа бөгөөд дундаж үзүүлэлт 26.6 хувьд хүрсэн байна¹⁰⁹.

¹⁰⁵ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

¹⁰⁶ Inter-Parliamentary Union, IPU Parline Solomon Islands

¹⁰⁷ Inter-Parliamentary Union, IPU Parline Solomon Islands

¹⁰⁸ Political Parties Integrity Act Integrity Act 2014 (No.9 of 2014)

¹⁰⁹ Олон улсын парламентын холбоо- Парламент дахь жендэрийн нэгдсэн сан. 2021 оны 6 дугаар сарын байдлаар.

Хүснэгт 2.24. Суудал хадгалах квотыг хэрэгжүүлж буй улс орнууд

№	Эрэмбэ	Улс орон	Нийт суудал	Эмэгтэй суудал	Эзлэх хувь	Засаглал	Парламентын танхим	Сонгуулийн мөчлөг
1	1	Руанда	80	49	61.3	Холимог	2 танхим	5
2	3	Арабын Нэгдсэн Эмират улс	40	20	50	Хаант	1 танхим	4
3	33	Бурунди	123	47	38.2	Ерөнхийлөгч	2 танхим	5
4	35	Танзани нэгдсэн улс	388	143	36.9	Ерөнхийлөгч	1 танхим	5
5	37	Гайана	70	25	35.7	Холимог	1 танхим	5
6	44	Уганда	529	174	32.9	Ерөнхийлөгч	1 танхим	5
7	45	Балба	275	90	32.7	Парламент	2 танхим	5
8	47	Зимбабве	270	86	31.9	Холимог	2 танхим	5
9	65	Египет	591	162	27.4	Холимог	2 танхим	5
10	70	Афганистан	248	67	27	Ерөнхийлөгч	2 танхим	5
11	72	Ирак	329	87	26.4	Парламент	1 танхим	4
12	75	Жибути	65	17	26.2	Холимог	1 танхим	5
13	78	Нигер	166	43	25.9	Холимог	1 танхим	5
14	82	Хятад	2975	742	24.9	Коммунист	1 танхим	5
15	85	Сомали	275	67	24.4	Холимог	2 танхим	4
16	106	Кени	347	75	21.6	Ерөнхийлөгч	2 танхим	5
17	109	Бангладеш	350	73	20.9	Парламент	1 танхим	5
18	112	Марокко	395	81	20.5	Хаант	2 танхим	5
19	114	Пакистан	342	69	20.2	Парламент	2 танхим	5
20	117	Саудын Араб	151	30	19.9	Хаант	1 танхим	4
21	156	Жордан	130	15	11.5	Хаант	2 танхим	4
22	166	Свазиленд улсад	73	7	9.6	Хаант	2 танхим	5
23		Эритрей	-	-	0	Ерөнхийлөгч	1 танхим	4
24		Гаити	-	-	0	Ерөнхийлөгч	2 танхим	4
25		Самоа	51	-	0	Парламент	1 танхим	5
26	47	Судан	426	133	31.2	Шилжилтийн	2 танхим	
	Нийт				26	26.6		

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Энэ зохицуулалт нь олонхын тогтолцоонд илүүтэй байх бөгөөд ихэнхдээ үндсэн хуульдаа заасан байдаг. Тухайлбал, Афганистанд 32 муж тус бүрээр 2 эмэгтэй буюу нийт суудлын ойролцоогоор 25 хувь, Угандад 56 тойрог тус бүрээс 2 эмэгтэй буюу нийт суудлын ойролцоогоор 18 хувь, Руандад зөвхөн эмэгтэй нэр дэвшигч л сонгогддог тойргийн заалт бүхий хууль үйлчилж байна¹¹⁰.

Суудал хадгалах квотыг хэрэглэж буй улс орнуудыг бүсээр нь авч үзвэл Сахараас урагш Африкийн бүс хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны үзүүлэлтээр хамгийн өндөр буюу 28.1 хувьтай байна. (Хавсралт 3. Суудал хадгалах квотыг хуульчилсан улс орнуудын эрэмбэ, бүсээр)

¹¹⁰ ЖҮХАА. Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 2021 он. 47 тал.

Хүснэгт 2.25. Суудал хадгалах квотыг хуульчилсан улс орнуудын эрэмбэ, бүсээр

Бүс	Улс орон	Бүсийн дундаж	Тэргүүлэгч улс	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Ази	5	25.1%	Балба	32.7
Америк	2	17.8%	Гаиана	35.7
Европ	0	-	-	-
Номхон далай	1	0%	Самоа	0
Ойрх Дорнод	7	22.7%	Арабын Нэгдсэн Эмират	50
Сахараас урагш Африк	11	28.1%	Руанда	61.3

Эх сурвалж: Олон улсын парламентын холбоо-Парламент дахь жендэрийн нэгдсэн сан. 2021 оны 6 дугаар сарын байдлаар.

УЛС ТӨРИЙН НАМЫН САЙН ДУРЫН КВОТ:

Эмэгтэйчүүдийн хувьд сонгуульд нэр дэвшин өрсөлдөх хувийн шийдвэрээ гаргахаас эхлээд нам дотроо өрсөлдөж, нэр дэвших, улмаар сонгогчдын саналыг авч сонгогдох хүртэл олон сорилттой тулгардаг.

Эдгээр сорилтыг даван туулахад туслах нэг хөшүүрэг нь улс төрийн намууд дүрмэндээ квотыг оруулах явдал юм.

Энэ төрлийн квотыг хэрэглэж байгаа нийт 55 орчим улс орон байгаа бөгөөд зарим оронд хуульчилсан квот, суудал хадгалах квотыг хослуулан хэрэглэж байна. Үүнээс улс төрийн намуудын сайн дурын квотын хэлбэрийг дангаар нь ашиглаж байгаа нийт 33 улс байгаа бөгөөд эдгээр орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх дундаж хувь 29.6 байна¹¹¹.

Улс төрийн намын сайн дурын квотыг хэрэгжүүлж буй орнуудыг бүсээр нь авч үзвэл Номхон далайн бүс хамгийн өндөр буюу 39.7 хувьтай байгаа бөгөөд Европын бүсийн 17 орон квотын энэ хэлбэрийг хэрэглэж байгаагаар хамгийн өндөр үзүүлэлттэй байна. (Хавсралт 4. Улс төрийн намын сайн дурын квотыг хэрэглэж байгаа улс орнуудын эрэмбэ, бүс нутгаар)

Улс төрийн намын дотоод төлөөллийн байгууллагад нэр дэвшигчийн болон суудал хадгалах квотыг хэрэглэх нь хамгийн үр ашигтай байна¹¹². Учир нь үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн өмнө намууд дотооддоо эмэгтэйчүүдэд улс төрийн боловсрол олгох, улс төрийн хүрээнд өөрийгөө таниулах, туршлагажих боломжийг олгох шаардлагатай. Иймээс эдгээр сорилтыг даван туулахад туслах бас нэг хөшүүрэг нь улс төрийн намууд дүрэмдээ квотыг тусгах явдал юм¹¹³.

Хүснэгт 2.26. Улс төрийн намын квотыг хэрэгжүүлэгч орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт, бүс нутгаар.

Бүс	Улс орон	Бүсийн дундаж	Тэргүүлэгч улс	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Ази	2	15.3%	Тайланд	15.8
Америк	2	24.5%	Канад	29.6
Европ	17	30%	Швед	47
Номхон далай	2	39.7%	Шинэ Зеланд	48.3
Ойрх Дорнод	1	24.2%	Израйль	24.2
Сахараас урагш Африк	9	30.5%	Өмнөд Африк	46.1

¹¹¹ НҮБ ХХ, ЖҮХ 2014. “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь” төсөл.

¹¹² Де Факто Институт, “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс” 2019 он. 25-р хуудас.

¹¹³ ЖҮХАА. Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 2021 он. 47 тал.

Квот хэрэглэдэггүй улс орнууд:

Харин хуулиндаа квот тусгаагүй, мөн намын сайн дурын квот болон суудал хадгалах квот хэрэглэдэггүй нийт 67 улс байгаа

бөгөөд дундаж үзүүлэлт 17.4 хувьтай байна. Тэдгээрээс шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь 25-аас дээш дараах 16 улс орон байна.

Хүснэгт 2.27. Квот хэрэглэдэггүй улс орнуудын эрэмбэ

№	Улс орон	Сүүлийн сонгууль	Нийт суудал	Эмэгтэй суудал	Эзлэх хувь	Засаглал	Парламентын танхим	Сонгуулийн мөчлөг
8	Гренада	3.2018	15	7	46.7	Парламент	2 танхим	5
9	Андорра	4.2019	28	13	46.4	Парламент	1 танхим	4
22	Беларусь	11.2019	110	44	40	Холимог	2 танхим	4
25	Дани	6.2019	179	71	39.7	Парламент	1 танхим	4
42	Монако	2.2018	24	8	33.3	Парламент	1 танхим	5
50	Суринам	5.202	51	16	31.4	Ерөнхийлөгч	1 танхим	5
53	Вьетнам	5.2021	499	151	30.3	Коммунист	1 танхим	5
54	Сингапур	7.202	104	31	29.8	Холимог	1 танхим	5
59	Ямайка	9.202	63	18	28.6	Парламент	2 танхим	5
61	Лихтенштейн	2.2021	25	7	28	Парламент	1 танхим	4
62	Филиппин	5.2019	304	85	28	Ерөнхийлөгч	2 танхим	3
67	Америкийн нэгдсэн улс	11.202	430	118	27.4	Ерөнхийлөгч	2 танхим	2
76	Тринидад Тобаго	8.202	42	11	26.2	Парламент	2 танхим	5
79	Эстони	3.2019	101	26	25.7	Парламент	1 танхим	4
80	Гэгээн Китс ба Невис	6.202	16	4	25	Парламент	1 танхим	5
81	Туркменистан	3.2018	124	31	25	Ерөнхийлөгч	2 танхим	5

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Квот хэрэгжүүлдэггүй улс орнуудыг бүсээр нь авч үзвэл Европ бүсийн эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт 27.9 хувьтайгаар

хамгийн өндөр байна. (Хавсралт 5. Квот хэрэглэдэггүй улс орнуудын эрэмбэ, бүсээр)

Хүснэгт 2.28. Квот хэрэглэдэггүй улс орнуудын хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн оролцооны дундаж үзүүлэлт, бүсээр

Бүс	Улс орон	Бүсийн дундаж	Тэргүүлэгч улс	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Ази	15	18.3%	Вьетнам	30.3
Америк	12	24.1%	Гренада	46.7
Европ	12	27.9%	Андорра	46.4
Номхон далай	8	8.1%	Фижи	21.6
Ойрх Дорнод	6	4.9%	Сири	11.2
Сахараас урагш Африк	14	13.5%	Сициль	22.9

Эх сурвалж : Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

Энэ бүхнээс үзэхэд сонгуульд нэр дэвшигчдийн дунд аль нэг хүйсийн байвал зохих доод хязгаарыг зааж өгөх буюу квот тогтоох нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн төлөөллийн тэнцвэрт байдлыг хангахад чухал ач холбогдолтой ч үр дүнд шууд хүрэхгүй байна. Учир нь нэр дэвшигчдийн 20 хувь нь эмэгтэй байлаа ч тэдгээр нэр дэвшигч эмэгтэй бүгд сонгогдоно гэсэн үг биш¹¹⁴.

Квотын үр нөлөө нь сонгуулийн тогтолцооноос ихээхэн хамаардаг бөгөөд тухайлбал, нэр дэвшигчийн жагсаалтыг хаалттай гарган суудлыг хувь тэнцүүлэн тооцож, томсгосон тойргоор сонгууль явуулдаг орнуудад хамгийн үр дүнтэй гэдгийг

квотын тогтолцоог амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын туршлага харуулж байна.

Квотыг хэрэгжүүлэх тодорхой арга замыг боловсруулж мөрдөхгүй бол нэр дэвших квотыг 30-50 хувь болголоо ч зорилго биелэх нь учир дутагдалтай. Тиймээс улс төрийн намуудын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт дахь дараалал чухал ач холбогдолтой. Эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийг хэрхэн эрэмбэлэх талаарх тодорхой дүрэм, журамгүй, мөн дагаж мөрдөөгүй тохиолдолд авах арга хэмжээг хуульд тусгаагүй бол квот бэлгэдлийн зүйл болж хувирч¹¹⁵ байгааг олон улсын байгууллагууд дүгнэж байна.

¹¹⁴ Пол Гуэрин, Монгол улсад үзүүлсэн сонгуулийн туслалцааны сургамж 2008-2012. УБ. 2013. НҮБХХ.

¹¹⁵ Ардчилал, Сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон Улсын хүрээлэн. Парламент дахь эмэгтэйчүүд: Тоо ба агуулга. 137 тал.

2.3. УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО

Улс төрийн санхүүжилтийн хувьд зарим улс орнууд улс төрийн намд хуваарилах төрийн санхүүжилтийг эмэгтэй улс төрчдийг дэмжих хөшүүрэг болгон ашигладаг байна. Үүнд гурван үндсэн загвар байна:

1. Тодорхой тооны эмэгтэй нэр дэвшигчийг нэр дэвшүүлээгүй бол төрөөс олгох санхүүжилтийг бууруулах,
2. Шалгуурыг биелүүлсэн намд нэмэлт санхүүжилт олгох,
3. Эмэгтэй нэр дэвшигчийн хувь, тооноос хамааран улс төрийн намд олгох сонгуулийн санхүүжилтийг тодорхой хувиар нэмэгдүүлэн олгох зэрэг болно.

Дээрх арга хэмжээг хуулиар тогтоосон квотыг хэрэгжүүлэхтэй хамтатгах юмуу эсвэл хэрэгжүүлсний дараа хэрэгжилтийг нь урамшуулж өгдөг.

Хуулиар тогтоосон квот хэрэглэж буй улс орнуудын туршлагаас харахад улс төрийн санхүүжилтийг квотын хэрэгжилт төдийгүй үр нөлөөтэй холбож өгсөн байдаг.

Аль нэг улс төрийн нам нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад хуульд заасан квотын шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд төрөөс олгох санхүүжилт, тэтгэмжийг бууруулах, бүрэн хуваарилахгүй байх, торгууль ногдуулах зэрэг хариуцлагыг тусгасан байна. Жишээлбэл:

- Францад улс төрийн намууд хуулиар тогтоосон эмэгтэйчүүдийн төлөөллийн хязгаарт хүрээгүй тохиолдолд санхүүгийн шийтгэл хүлээдэг байна.

- Ирландад улс төрийн нам бүрийн нэр дэвшигчдийн дор хаяж 30 хувь нь эмэгтэй биш тохиолдолд тухайн намд төрөөс олгох татаас 50 хувиар буурдаг байна.
- Португал Улсад улс төрийн намуудын нэр дэвшигчдийн дунд хүйсийн төлөөлөл доод тал нь 33 хувь байх шаардлагыг биелүүлээгүй бол төрөөс авах санхүүжилтийнхээ 25-аас 80 хувийг алдах аюултай байдаг.
- Хорват Улсад улс төрийн намууд нь жендэрийн цөөн төлөөлөл бүхий нэр дэвшигч бүрийнхээ тоогоор төрөөс нэмэлт 10 хувийн санхүүжилт авдаг байна¹¹⁶.
- Солонгос улсад 30-аас дээш хувийн эмэгтэй нэр дэвшигчийг санал болгосон тохиолдолд улс төрийн намууд нийт сонгуулийн эрхтэй хүний тоог 100 воноор үржүүлсэн дүнгээр санхүүждэг. Үүнийг улсын жилийн төсөвт суулгасан байдаг. Нэр дэвшигчдийн бүртгэл дууссаны дараа 2 хоногийн дотор санхүүжилт олгогдоно. (Улс төрийн санхүүжилтийн тухай хууль 27-р зүйл)

Эмэгтэй улс төрчдийг шууд ба шууд бусаар дэмжих олон төрлийн арга хэрэгсэл байдгаас эдгээр дэмжлэгийг хуульчилсан улс орнууд цөөнгүй байна. Жишээлбэл Намуудад очих төсвийн дэмжлэгээс Колумбид 5 хувь¹¹⁷, Чили, Өмнөд Солонгост 10 хувь¹¹⁸, Финляндад 12 хувийг¹¹⁹ тус тус эмэгтэй улс төрчдийг дэмжихэд зарцуулдаг байна.

Бразил, БНСУ, Мексик болон Соломоны

¹¹⁶ Ш. Батсүх, Л. Бямбаханд. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс. 2020 он. Монгол дахь Ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа

¹¹⁷ Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/272641>

¹¹⁸ Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/294691>

¹¹⁹ Political finance. International IDEA. <https://www.idea.int/node/261413>

арлууд гэх мэт улс орнууд сонгуулийн тухай хууль, улс төрийн нам, санхүүжилтийн тухай хуульдаа эмэгтэй улс төрчдийг дэмжих мөнгөн тэтгэлэг, тэдний сургалт хөгжилд зарцуулах үүрэг, сонгуулийн сурталчилгаанд зарцуулах нөхцөл зэргийг хуульчлан тусгасан байна.

Мексикт улс төрийн намууд жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдвөл урамшуулал болгон санхүүжилт авдаг байна. Хэрэв улс төрийн намууд жендэрийн үйл ажиллагаа, эмэгтэй манлайллыг хөгжүүлэхэд зориулагдсан төсвийн хөрөнгийг буруу зарцуулсан бол бүртгэлээс хасагдах, улсын төсвөөс хуваарилсан санхүүжилтийн 50 хүртлэх хувийг алдах эрсдэлтэй байна¹²⁰. Улс төрийн намд тогтмол хуваарилсан улсын төсвийн санхүүжилтийн 3 хувийг эмэгтэй манлайллыг хөгжүүлэхэд зарцуулах ёстой.

Эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих шууд бус

дэмжлэгийг улс орнууд багагүй хэрэглэж байна. Тухайлбал Бразилд 2009 онд нам тус бүрт оногдох олон нийтийн хэвлэл мэдээллээр сонгуулийн сурталчилгааны үнэгүй цагийн багадаа 10 хувийг эмэгтэй нэр дэвшигчдэд зарцуулах, намын нийт сонгуулийн сурталчилгаанд зарцуулах хөрөнгийн 5-аас доошгүй хувийг эмэгтэй нэр дэвшигчдэд зориулах талаар сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна¹²¹. Үүнийг хэрэгжүүлээгүй тохиолдолд нийт зарцуулагдсан зардлын 12.5 хувиар тооцож, торгууль төлөх ёстой.

Сонгуулийн төв байгууллага нь сонгуулийн кампанит ажлын үеэр эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих зорилгоор сонгогчийн боловсролын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 5 минутын сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй ажээ.

¹²⁰ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

¹²¹ Inter-Parliamentary Union, IPU Parline Brazil

2.4. УЛС ОРНУУДЫН САЙН ТУРШЛАГА, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖСЭН БОДЛОГО ХӨТӨЛБӨРҮҮД

Энэхүү судалгааны тайланд нийт 14 орны туршлагыг судлан тусгав. Дараах үндэслэлээр улс орнуудыг сонгосон болно.

Хүснэгт 2.29. Туршлага судалсан улс орнуудыг сонгосон үндэслэл

Бүсчлэл	Улс орон	Сонгосон үндэслэл
Ази	1. Бүгд Найрамдах Солонгос Улс	Эмэгтэйчүүдийн оролцооны хувь үзүүлэлтээр Азийн бүсэд Монгол Улстай хамгийн ойр,хуульчилсан квот хэрэгжүүлдэг.
	2. Узбекистан Улс	Сонгуулийн мажоритар тогтолцоог хэрэгжүүлэгч Ази бүсийн хамгийн өндөр үзүүлэлттэй,шинээр ардчилагдсан орон
	3. Балба улс	Суудал хадгалах квоттой,сонгуулийн холимог тогтолцоог хэрэгжүүлэгч хамгийн өндөр үзүүлэлттэй.
	4. Зүүн Тимор	Хуульчилсан квоттой,пропорционал тогтолцоог хэрэгжүүлэгч,парламентын засаглалтай орнуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй.
Европ	5. Швед	Парламентын засаглалтай,улс төрийн намын сайн дурын квот хэрэгжүүлэгч, пропорционал тогтолцоог хэрэгжүүлэгч орнуудаас эмэгтэйчүүдийн оролцооны хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй улс.
	6. Испани	Хуульчилсан квотын зарчим хэрэгжүүлэгч улс орнуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй улс
Америк	7. Канад	Улс төрийн намын сайн дурын квот хэрэгжүүлэгч хамгийн өндөр үзүүлэлттэй улс
	8. Гайана	Засаглалын холимог хэлбэртэй улс орнуудаас эмэгтэйчүүдийн оролцоогоор хамгийн өндөр үзүүлэлттэй. Үндэстнүүдийн хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудаас Өмнөд Америкийн бүс нутагт оршигч цорын ганц улс
Номхон далай	9. Шинэ Зеланд	Парламентын засаглалтай,улс төрийн намын квот хэрэгжүүлдэг,холимог сонгуулийн тогтолцоотой улс орнуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй
	10.Фижи	Квот хэрэгжүүлдэггүй,пропорционал сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлэгч улс орнуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй улс.
Ойрх Дорнод	11.Арабын Нэгдсэн Эмират	Хууль тогтоох байгууллагад суудал хадгалах квот хэрэгжүүлдэг,мажоритар сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлэгч улс орнуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй улс.
	12.Тунис	Эмэгтэйчүүдийг дэмжих квотыг хуульчлан хэрэгжүүлж байгаа,хамгийн өндөр үзүүлэлттэй улс.
Сахараас урагш	13.Өмнөд	Хуулиар тогтоосон квот хэрэгжүүлэгч хамгийн өндөр үзүүлэлттэй улс.
	14.Кабо-Верде	Квотын зарчмыг хэрэгжүүлдэггүй хэрнээ өндөр үзүүлэлттэй улс.

1. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.30. БНСУ-ын парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт, хууль эрх зүйн зарим мэдээлэл

Он	2000-04	2007-01	2008-04	2012-01	2016-04	2020-04
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	13.04%	14.38%	13.71%	15.67%	17%	19%
Засаглал	Ерөнхийлөгч / 1 танхим					
Квотын төрөл	Хуульд заасан нэр дэвшигчдийн квоттой. Үндэсний ассамблейн 56 мандатын хувьд улс төрийн намууд нэр дэвшигчдийнхээ жагсаалтын 50 хувьд эмэгтэйчүүдийг оруулах ёстой. Ассамблейн орон нутгийн нэг мандаттай 243 тойргийг төлөөлөх гишүүдийг сонгохын тулд улс төрийн намуудад нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувийг эмэгтэйчүүдээр бүрдүүлэхийг зөвлөдөг. (Сонгуулийн тухай хууль 47-р зүйл) ¹²²					
Квотыг хэрэгжүүлээгүй тохиолдолд	Тухайн намын нийт нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгодог. (Сонгуулийн тухай хуулийн 52-р зүйл 2-р заалт) Тодорхой тооны эмэгтэй нэр дэвшигчийг нэр дэвшүүлээгүй бол төрөөс олгох санхүүжилтээ бууруулдаг. (Улс төрийн санхүүжилтийн тухай хууль 27-р зүйл) ¹²³					
Нэрсийн жагсаалт гаргах үйл явц	Пропорционал тогтолцооны хувьд, жагсаалт бүрийн сондгой тоо дээр эмэгтэй нэр дэвшигч байхаар улс төрийн намаас зохицуулалт хийх.					
Төрөөс улс төрийн намд олгох шууд санхүүжилт ба жөндөр	<ul style="list-style-type: none"> 30-аас дээш хувийн эмэгтэй нэр дэвшигчийг санал болгосон тохиолдолд улс төрийн намууд нийт сонгуулийн эрхтэй хүний тоог 100 воноор үржүүлсэн дүнгээр санхүүждэг. Улсын жилийн төсөвт суулгасан байдаг. Нэр дэвшигчдийн бүртгэл дууссаны дараа 2 хоногийн дотор санхүүжилт олгогдоно. (Улс төрийн санхүүжилтийн тухай хууль 27-р зүйл) 					
Улс төрийн намын санхүүгийн зарцуулалт	Нийт санхүүгийн зарцуулалтын 10 хувийг эмэгтэй улс төрчдийн хөгжилд зарцуулдаг байхаар хуульд зааж өгсөн. (Улс төрийн санхүүжилтийн тухай хууль 28-р зүйл) ¹²⁴					
Нэмэлт мэдээлэл	2013 оны 1-р сарын 1 өдөр Сонгуулийн тухай хуулийг шинэчлэн баталсан ¹²⁵ .					

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Солонгос улс төрийн албанд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх стратеги төлөвлөгөө (2018-2022 он) боловсруулан түүний хүрээнд дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

- a) **Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо-эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөр.** Гэрлэлт, жирэмслэлт, хүүхэд, ахмад настанг асрах гэх мэт шалтгаанаар ажилгүй болсон эмэгтэйчүүдэд зориулсан ажилд зуучлах, мэргэжлийн сургалт, дадлага, зөвөлгөө өгөх “Шинэ ажил төв”¹²⁶-ийг орон даяар нийт 158 газар бий болгосон байна. Тус төвөөс эмэгтэйчүүдийг төрийн албанд чиглүүлэх (mentoring), үр чадварыг нэмэгдүүлэх

сургалтуудыг зохион байгуулдаг байна.

- b) **Эмэгтэйчүүдийн тоо болон үр чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр.** Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, эмэгтэй удирдагч нарыг бэлтгэх “Эмэгтэйчүүдийн үр чадварын академи”¹²⁷ байгуулсан. Тус академи нь төрийн өндөр алба хашиж байгаа болон, албан тушаал дэвшигч, горилогч нарын үр чадварыг сайжруулах, манлайлын сургалтыг явуулдаг байна. Мөн орон нутгийн болон нутгийн зөвлөл, албан байгууллага, хамт олныг манлайлах эмэгтэйчүүдийг бэлтгэх семинар, уулзалтыг зохион байгуулдаг байна.

¹²² [Public Official Election Act] (in Korean)

¹²³ <https://www.law.go.kr/법령/정치자금법/11376>

¹²⁴ <https://www.law.go.kr/법령/정치자금법/11376>

¹²⁵ Sun-uk, Kim. 1995. ‘Meaning of the Quota system as a Policy for Women and its Introduction Methods.’ Women’s Studies Forum. 11. pp. 29-54.

¹²⁶ 여성새로일하기센터/새일센터 누리집(saeil.mogef.go.kr)

с) **Эмэгтэй удирдагч нарын нэгдсэн мэдээллийн сан.** Төрийн байгууллагын ажил олгох эрх бүхий албан тушаалтан, байгууллагын удирдлага, улс төрийн намын удирдлагуудад зориулсан эмэгтэй манлайлагч нарын мэдээллийн сан¹²⁸ бий болгосон байна.

д) **“Гэр бүлд ээлтэй төрийн алба” хөтөлбөр.** Төрийн байгууллагууд эмэгтэй албан хаагчдын ажлын цагийн хуваарийг уян хатан зохицуулж болдог байхаар, мөн хүүхэд төрүүлсний дараах амралтыг эхнэр нь төрсөн эрэгтэй албан хаагчид эдлэх боломжтой байхаар зохицуулалт хийсэн байна.

Хүснэгт 2.31. БНСУ-ын Гэр бүл, жендэрийн яамнаас жендэрийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөө

Жендэрийн талаар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	Стратеги
1. Жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, соёлыг дэлгэрүүлэх.	1. Хэвлэл мэдээллийн салбар дахь жендэрийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх. 2. Сургуулийн жендэрийн тэгш байдлын талаарх боловсролыг хөгжүүлэх. 3. Тэнцвэртэй нийгмийн соёлыг өдөр тутамд хэвшүүлэх 4. Жендэрийн эрх тэгш байдлын талаарх иргэний боловсролын үр нөлөөг дээшлүүлэх.
2. Ажил хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бий болгох.	1. Хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг дэмжих 2. Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой жендэрийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх 3. Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн байр суурийг дээшлүүлэх 4. Эмэгтэйчүүдийг карьераа хадгалах, ахиулахад нь дэмжлэг үзүүлэх
3. Эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоог нэмэгдүүлэх	1. Улс төр, төрийн албанд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх 2. Хувийн хэвшилд эмэгтэйчүүдийг төлөөллийг нэмэгдүүлэх 3. Эмэгтэйчүүдийн манлайллын чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах
4. Ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангах нийгмийн дэд бүтцийг бий болгох.	1. Асран халамжлах нийгмийн хариуцлагыг чангатгах 2. Ажил эрхэлдэг эцэг эхийн эрхийг баталгаажуулах 3. Ажлын байранд гэр бүлд ээлтэй соёлыг төлөвшүүлэх
5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс ангид байх, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах.	1. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс ангид байх бодлогыг бэхжүүлэх 2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх олон талын арга хэмжээг сайжруулах 3. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн хамгаалалтыг хүчирхэгжүүлэх. 4. Жендэрт суурилсан эрүүл мэндийн тогтолцооны суурийг сайжруулах
6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын механизмыг бэхжүүлэх	1. Жендэрийн дүн шинжилгээний механизмыг шинэчлэх 2. Жендэрт суурилсан бодлогын чадавхыг бэхжүүлэх 3. Иргэний нийгмийн хамтын ажиллагааны тогтолцоог бий болгож, нэмэгдүүлэх 4. Энх тайван, нэгдлийн үйл ажиллагаа болон олон улсын хамтын ажиллагааг дэмжих

2. УЗБЕКИСТАН УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.32. Узбекистан улсын ерөнхий мэдээлэл

Засаглал	Холимог / Дээд, доод танхим
Сонгуулийн жил	5 (Сүүлийн сонгууль 2019 оны 12-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Олонхи-Мажоритар
Парламентын нийт суудал	147 (48 эм -32.7%)
Квотын төрөл	Хуульд заасан нэр дэвшигчийн квоттой. Улс төрийн намаас нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэй байх ёстой. (Сонгуулийн тухай хуулийн 22-р зүйл-Oliy Majlis) Хууль тогтоох дээд танхим нь нийт 150 гишүүнээс бүрддэг бөгөөд үүнээс 135 нь хоёр тойргийн системээр олонхын саналаар, 15 нь шууд бусаар сонгогддог байна ¹²⁹ . Квотын тогтолцоог 2004 онд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 30 хувиар тогтоосон ¹³⁰ .

¹²⁷ 여성인재아카데미/여성인재 아카데미

¹²⁸ 여성인재 DB 운영 바로가기

¹²⁹ Law on Elections of the Oliy Majlis of the Republic of Uzbekistan, as amended in 2009

¹³⁰ Inter-Parliamentary Union, IPU Parline Uzbekistan

1995 оны 3-р сарын 2 өдөр “Узбекистаны эмэгтэйчүүдийн төр, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Ерөнхийлөгчийн 1084 тоот зарлиг гарч, засаг захиргааны түвшин бүрт “Эмэгтэйчүүдийн хороо байгуулагдсан байна”¹³¹.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа. Эмэгтэйчүүдийн гэр бүл, нийгэмд эзлэх байр суурийг сайжруулах, тэдний хууль ёсны эрхийг хамгаалах, тэдэнд шинэ орлого, бизнес эрхлэх боломжийг өргөжүүлэх, мөн хууль зүйн мэдлэг олгох сургалт, нийгмийн оролцоог дэмжих үйл ажиллагааны чиглэлтэй ТББ-ын тоо Узбекистан улсад 5000 орчимд хүрсэн байна. Эдгээр төрийн бус байгууллагууд хямд төсвөөр, ихэвчлэн сайн дурын үндсэн дээр сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулдаг бөгөөд уян хатан зохион байгуулалттай ажиллаж чаддаг байна.

Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжих чиглэлд Эмэгтэйчүүдийн ТББ-ууд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Тусгаар тогтнолын эхний жилүүдэд байгуулагдсан Бүгд Найрамдах Узбекистан Улсын Эмэгтэйчүүдийн хороо (1991), Эмэгтэйчүүдийн холбоо (1991) “Tadbirkor Ayol” зэрэг эмэгтэйчүүдийн байгууллагууд анхдагчууд бөгөөд засгийн газрын дэмжлэг, идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлэн ажилладаг байна. Тэд Засгийн газраас санхүүгийн дэжлэг авч Засгийн газрын санаачлага, төсөл хөтөлбөрийг дэмжиж нягт хамтран ажиллах үүрэг хүлээдэг байна.

Шилжилтийн дараах үеийн эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх, тэднийг хөгжүүлэх үүргийг ТББ-ууд гүйцэтгэж

ирсэн бөгөөд тэд эмэгтэйчүүдийн карьер хөгжилд тус болох төрийн алба, улс төрийн өргөн хүрээлэл, сүлжээг санал болгосоор иржээ.

Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хоорондын уялдаа, хамаарал байхгүй, давхардал гарах зэрэг алдаа гарсан хэвээр байна¹³².

2003 оны 8 сард өөр өөр орон нутгийн 58 Эмэгтэйчүүдийн ТББ-уудын нэгдэл бүхий Узбекистаны Эмэгтэйчүүдийн ТББ-уудын Холбоо (МЕНР) байгуулагдсан байна. Тус холбооны үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл нь дараахтай адил болно.

1. Эмэгтэйчүүдийн асуудлаарх ТББ-уудын үйл ажиллагааг нэгтгэх, зохицуулах, улс төр, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн ТББ-уудын үүргийг бэхжүүлэх.
2. Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эмэгтэйчүүдийн хөдөлгөөний чадавхыг бэхжүүлэх.
3. НҮБ-ын CEDAW-ийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран конвенцийн хэрэгжилтийн талаарх албан бус тайланг бэлтгэх.
4. Бээжингийн тунхаглал, бусад ижил төстэй олон улсын болон үндэсний баримт бичгүүдийг хэрэгжүүлэх.
5. Эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, мэдээлэл солилцох мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох.
6. Олон улсын байгууллагууд, сангийн хамтын ажиллагаа

¹³¹ Uzbekistan: Country Gender Assessment- ADB, East and Central Asia Regional Department and Regional and Sustainable Development Department 2005.

¹³² Uzbekistan: Country Gender Profile-Final Report Japan International Cooperation Agency (JICA) 2015.

3. ЗҮҮН ТИМОР УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.33. Зүүн Тимор улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь, өсөлт, хууль эрх зүйн зарим мэдээлэл

Он	2007-06	2010-01	2012-07	2017-07	2019-01	2019-03
Эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин	27.69%	29.23%	38.46%	32.31%	40%	38.46%
Засаглал	Парламент					
Сонгуулийн жил	5 жил					
Сонгуулийн тогтолцоо	Пропорционал (2018 оны 5-р сар)					
Парламентын нийт суудал	65 (25 эм -38.5%)					
Сонгуулийн тухай хууль	3 нэр дэвшигч тутамд 1 эмэгтэй нэр дэвшигч байх. (Үндэсний Парламентын сонгуулийн тухай хуулийн 12-р зүйлийн 3-т) ¹³³					
Квотыг хэрэгжүүлээгүй тохиолдолд	Тогтоосон квотыг хэрэгжүүлээгүй тохиолдолд нэр дэвшигчийн жагсаалтыг хүчингүй болгоно ¹³⁴ . (12-р зүйл (3).					
Нэрсийн жагсаалт гаргах үйл явц	3 нэр дэвшигч тутамд 1 эмэгтэй нэр дэвшигч байх. (Үндэсний Парламентын сонгуулийн тухай хуулийн 12-р зүйлийн 3-т)					
Бусад мэдээлэл	Орон нутгийн удирдлага('Suco'), гишүүнд нэр дэвшигчээр эрэгтэй, эмэгтэй ялгаварлалгүйгээр оролцох эрхтэй ¹³⁵ .					

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

- a) **Жендэрийн Нөөцийн Төв.** 2008 онд НҮБ-ын Хүн амын сан, НҮБХХ тусламжтайгаар Жендэрийн нөөцийн төв парламентын дэргэд байгуулагдсан байна. Тус төв нь эмэгтэй улс төрчдийн үр чадварыг үнэлэх, тогтмол сургалт явуулах, гадаадын орнуудын эмэгтэй улс төрчдөд зориулсан улс төрийн сургалтанд хамруулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.
- b) **Улс төр дэх эмэгтэйчүүдийн бүлэг.** Парламентын дэргэд улс төр дэх эмэгтэйчүүдийн бүлэг байгуулагдснаар бусад улс төрчдөд жендэрийн талаарх мэдлэг олгох, жендэрийн талаар сурталчлах боломж нээгдсэн бөгөөд жендэртэй холбоотой хууль тогтоомжуудыг (жишээ: Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль гэх мэт) батлах явц, тайланг олон нийтэд түгээх үйл ажиллагаа явуулдаг байна.
- c) **Тусгаар тогтносны дараах улс төр дэх эмэгтэйчүүдийн манлайлал хөдөлгөөн** 2000 онд тусгаар тогтонолоо олж авахын өмнө конгресс шийдвэр гаргах түвшний бүх байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг 30 хувиас доошгүй байх зорилт тавин ажилласан байна. Эмэгтэйчүүдийн үндэсний сүлжээ болох Rede Feto жендэрийн квотыг бий болгох кампанит ажлыг зохион байгуулсны үр дүнд 2001 оны Үндсэн хуулийн ассамблейн сонгуулийн тэргүүлэх чиглэл болгож чадсан ч квот хуульчлахын оронд пропорционал тогтолцоог хэрэгжүүлэх шийдвэрийг сонгожээ.
- Тиймээс Засгийн газраас Тусгаар тогтносны дараах улс төр дэх эмэгтэйчүүдийг идэвхжүүлэх кампанит ажил өрнүүлсэн байна. Тус хөдөлгөөн нь улс төр дэх эмэгтэйчүүдийн манлайлал, эмэгтэйчүүдийн сүлжээг удирдан зохион байгуулах үр чадварын сургалтыг эрчимжүүлсэн байна.
- Сургалтын агуулгад дараах зүйл хамаардаг байна. Үүнд:
- Сонгуулийн өмнөх богино хугацааны Манлайллын сургалт
 - Улс төр, хуулийн мэдлэг олгох урт хугацааны сургалт
 - Удирдагч бэлтгэх байнгын сургалт болно.

¹³³ UN Women Asia and the Pacific, <https://asiapacific.unwomen.org/en>

¹³⁴ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

¹³⁵ Ballington, J. and Dahlerup, D., 'Gender Quotas in Post-conflict States: East Timor, Afghanistan and Iraq', in D. Dahlerup (ed.), *Women, Quotas and Politics* (New York: Routledge, 2006)

4. БАЛБА УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.34. Балба улсын хууль эрх зүйн зарим мэдээлэл

Засаглал	Парламент / Дээд,доод танхим
Сонгуулийн жил	5 (Сүүлийн сонгууль 2017 оны 11-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Холимог
Парламентын нийт суудал	275 (90 эм -32.7%)
Квотын төрөл	Хууль тогтоох байгууллагад суудал хадгалах квот хэрэгжүүлдэг. Чуулган нь тойрог тус бүрээс сонгогдсон 240 гишүүнээс бүрдэх бөгөөд пропорционал тогтолцооны жагсаалтаар 335 гишүүн сонгогдож, 26 гишүүн нь Сайд нарын зөвлөлөөс томилогддог. (Үндсэн хуулийн 63-р зүйлийн 3) Үүнээс мажоритар тогтолцоогоор нийт нэр дэвшигчийн 33-аас доошгүй хувийг эмэгтэй байхаар бүрдүүлэх ёстой. (Үндсэн хуулийн 63-р зүйлийн 5)
Сонгуулийн тухай хууль	Улс төрийн намууд сонгуулийн пропорционал болон мажоритар, холимог тогтолцоонд зориулан нийт нэр дэвшигчдийн 3 хүн тутмын 1 нь эмэгтэй байхаар жагсаах ёстой. (Constituent Assembly Ordinance 2013) Хэрэв сонгуульд ирүүлсэн нэр дэвшигчийн жагсаалт нь квотын дүрмийг дагаж мөрдөөгүй бол сонгуулийн хороо уг жагсаалтыг буцаах, шаардлага хангаагүй тохиолдолд хүчингүй болгож болно. (Constituent Assembly Ordinance 2013).

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

а) Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, мөрийн хөтөлбөр. Балбын үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих дараах чиглэлийг тусгасан байна. Үүнд:

- Үндэсний болон гадаадын төлөөлөгчийн газарт энх тайвныг бэхжүүлэх үйл явц болох бүхий л хэлбэрийн энхийн хэлэлцээр, албан бус хэлэлцүүлэг, тусгай ажлын хэсэгт эмэгтэйчүүдийг хувь тэнцүүлэн хамруулж, идэвхтэй оролцоог хангах.
- Үндэсний төлөвлөгөөний комисс, сайд нарын зөвлөл, бусад төрийн чухал албаны зөвлөхүүд, албан тушаалтнуудын бүрэлдэхүүн, төрийн механизмын бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангах.
- Эмэгтэйчүүдийг энх тайван, аюулгүй байдал, шүүхийн бүхий л шатлалд идэвхтэй оролцуулах зорилгоор улс даяар чадавхжуулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

- Эмэгтэйчүүдийг сонгуульд нэр дэвшихийг дэмжих¹³⁶.

Тус Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, төрийн бүх түвшинд эмэгтэйчүүдийг оролцоог нэмэгдүүлэх талаар олон заалтууд тусгасан байдаг ч олон улсын гэрээний үүргийг бүрэн дагаж мөрдөхтэй холбоотой зарим зөрүү байсаар байна¹³⁷.

б) Төрийн албанд ажиллах туршилтын хугацааг багасгах. Балбын дээд шүүх засгийн газартаа төрийн албанд ажиллах эмэгтэй албан хаагчдын туршилтын хугацааг багасгаж, эрэгтэй албан хаагчтай адил эрх эдлэх боломжоор хангах шаардлага тавьж¹³⁸ тэр нь биеллээ олсон байна. Энэ нь эмэгтэйчүүдийг төрийн албанд, цаашлаад шийдвэр гаргах түвшинд ажиллах боломжийг нэмэгдүүлсэн байна.

¹³⁶ Ministry of Peace and Reconstruction, National Action Plan on Implementation of UN Security Council Resolutions 1325 and 1820, (2011/2012-2015/2016), 2011

¹³⁷ Promoting Gender Equality and Social Inclusion: Nepal’s Commitments and Obligations. The Asia Foundation. 2019.

¹³⁸ Pro-Public v. Office of the Prime Minister, 2063, 48(1) NKP 1 (2006).

5. ШВЕД УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.35. Швед улсын хууль эрх зүйн зарим мэдээлэл

Засаглал	Парламент / 1 танхим
Сонгуулийн жил	4 (Сүүлийн сонгууль 2018 оны 9-р сарын 5 өдөр)
Сонгуулийн тогтолцоо	Пропорционал
Парламентын нийт суудал	349 (185 эр/164 эм - 47%)
Квотын төрөл	Улс төрийн сайн дурын квот
Социал Демократ нам	Цахилгаан товчны систем (Нэр дэвшигчдийг сөөлжүүлэн байршуулах жагсаалт) (1993). 1978 оноос хойш хэрэгжүүлж ирсэн.
Зүүний нам	Намын жагсаалтад 50 хувиас доошгүй эмэгтэй байхаар 1993 оноос журамласан. Анх 1987 онд нэр дэвшигчийн жагсаалтад квот тогтоосон анхны намуудын нэг.
Ногоон нам	Намын жагсаалтад 50 хувиас доошгүй эмэгтэй байх,+1 ба -1 байж болохоор 1997 онд журамласан. Анх 1987 онд нэр дэвшигчийн жагсаалтад квот тогтоосон анхны намуудын нэг.
Модерат нам	2009 онд Европын парламентын сонгуульд намын жагсаалтаар эхний дөрөвт 2 эмэгтэй, 2 эрэгтэй байхаар тогтоосон.
Төрөөс олгох улс төрийн намын шууд санхүүжилт ба жендэр	Швед Улсын хууль тогтоомжийн дагуу улсын төсвийн 12 хувийг улс төрийн намууд дахь эмэгтэйчүүдийн жигүүрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулахаар тусгасан.

Шведийн ардчилсан намаас бусад Парламентад төлөөлөлтэй бүх нам жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор сайн дурын үүрэг хүлээдэг. Эдгээр нь заавал биелүүлэх шаардлагагүй зөвлөмжөөс авахуулаад намын жагсаалтанд цахилгаан товчны систем хэрэглэх, намын дотоод шаардлага гэх мэт янз бүрийн хэлбэртэй.

Анх улс төрийн намын эмэгтэй гишүүд квотын талаарх санаачилгыг гаргасан¹³⁹. Гэвч квот нь мерит зарчимтай зөрчилдөж байна хэмээн эсэргүүцэгчид мэтгэсний улмаас эмэгтэй гишүүдийн шаардлагыг удаа дараалан хүлээн аваагүй ч 1970-аад онд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн эрчимжиж, хүрээгээ их тэлжээ. Тэд эмэгтэйчүүдийн төлөөлөл доогуур байгаа явдал ардчиллын зарчмыг зөрчиж байна гэх үндэслэлийг гарган тавьж, намууд дотооддоо тодорхой зорилт дэвшүүлэхийг удирдлагаасаа шаардах, намын жагсаалтын дээд хэсэгт илүү олон эмэгтэй нэр дэвшигчийг оруулахыг шаардах, жендэрийн тэгш бус байдлыг арилгахын тулд авч буй арга хэмжээг нь яриулах зорилготой намын албан тушаалтнуудыг оролцуулсан олон нийтийн сонгол явуулах зэрэг ажлыг зохион байгуулжээ.

Энэ өөрчлөлт бий болоход нөлөөлсөн хэд хэдэн хүчин зүйл байсан байна. 1991 онд эмэгтэй парламентчдын хувь 38-аас 33 болж гэнэт буурсан нь Социал демократ намын эмэгтэйчүүдэд цаашид үйл ажиллагаагаа идэвхжүүлэх боломжийг олгожээ. Улс төрийн хүрээний гол эмэгтэй лидерүүд “Шилэн трикотнуудыг дэмж” гэх албан бус феминист сүлжээ байгуулан, улс төрийн намууд өөрчлөлт хийхгүй бол эмэгтэйчүүдийн нам байгуулна хэмээн заналхийлжээ. Сонгууль болохоос 6 сарын өмнө явуулсан олон нийтийн санал асуулгаар Шведийн сонгогчдын 23 орчим хувь нь эмэгтэйчүүдийн намын төлөө санал өгөхөд бэлэн байгаагаа илэрхийлжээ. Социал демократ намын 1993 оны намын их хурлын үеэр энэ аюул илт мэдрэгдсэн бөгөөд намын эрэгтэй гишүүд сонгогчдын хувьд эмэгтэйчүүдийн тогтвортой дэмжлэггүйгээр оршин тогтнох боломжгүй гэдгийг ухамсарласан юм¹⁴⁰. Тиймээс эмэгтэй гишүүд, сонгогчдоо алдах вий гэсэн айдсын улмаас тус нам “цахилгаан товч”-ны системийг нэвтрүүлсэн. Бусад намууд ч намынхаа жагсаалтад эрэгтэйчүүдийн тоотой адил тооны эмэгтэйг дэвшүүлэх үүрэг хүлээжээ.


¹³⁹ Sainsbury, D. 2004. 'Women's Political Representation in Sweden: Discursive Politics and Institutional Presence', *Scandinavian Political Studies*, 27, 1: 65–87.

¹⁴⁰ Sainsbury, D. 2005. "Party feminism, state feminism and women's representation in Sweden", in Lovenduski, J. et al (eds) *State Feminism and Political Representation*, Cambridge: Cambridge University Press, pp. 195-215.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

- a) Улсын хүүхэд асрах бодлого, байгууламжийн хөгжил (1974)
Нийтэд хүртээмжтэй хүүхэд асрах байгууламжийг хөгжүүлэх нь Шведэд хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн дийлэнх хувийг бүрдүүлэх урьдчилсан нөхцөл болсон юм. Швед Улсын Социал демократуудын эмэгтэйчүүдийн холбооноос намын улс төр, орон нутгийн засаг захиргааны ажилд оролцоход нь эмэгтэйчүүдэд туслах зорилгоор хүүхэд асрах тусламж үзүүлж, цалин буурсан тохиолдолд нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна¹⁴¹.
- b) Хүүхэд асрах чөлөөний хүйсийн тэнцвэрт- тэтгэмж (1974) 1974 онд Швед улс хүүхэд асрах чөлөөний тэтгэмжийг хүйс хамаарахгүй олгодог дэлхийн анхны улс болжээ. Энэ бодлого нь жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн чадавхыг хөгжүүлэх, давхар орлоготой гэр бүлийн загварыг дэмжих зорилготой байв. (1 хүүхдийн 480 хоногийн цалинтай чөлөө)

- c) Тусгайлсан салбарын бодлого. Эрх мэдэл, нөлөөллийн тэгш хуваарилалтыг хангах дэд зорилт дэвшүүлэн ажиллаж байгаагийн нэг нь Засгийн газар шийдвэр гаргахад хамгийн их нөлөөлж болох Харилцаа холбоо-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Соёл-кино урлаг, боловсролын салбаруудад жендэрийн эрх тэгш байдлыг хангах, тэдгээр салбарын удирдлагуудад эмэгтэйчүүдийн оролцоо байр суурийг хадгалах, нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- d) “The Power Handbook” гарын авлага¹⁴² Шведэд нийгмийн аль ч бүлэгт “Давамгайлах арга техник, түүнтэй тэмцэх стратеги” гэсэн санааг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэн Шведийн Социал Демократ эмэгтэйчүүдийн үндэсний холбоо (S-kvinnor)-ноос санаачлан “Хүч чадал, эрх мэдэл” нэртэй гарын авлагыг боловсруулан гаргасан байна. Тус гарын авлагыг улс төрийн нам, сургууль, хувийн хэвшил гээд аль ч нийгмийн бүлэгт ашиглаж болохуйц бөгөөд дараах таван ерөнхий тохиолдолд хэрхэх талаар техникийг санал болгодог байна. Үүнд:



Дээрх гарын авлагын дагуу олон хэлэлцүүлэг, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа өрнөсөн бөгөөд үүнтэй холбоотой кино, жүжиг гэх мэт урлагийн бүтээлүүд мөн гарсан байна.

Энэхүү гарын авлагыг улс төрийн намууд

өргөнөөр ашигладаг, хамгийн үр дүнтэй гарын авлага хэмээн үнэлэгдэж ирсэн байна. Нийгмийн аль ч бүлэгт ашиглаж болох, хүртээмжтэй, тэнцвэрт төлөөллийн нийгмийг бий болгоход энэ гарын авлага тус болсон гэж судлаачид дүгнэжээ¹⁴³.

¹³⁹ Sainsbury, D. 2004. 'Women's Political Representation in Sweden: Discursive Politics and Institutional Presence', *Scandinavian Political Studies*, 27, 1: 65–87.
¹⁴⁰ Sainsbury, D. 2005. "Party feminism, state feminism and women's representation in Sweden", in Lovenduski, J. et al (eds) *State Feminism and Political Representation*, Cambridge: Cambridge University Press, pp. 195-215.
¹⁴² <https://s-kvinnor.se/var-politik/political-program/the-power-handbook/>
¹⁴³ European Institute for Gender Equality. *Advancing Gender Equality in Political decision Making- Good practices*. 2016. Page 65.

6. ИСПАНИ УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.36. Испани улсын хууль эрх зүйн зарим мэдээлэл

Засаглал	Парламент / Дээд, доод танхим
Сонгуулийн жил	4 (Сүүлийн сонгууль 2019 оны 11-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Хувь тэнцүүлэх буюу Пропорционал
Парламентын нийт суудал	350 (154 эм -44%)
Квотын төрөл	<ul style="list-style-type: none"> - Хуульд заасан нэр дэвшигчийн квоттой. - Конгрессын сонгуульд нэр дэвшигчийн жагсаалт нь хүйсийн тэнцвэрт харьцаатай байх ба аль нэг хүйсийн нэр дэвшигч нийт 100 гишүүнээс 40-өөс доошгүй хувийг эзлэх ёстой. (Organic Law on Regime of General Elections, Article 44 bis (1)). - Улс төрийн намуудад квотын шаардлагыг хангаагүй жагсаалтыг өөрчлөх богино хугацаа өгдөг бөгөөд шаардлага хангаагүй тохиолдолд Сонгуулийн хороо жагсаалтыг хүчингүйд тооцон батлахгүй болно. (Article 47 (2 and 4)). - Квотыг зөвхөн намын жагсаалтанд төдийгүй тойрог бүрт хэрэгжүүлдэг. Жагсаалт нь 40-60 хувийн тэнцвэрт байдалд аль болох ойр байх ёстой². (Article 44 (2)).
Хууль эрх зүйн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - 2007 оны 3-р сард Эрх тэгш байдлын тухай хуульд (Ley de Igualdad) сонгуулийн тухай хуульд эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдийг тэнцвэртэй байлгах зарчмыг нэвтрүүлэх нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд улс төрийн нам нь нэр дэвшигчийн жагсаалтыг боловсруулахдаа доод танхимд аль нэг хүйсийн төлөөлөл хамгийн багадаа 40 хувь, дээд тал нь 60 хувь байх ёстой гэж заасан. Энэ хуулийг 2008 оны 3-р сард болсон бүх нийтийн сонгуулиар хэрэгжүүлж эхэлсэн байна. - Адил квотын шаардлагыг бүс нутгийн хуулиудад мөн тусгасан бөгөөд 2011 оноос хойш 3000-аас доош оршин суугчтай тосгонд хамаарахгүй болсон байна. Энэ зарчмыг хэрэгжүүлсэн анхны сонгуульд оролцсон зарим мужийн сонгуулийн байгууллагууд дүрмийг дагаж мөрдөөгүй улмаас нэр дэвших эрхгүй болсон байна. - Баск (Basque Country)-д 2005 онд батлагдсан Тэгш эрхийн тухай хуулиар Засгийн газрын бүрэлдэхүүнд аль ч хүйсийн төлөөлөл 40 хувийн квоттой байхаар үүрэг болгосон бөгөөд Улс төрийн намын сонгуулийн жагсаалтад эмэгтэйчүүд нийт нэр дэвшигчийн 50-аас доошгүй хувийг бүрдүүлэх ёстой гэж заасан байна. Мөн улс төрийн намууд өөрсдийн дотоод дүрэмдээ сайн дурын эмэгтэйчүүдийг дэмжих квотыг заасан байдаг³. Жишээ нь: - Испаний Социалист Хөдөлмөрчдийн Нам- Аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх. (Анх 1988 онд 25 хувийн квот тогтоож байсан.) - Зүүний нэгдсэн нам- Аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас хэтрэхгүй байх. - Каталони Социалист Нам- Эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийн харьцаа 40:60 байх. (1982 онд 12 хувь, 1987 онд 15 хувь, 1990 онд 25 хувь, 1996 онд 30 хувь тус тус байсан.) - Ногоон Нам – Эмэгтэй нэр дэвшигч 40 хувиас багагүй байх. (1991 онд 30 хувь байсан.) - Каталони Бүгд найрамдах Зүүний нам- Аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас багагүй байх.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

а) Эмэгтэйчүүдийн эдийн засгийн хөгжил. Испани улс 2007 оны 3-р сард батлагдсан Эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор бусдаасаа ялгарч буй компаниудыг “Тэгш эрхийн шагнал” гэх

урамшууллыг бий болгосон бөгөөд энэхүү шагналыг хүртсэн компаниуд Засгийн газартай хийх зарим төрлийн гэрээ(тендэр, худалдан авах гэх мэт) -нд давуу эрхтэй байх боломжийг бүрдүүлсэн байна. Тус “шагнал”-

¹⁴⁴ Ley orgánica 5/1985, del Régimen Electoral General, 2011 (Last updated: 25 June 2019)

¹⁴⁵ <https://www.idea.int/data-tools/data/gender-quotas>

¹⁴⁶ <http://www.congreso.es/>

ыг авахын тулд хувийн хэвшлийн байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь 40/60 гэсэн хүйсийн харьцаатай байх зарчмыг биелүүлэх хэрэгтэй бөгөөд энэ нь төрийн байгууллагуудад нэгэн адил хамааралтай байв. Ийнхүү хувийн хэвшил дэх удирдах түвшний эмэгтэй албан хаагчдыг нэмэгдүүлэх нь эмэгтэйчүүдийн манлайллын үр чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн дэмжлэг болно гэж үзсэн байна.

b) Улс төрийн намын дотоод шинэчлэл. Олон судлаачид (e.g. Gallego Mйndez & Durбn 1994; Martнnez-Hernбndez & Elizondo 1997; Barbadillo et al 1990; Federaciyn de Mujeres Progresistas 1996; Threlfall 2005) Испанид шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь Испанийн Социалист Ажилчны намын квот хэрэгжүүлэх шийдвэрийн үр нөлөө мөн гэдэгтэй улс төрчид нь санал нийлдэг байна. Улс төрийн намуудаас эмэгтэйчүүдийг дэмжих, квотын зарчим болон бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх алхам амаргүй байсан юм. Харин нам доторх фракц, эмэгтэйчүүдийн лобби бүлэг, намуудын хоорондох эмэгтэйчүүдийн албан бус холбоо, сүлжээнүүд нэлээдгүй хүчин чармайлт гаргасан байна.

Испаний Социалист нам үндэсний түвшинд намын дотрох шийдвэр гаргах үйл явц, удирдлагыг сонгох журам зэрэг дотоод механизмдаа дүн шинжилгээ хийх зарчмыг нэвтрүүлсэн байна. Энэ нь нэр дэвшигчдэд тэгш боломж, тэгш эрхийг бий болгоход чухал хувь нэмэр болсон байна.

Мөн зарим намын удирдагчид эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлснээр намаа шинэчлэх, “шинэ цус” сэлбэх нэг төрлийн шийдэл гэж үзсэн байна. (A. Navarro 2000: 25)

c) Улс төрийн намаас сайн дурын үндсэн дээр квот тогтоосон туршлагын үр дүн-Аажим өсгөх арга барил. Испанид сонгуульт албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх “түргэвчилсэн” бус харин “шат дараалсан” арга хэмжээ авч хэрэгжүүлжээ.

1979 онд парламентын суудлын зөвхөн 5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байжээ. Хуулиар жендэрийн квот нэвтрүүлсний үр дүнд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 2007 онд 36 хувь болтлоо өссөн байна.

Олон нийт, намын гишүүдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ, намын эмэгтэйчүүдийн байгууллага, иргэний нийгмийн тэмцэгчдийн нөлөөллийн үйл ажиллагаа, олон улсын эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, үйл ажиллагаанд намаас идэвхтэй оролцох зэрэг үйл ажиллагааг сайн дурын квоттой хослуулсны үр дүнд энэ өөрчлөлт гарчээ.

Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулахын төлөөх улс төрийн хөдөлгөөний тэргүүн шугамд Испанийн Социалист ажилчдын намын (ИСАН) эмэгтэйчүүдийн байгууллага ажиллаж байсан бөгөөд нам, түүний удирдах тогтолцоонд жендэрийн харьцаа тэнцвэргүй байгааг судалгаагаар нотолж, бусад улс орнуудын социалист намтай харьцуулахад ИСАН энэ талаараа хол хоцорч яваа гэдгийг сануулан, намын квот нэвтрүүлэх талаар 1980-аад оны дунд үед лобби хийж байжээ. Түүнчлэн ИСАН-ын эмэгтэйчүүдийн байгууллага сайн дурын квотын талаар намын гишүүдийн дунд санал асуулга явуулахад 67 хувь нь дэмжсэн байна. ИСАН болон Коммунист нам 1980 оны сүүлээр намын жагсаалтын 25 хувийг эмэгтэйчүүдэд олгох намын квот баталсан байна. .

Испанийн жендэрийн эрх тэгш байдлын төлөө тэмцэгчдийн явуулсан олон нийтийг гэгээрүүлэх аян болон иргэдийн 60 гаруй хувь нь ийм арга хэмжээг дэмжинэ гэсэн судалгааны дүн нь намын эмэгтэй гишүүдэд урам зориг өгсөн байна. Намын төв байгууллагад эрх мэдэл төвлөрсөн байдаг учраас бүсийн болон орон нутгийн сонгуульд ч квот тогтоохыг үүрэг болгожээ.

1994 онд ИСАН ялалт байгуулах магадлалтай тойргуудыг эмэгтэйчүүдэд хуваарилах шинэ заалтыг нэмж, квотын журмыг улам сайжруулсан байна. Намын эмэгтэй гишүүдийг улс төрийн маркетинг хийх, үр чадвар сайжруулах сургалтад хамрагдахыг хөхүүлэн дэмжих замаар эмэгтэй нэр дэвшигчдийн “нийлүүлэлт”-ийг дээшлүүлэх арга хэмжээ авчээ. 1997 онд ИСАН сөрөг хүчин байхдаа намын нэр дэвшигчдийн жагсаалтад аль ч хүйсийн төлөөллийг 40 хувиас доошгүй байлгах талаар жендэрийн хувьд төвийг сахисан өөрчлөлтийг намын дүрэм журамдаа оруулжээ. Эрх барьж буй Эмэгтэйчүүдийн Европын дээд хэмжээний уулзалт (1992 онд Афинд болсон), Социалист Эмэгтэйчүүдийн Интернационал цуглаан

зэрэг олон улсын, европын төрөл бүрийн үйл ажиллагаанд намын гишүүд идэвхтэй оролцож байсан болон 1995 онд Бээжингийн үйл ажиллагааны хөтөлбөрийг НҮБ-аас баталсан нь дээрх ахиц дэвшил гарахад нөлөөлсөн гэж үздэг.

Мөн ийм квотыг Коммунист намаас төрж гарсан Нэгдсэн зүүний холбоо 1997 онд шуурхай баталсан байна. Дараачийн 10

жилд нь “нам хоорондын халдвар” дэгдэж Нийтийн нам зэрэг илүү консерватив намуудыг оролцуулан Испанийн бүхий л том намууд квотын талаар төстэй шийдвэр гаргажээ. Үүнээс хойш эмэгтэйчүүдийг улс төрийн шат ахиулахыг дэмжиж Испаний гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлын талаар цогц хууль тогтоомж, бодлого, стратегийг батлан гаргасан байна¹⁴⁷.

7. БҮГД НАЙРАМДАХ ЛИТВА УЛСЫН ТУРШЛАГА

1998 онд Европын Холбоонд элсэх, Холбооны жендэрийн эрх тэгш байдлын талаарх удирдамжийг хэрэгжүүлэхийн тулд Литвад жендэрийн эрх тэгш байдлыг хангах “Эмэгтэй, эрэгтэйчүүдийн тэгш боломжийн тухай хууль”-ийг анх баталсан байна. Энэ нь Төв ба Зүүн Европдоо анхдагч байв. Тус хуулинд бүх салбарын ажил олгогч нь хүйсийн тэгш байдлыг хангах үүрэгтэй, ялгаварлан гадуурхах үйлдлийг хориглох тухай заалтуудыг тусгасан байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас 2018-2021 онуудад “Эмэгтэй, эрэгтэйчүүдийн тэгш боломжийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2015-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан бөгөөд энэ хөтөлбөрийг хойшид үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байна¹⁴⁸.

Литвийн Статистикийн газрын 2018 судалгаагаар боловсролын түвшин эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд өндөр хэдий ч төрийн чухал шийдвэр гаргахад эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд оролцсон гэж дүгнэсэн байна¹⁴⁹. Үүнээс эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд оролцоход тэдний үр чадвар дутагдаж байгаас гадна мэргэшсэн эмэгтэйчүүдийг албан тушаал ахиулах, тэднийг үнэлэх явцад жендэрийн ялгаварлан гадуурхах үзэгдэл байна. Мөн сонгогчид болон олон нийт шийдвэр гаргах түвшин

дэх эмэгтэйчүүдэд үл итгэх байдал байсаар байна гэж дүгнэсэн байна¹⁵⁰. Эдгээр асуудал дэлхийн ихэнх улс орнуудад төдийгүй Литва улсад асуудал хэвээр байсаар байна. Хэдий хууль эрх зүйн таатай орчин бүрдсэн хэдий ч бодит байдалд хангалттай үр дүнд хүрч чадахгүй байна. Тиймээс БНЛУ-ын эрх бүхий байгууллагуудыг тэгш боломжийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад хотын захиргааг оролцуулахаас эхлээд шинэлэг шийдлүүд эрэлхийлэх, практик хэрэгжилтэд илүү идэвхтэй санал, санаачлагыг өрнүүлэхээр ажиллаж байна.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

“Улс төрд илүү олон эмэгтэйчүүд” төсөл. 2001 оны 6-р сарын 15-17 ны өдрүүдэд Вильнюс хотод болсон “WoMen ба ардчилал” сэдэвт бага хурлын үеэр санаачилсан “Улс төрд илүү олон эмэгтэйчүүд” төслийг 2002 оны 3-р сард КАУНАС эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн төв SIDA-гийн тусламжаар хэрэгжүүлэн эхэлсэн байна. Уг төсөл нь улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог идэвхжүүлэх, тоог нэмэгдүүлэх зорилготой бөгөөд төслийн хүрээнд эмэгтэйчүүдэд манлайллын

¹⁴⁷ “Улс төрийн албан тушаалд жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох талаарх Өмнөд Европын зохицуулалт: Грек, Португал, Испанийн туршлага” (Regulating Gender Equality in Political Office in Southern Europe: The Cases of Greece, Portugal and Spain, Tania Verge, Paper Prepared for the 3rd European Conference on Politics and Gender, Universitat Pompeu Fabra, Barcelona, 21–23 March 2013).

¹⁴⁸ Order on the approval of the 2018–2021 Action Plan for the Implementation of the 2015–2021 National Programme on Equal Opportunities for Women and Men, pub. L. No. No. A1-331 (Minister for Social Security and Labour of the Republic of Lithuania 2018). (25.03.2019).

¹⁴⁹ Women and Men in Lithuania 2017. (25.03.2019)

¹⁵⁰ Profeta, Paola. “Gender Equality in Decision-Making Positions: The Efficiency Gains.” *Intereconomics*. February 1, 2017. <https://archive.intereconomics.eu/year/2017/1/gender-equality-in-decision-making-positions-the-efficiency-gains/#footnote-32050-7>.

зөвлөгөө, тэдний сүлжээг өргөжүүлэх, чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан байна. Судлаачид Уг төсөл нь Европын парламентын сонгуульд хувь нэмэр оруулж чадсан бөгөөд

төслийн үр дүнд 2004 онд нийт 13 мандатаас 6 эмэгтэй сонгогдсон байна. Мөн энэ онд болсон Ерөнхийлөгчийн сонгуульд эмэгтэй хүн нэр дэвшсэн явдал байлаа¹⁵¹.

8. КАНАД УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.37. Канадын улс төрийн зарим мэдээлэл

Сонгуулийн тогтолцоо	Олонхи- Мажоритар
Парламентын нийт суудал	338 (100 эм -29.6%)
Квотын төрөл	Улс төрийн нам доторх сайн дурын квоттой.
Шинэ Ардчилсан нам	Шинэ Ардчилсан нам 1985 онд Сонгуульд нэр дэвшигчдийн 50 хувь нь эмэгтэй байхаар журам тогтоосон байна. 1985 онд ҮАН -аас сонгуульд нэр дэвшигчдийнхээ 50 хувь нь эмэгтэйчүүд байх зорилт тавьсан. Нэр дэвших “сунгаа” -ны явц бүрт дор хаяж нэг эмэгтэй байхаар тогтож,энэ нь одоо хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.
Канадын либерал нам	Тус нам нь нэр дэвшигчийн 25 хувь нь эмэгтэй байхаар 1993 онд журамласан байна.
Бусад мэдээлэл	Эмэгтэй төлөөллийн талаарх бодлогын хувьд улс төрийн намууд харилцан адилгүй байдаг бөгөөд Шинэ Ардчилсан нам,Либерал нам болон Ногоон намууд эмэгтэй төлөөллийг дэмжсэн бодлого элбэг байхад Консерватив намд ийм бодлого байдаггүй байна ¹⁵² . 1997 онд сонгуулийн жөндөрийн тэгш байдлын талаарх санал баруун хойд нутгийн өөрөө удирдах бүс болох Нунавут хотод бүх нийтийн санал асуулга явуулав. Сонгогчид “Нунавут мужийн анхны хууль тогтоох ассамблейд эрэгтэй,эмэгтэй гишүүдийн тоо тэнцүү байх ёстой бөгөөд нэг тойрог бүрийг төлөөлж нэг эрэгтэй,нэг эмэгтэй сонгогдох ёстой юу?” Гэсэн асуултад “тийм” эсвэл “үгүй” гэсэн санал өгөхөөс сонгогчдын 57 хувь нь “Үгүй” буюу татгалзсан хариулт өгсөн байна. Хэрэв энэ санал батлагдсан бол 10,11 тойрог тус бүрээс нэг эмэгтэй,нэг эрэгтэй сонгогдох бөгөөд сонгогч бүр эмэгтэйчүүдийн жагсаалтаас нэг,эрэгтэйчүүдийн жагсаалтаас нэг гэж хоёр хайрцгийг тэмдэглэх ёстой болох байлаа.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Эмэгтэй оюутан сурагчдад зориулсан аялал. 2001 оноос эхлэн Women in House байгууллага эмэгтэй оюутнуудад Канадын улс төрийн тогтолцоо, орчин нөхцөлийг танилцуулах аяллыг зохион байгуулсаар ирсэн байна. Энэ аяллаар эмэгтэй оюутнууд улс төрийн нэрт эмэгтэй зүтгэлтэн, улс төрч нартай чөлөөт уулзалт хийх, ажлын байраар нь зочлох боломж олгодог байна.

Эмэгтэй нэр дэвшигчдийн гаргасан зардлыг нөхөн олгох. Канадын Шинэ ардчилсан нам эмэгтэй болон үндэстний цөөнхөөс гаралтай

нэр дэвшигчдэд нэр дэвших үеийн хүүхэд асрах зардал болон алс хол байрлалтай газарт очиж ажиллах зардалд тус бүр 500 канад доллар, Шинэ ардчилсан намаас сонгогдсон төлөөлөгч тэтгэвэрт гарах болсон тойрогт өрсөлдөх тохиолдолд 500 канад долларын нөхөн олговор өгөх санхүүгийн туслалцааны хөтөлбөр хэрэгжүүлдэг. Ийм хөтөлбөр нь зөвхөн сонгуулийн сурталчилгааны зарим зардлыг нөхөн олгох төдий бус хувийн амьдрал, ажлын үүрэг хариуцлагаа тэнцвэржүүлэхэд ач холбогдолтой байдаг¹⁵³.

¹⁵¹ <https://www.un.org/womenwatch/daw/Review/responses/LITHUANIA-English.pdf>

¹⁵² OSCE/ODIHR Election Misson Assessment Final Report 2015.

¹⁵³ Lisa Young, Chapter on Campaign Finance and Women’s representation in Canada and the United States in Fund- ing of Political Parties and Election Campaigns in the Americas. Stockholm: International IDEA, 2005, p.137.

9. ГАЙАНА УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.38. Гайана улсын улс төрийн зарим мэдээлэл

Засаглал	Холимог / Дээд танхим
Сонгуулийн жил	5 (Сүүлийн сонгууль 2020 оны 3-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Пропорционал
Парламентын нийт суудал	70 (25 эм -35.7%)
Квотын төрөл	Хууль тогтоох дээд байгууллагад суудал хадгалах зарчим хэрэгжүүлдэг.
Сонгуулийн тухай хууль	Улс төрийн намуудаас нийт нэр дэвшигчийн жагсаалтаас эмэгтэй нэр дэвшигч нь гуравны нэгээс багагүй байх ёстой. (Section 11B,Art,5); Тухайн тойрогт өрсөлдөж байгаа намуудын нэрсийн жагсаалтад орсон эмэгтэйчүүдийн нийт тоо жагсаалтад багтсан нийт нэр дэвшигчийн гуравны нэгээс багагүй байх. (Section 11B,Art. 6); Эмэгтэй нэр дэвшигчгүй нам нь нийт сонгуулийн тойргийн 20 хувиас хэтрэхгүй байх. (Section 11B,Art. 7)
	Хэрэв нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт шаардлага хангасан эсэхийг Сонгуулийн төв байгууллага нь сонгуулийн өдөр болохоос 30 хоногийн өмнө илрүүлж, төлөөлөгчид мэдэгдэх. (Section 14,Art. 1); Хүйсийн шаардлага хангаагүй нэрсийн жагсаалтыг сонгууль болохоос 29 хоног өмнө засварлаж болно. (Section 15);

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Гайанагийн Эмэгтэйчүүдийн Манлайллын Институт (GWLl). Жендэрийн асуудал эрхэлсэн Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг Гайанагийн Эмэгтэйчүүдийн Манлайллын Институт (Guyana Women's Leadership Institute (GWLl)) байгуулан сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 480 гаруй эмэгтэйчүүдэд дараах сургалтыг явуулсан байна. Үүнд:

- Манлайлал
- Байгууллагын чадамж, хөгжүүлэлт
- Улс төрийн боловсрол, хууль эрх зүйн сургалт
- Улс төр ба жендэр

- Төрийн алба дахь жендэрийн эрх тэгш байдал
- Эмэгтэйчүүдийн нүдээр улс төр, төрийн алба
- Жендэрийн боловсрол
- Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт
- Баг бүрдүүлэн амжилтанд хүрэх гэх мэт сургалтын агуулгаар улс даяар төрийн алба, улс төрийн карьер төлөвлөж байгаа эмэгтэйчүүдэд зориулан манлайллын үр чадвараа дээшлүүлж, шийдвэр гаргах түвшинд идэвхтэй оролцох боломжийг олгодог байна¹⁵⁴.

10. ШИНЭ ЗЕЛАНД УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.39. Шинэ Зеланд улсын улс төрийн зарим мэдээлэл

Засаглал	Парламент / 1 танхим
Сонгуулийн жил	3 (Сүүлийн сонгууль 2020 оны 10-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Холимог
Парламентын нийт суудал	120 (62 эр/58 эм -48.3%)
Квотын төрөл	Улс төрийн намын доторх квот
Ногоон нам	2015 онд Ногоон нам 50/50 хувийн квотыг баталсан байна. “Засгийн газарт, Ногоон кабинетын сайд нарын тал хувь нь эмэгтэйчүүд байх болно”
Хөдөлмөрийн нам	Намын үндсэн дүрмийн 8.47 зүйлд Зохицуулах хороо нь жагсаалтыг тодорхойлохдоо 50 хувь нь эмэгтэйчүүд байхаар тогтооно гэж заасан байна.

2020 онд болсон сонгуулиар парламент болон Засгийн газрын аль алинд эмэгтэйчүүдийн төлөөлөл эрс нэмэгдсэн нь сонгогчид цар тахлын үед нийгмийн олон салбарт эмэгтэйчүүдийн төлөөлөл хэрэгтэй гэж үзсний үр дүн гэж үзэж байна¹⁵⁵.

Сонгогчид Ковид цар тахлын хариу урвалд чадварлаг, үр дүнтэй удирдсан гэж үзэж дахин ерөнхий сайдаараа эмэгтэй хүнийг сонгосон байна.

Шинэ Зеланд улс парламентаа олон талт төлөөллөөр бүрдүүлж чадсан улсуудын нэг юм. Жишээлбэл, нийт парламентын 48 хувь нь эмэгтэйчүүд, 11 хувь нь ЛГБТК, Маори үндэстэний төлөөлөл 21 хувь тус тус бүрдүүлсэн байна.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:


Эмэгтэйчүүдийн яам. Шинэ Зеланд улс олон талт төлөөлөл бүхий Засгийн газрыг бүрдүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд нийгмийн аль ч түвшин, салбарт олон үндэстний төлөөлөл, цагаач, дүрвэгсэдээс эхлээд хүйс, арьс өнгөний төлөөлөл бүрээс бүрдсэн орчныг бүрдүүлэх аянг орон даяар эхлүүлээд удсан байна.

Эмэгтэйчүүдийг удирдах болон шийдвэр гаргах түвшинд илүү идэвхтэй байлгах нь “олон талт төлөөллийн нийгэм”-ийг бий болгох чухал алхам гэж үздэг байна. Энэ агуулгын хүрээнд олон төрлийн ажлын байрны сургалт, манлайллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн байна.

Шинэ Зеланд улсын Эмэгтэйчүүдийн яам шинээр гарч ирж буй эмэгтэй удирдагч нар авьяас, үр чадвараа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох үндсэн үүргийг гүйцэтгэж иржээ. Яам нь Эмэгтэй удирдагч нарын сүлжээг өргөжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын удирдлагуудтай нягт хамтарч ажилладаг байна. Жишээ нь төрийн байгууллагуудын удирдах түвшин дэх томилгоо, сонгон шалгаруулалтанд санал болгох/дэмжлэг үзүүлдэг байна.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийн тэгш боломж, эмэгтэйчүүдийн бодлогын талаар төрийн байгууллагуудад арга зүйн зөвлөмж, мэдлэгээр хангаж, жил бүр шагналын цуврал хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд олон нийтэд мэдээлэл түгээн ажиллаж байна¹⁵⁶.

Тус яам нь дараах тэргүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.



¹⁵⁴ Guyana National Report, The Twenty-Fifth Anniversary of the Fourth world Conference on Women and Adoption of the Beijing Declaration and Platform for Action (2005). Page 35.

¹⁵⁵ Олон улсын парламентын холбоо, Парламент дахь эмэгтэйчүүд, 2021.

¹⁵⁶ Enabling women’s potential- The social, economic and ethical imperative. A White Paper from the National Council of Women of New Zealand. 2015.

Эмэгтэйчүүдийн манлайлын үр чадварыг хөгжүүлэх. “Шинэ Зеландын Засаглал” (Governance New Zealand, Inc.) нэртэй хувийн байгууллага засаглалыг сайжруулах зорилгоор төрийн албан хаагч нарын мэргэжил дээшлүүлэх, арга зүйн зөвлөмжөөр хангах чиг үүргийг гүйцэтгэдэг байна. Тэд Эмэгтэйчүүдийн манлайлын үр чадварыг хөгжүүлэх замаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор 2015 онд “Шинэ Зеландын Эмэгтэйчүүдийн зөвлөл” байгуулсан байна. Тус зөвлөл нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжин төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны сайн жишээг үзүүлж байна.

Удирдах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, дараагийн үеийн эмэгтэйчүүдийг бэлтгэхэд Засгийн газар чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- Засгийн газрын цахим хуудсаар Эмэгтэйчүүдийн зөвлөл, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулдаг.
- Жендэрийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх мэргэжлийн дэмжлэг байгууллагуудад өгдөг.
- Жил бүр Эмэгтэйчүүдийн зөвлөлийн чуулга уулзалт, шилдэг эмэгтэй удирдагчийн шагнал гардуулах ёслолыг зохион байгуулдаг байна.

Тус зөвлөл нь мөн Олон улсын байгууллага, засгийн газруудтай өргөн харилцаа, хамтын ажиллагаатай үйл ажиллагаа явуулдаг байна. Жишээ нь, Арабын Нэгдсэн Эмират Улсын Жендэрийн Тэнцвэрийн Зөвлөлтэй жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хамтран боловсруулдаг байна¹⁵⁷.

11. ФИЖИ УЛСЫН ТУРШЛАГА

Хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр:

Хүснэгт 2.40. Фижи улсын улс Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөс¹⁵⁸.

<p>Зорилт 1: Үндэсний болон орон нутгийн шийдвэр гаргах түвшинд сонгогдсон буюу томилогдсон эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх.</p>	<p>Үйл ажиллагаа 1.1. Парламент болон олон нийтийн зөвлөл,хороонд 50 хүртлэх хувиар эмэгтэйчүүдийн төлөөллийг эрхийг баталгаажуулах хууль тогтоомж батлах</p> <p>Үйл ажиллагаа 1.2. Фижигийн засаг захиргаа болон асуудал хариуцсан зөвлөл жендэрийн тэгш байдлын талаар бодлого хөгжүүлэх.</p> <p>Үйл ажиллагаа 1.3. Төрийн албаны зөвлөл нь төрийн байгууллагуудын удирдах зөвлөл,хороодын сул орон тоог олон нийтэд сурталчлах.</p> <p>Үйл ажиллагаа 1.4. Үндэсний болон орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх</p> <p>Үйл ажиллагаа 1.5. Үндэсний болон Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийг дэмжих хөрөнгийг босгох.</p>
<p>Зорилт 2: Улс төрийн намын удирдах түвшин дэх эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх</p>	<p>Үйл ажиллагаа 2.1. Эмэгтэйчүүдийн эрх,жендэрийн асуудлыг дэмжих үүрэг амлалтыг биелүүлэхийг шаардах.</p>
<p>Зорилт 3. Удирдагч эмэгтэйчүүдийн жендэрийн эрх тэгш байдал,хүний эрх,хуулийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх</p>	<p>Үйл ажиллагаа 3.1. Жендэр,хүний эрх,хууль тогтоомжийн талаар нэгдсэн суртал ухуулгын ажлыг эхлүүлэх.</p>
<p>Зорилт 4. Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох</p>	<p>Үйл ажиллагаа 4.1. Одоогийн сонгуулийн тогтолцоог хянаж,сонгуулийн тогтолцоонд жендэрийн шинжилгээ хийх.</p>
<p>Зорилт 5: Төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангах.</p>	<p>Үйл ажиллагаа 5.1. Жендэрийн тэгш байдал,эмэгтэйчүүдийн эрхийг хангах талаар төрийн албаны удирдах албан тушаалтнуудын сүлжээг бэхжүүлэх.</p>

¹⁵⁷ Women on Boards New Zealand A Division of Governance New Zealand

¹⁵⁸ National Plan of Action (2014) cited in Fiji Women's Crisis Centre

Эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөн. 1980 онд өрнөсөн Фижи эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөн нь хэд хэдэн чухал үр дүн авч ирсэн бөгөөд олон санал санаачлага хэрэгжиж эхэлсний нэг нь улс төрийн намуудын бодлогод жендэрийн аудит хийх санаачлага юм¹⁵⁹. Тус санаачлагыг улс

төрийн намууд хэрэгжүүлснээр эмэгтэйчүүд улс төрийн төлөөлөлд түүштай хандах хандлага, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн нэр хүндэд сайнаар нөлөөлсөн хэмээн олон судлаачид үздэг байна¹⁶⁰.

12. АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.41. АНЭУ-ын улс төрийн зарим мэдээлэл

Засаглал	Хаант / Дээд танхим
Сонгуулийн жил	4 (Сүүлийн сонгууль 2019 оны 10-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Олонхи-Мажоритар
Парламентын нийт суудал	40 (20 эм -50%)
Квотын төрөл	Хууль тогтоох байгууллагад суудал хадгалах квотын зарчим хэрэгжүүлдэг.
Үндсэн хууль	“Төрийн алба нь бүх иргэдэд тэгш боломжийн үндсэн дээр нээлттэй байх ёстой. Төрийн албан хаагч нь итгэмжлэгдсэн, төрийн үйлчилгээг үзүүлэгч мөн бөгөөд зөвхөн нийтийн эрх ашгийн төлөө ажиллах ёстой.” Article 35,
Бусад мэдээлэл	АНЭУ -ын парламентын зөвлөлдөх байгууллага болох Холбооны Үндэсний Зөвлөлийн (FNC) 50% -ийг эмэгтэйчүүд эзэлдэг. ОУВС -гийн Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн эмхэтгэлд 2020 онд Арабын Нэгдсэн Эмират Улс эмэгтэй парламентын төлөөлөгчийн индексээр эхний байрыг эзэлжээ ¹⁶¹ .

Арабын Нэгдсэн Эмират улсад Эмэгтэйчүүдийн оролцоо төрийн албанд хүчтэй байна. Эмэгтэйчүүд төрийн албан тушаалын гуравны хоёрыг эзэлдэг бөгөөд 30% нь удирдах албан тушаалд, 15% нь техникийн болон эрдэм шинжилгээний чиглэлээр ажилладаг байна.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Хууль тогтоомжийн шинэчлэл. Дэлхийн банкнаас гаргасан 2021 оны “Эмэгтэйчүүд-Бизнес ба хууль” тайланд Арабын нэгдсэн Эмират Улс тэргүүлсэн байна. АНЭУ эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн 20 гаруй хууль тогтоомжийн шинэчлэлийн сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн байна.

Арабын Нэгдсэн Эмират Улсын Жендэрийн тэнцвэрийн зөвлөлийн ерөнхийлөгч Шейха Манал бинт Мохаммед бин Рашид Аль Мактум хэлэхдээ, Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог дэмжих нь эмэгтэйчүүдийг бүх талбарт идэвхтэй хамруулах үндэс юм гэсэн байна¹⁶².

Амжилттай эмэгтэйчүүдийг олон нийтэд сурталчлах. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан байгууллагадаа амжилт гаргасан, нийгэмдээ гавьяатай үйлс хийсэн эмэгтэйчүүдийг эерэгээр сурталчилан, алдаршуулдаг байна.

Удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийг олон нийтэд таниулан, жендэрийн хэвшмэл ойлголтыг халахад

¹⁵⁹ George, Nicole. 2012a. “Lost in Translation, Gender Violence, Human Rights and Women’s Capabilities in Fiji.” Unpublished paper.

———. 2012b. *Situating Women: Gender Politics and Circumstance in Fiji*. Canberra: ANU E-Press.

¹⁶⁰ Lee, Sun Hee, 2009. *Women in Politics: Fiji, the Solomon Islands and Van- uatu*, Centre for Democratic Institutions, ANU, April 1, located at http://www.cdi.anu.edu.au/AP/2008-09/D_P/2009_02_FA_PAC_WiP_SL_Mel_Visit/2009_03_PAC_REP.pdf.

¹⁶¹ Вашингтон дахь Арабын Нэгдсэн Эмират улсын элчин сайдын яамны цахим хуудас. <https://www.uae-embassy.org/about-uae/women-uae>

¹⁶² The United Arab Emirates Government Portal, Women-News <https://u.ae/en/#/>

нийгмийн сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл чухал үүрэгтэй байдаг. Шийдвэр гаргах түвшин, улс төрийн карьер, эрх мэдэл, албан тушаалыг дагаад олон нийтийн шүүмжлэл, сөрөг хариу үйлдэл, үг хэллэг тохиолдох нь элбэг байдаг.

Энэ зүйл дээр оролцогч талуудын өргөн хүрээтэй гэрээ байгуулан эмэгтэйчүүдийн эсрэг сонгуулийн хүчирхийллийг бууруулах үр дүнтэй стратеги боловсруулан ажилласан байна.

Удирдах албан тушаалд ажиллаж байгаа албан тушаалтны нэгдсэн мэдээллийн сан. Шийдвэр гаргах түвшний албан хаагч нарын мэдээллийг хүйсээр гаргаж монитор хийж эхэлсэн бөгөөд Энэхүү нэгдсэн мэдээллийн санг нээлттэй болгосноор “Эрэгтэйчүүд ачаалал даах, шийдвэр гаргах чадвар эмэгтэйчүүдээс илүү байдаг” гэсэн жендэрийн өрөөсгөл хандлагад үндэслэсэн хүний нөөц бүрдүүлэлт, томилгоо, албан тушаал ахиулах зэрэгт хяналт тавих боломжтой болсон байна.

Жендэрийн нөлөөллийн үнэлгээ. Арабын Нэгдсэн Эмират Улсад эмэгтэйчүүдийн зөвлөлийг санаачлах ажлыг Дубайн Эмэгтэйчүүдийн Байгууллага (орон нутгийн засаг захиргааны байгууллага) 2014 онд эхлүүлсэн бөгөөд удирдах түвшний эмэгтэйчүүдийн төлөөллийг хязгаарлаж буй бодлогын саадыг тодорхойлох, эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд идэвхтэй оролцуулах зөвлөгөө, үр чадварын сургалт зэргийг орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласнаар энэхүү санаачилгыг улам бэхжүүлээ. Энэ байгууллага төрийн албанд Жендэрийн нөлөөллийн үнэлгээ (GIA)-г нэвтрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан бөгөөд энэ тогтолцоо нь байгууллагын ямар бодлого, хөтөлбөр эмэгтэйчүүдийн ахиц дэвшилд саад тотгор болж байгааг илрүүлэх боломж бүрдсэн байна¹⁶³.

Аавууд бол үнэ цэнтэй түнш. Эмэгтэйчүүдийн манлайлалд Аав-Нөхөр маш чухал үүрэгтэй. Гэр бүлийн үүргийг тэгш гүйцэтгэх, ажлын уян хатан сонголтыг ашиглах, тэдэнд тулгарч буй бэрхшээл, саадыг арилгахад нь дэмжлэг үзүүлэх нь чухал.

13. ТУНИС УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.42. Тунис улсын улс төрийн зарим мэдээлэл

Засаглал	Холимог / 1 танхим
Сонгуулийн жил	5 (Сүүлийн сонгууль 2019 оны 10-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Пропорционал
Парламентын нийт суудал	217 (57 эм -26.3%)
Квотын төрөл	Хуульд заасан нэр дэвшигчдийн квоттой. Бүх салбарт хариуцлагын бүх түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш хамрагдах, тэгш боломжоор хангагдах. Төр нь сонгогдсон зөвлөл бүрт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөллийг тэгш байлгахыг эрмэлздэг. (Үндсэн хуулийн 46-р зүйл)
Бусад мэдээлэл	Парламент нийт 33 тойргоос пропорционал тогтолцоогоор сонгогдсон 217 гишүүнээс бүрддэг. (Article 16 of Decree 35)
Сонгуулийн тухай хуулиас	Нэр дэвшигч нар нэр дэвших өргөдөл гаргахдаа хүйсийн тэнцвэрийг харгалзан үзэх. Жендэрийн тэгш байдлын зарчмыг хэрэгжүүлээгүй нэрсийн жагсаалтыг холбогдох тойргийн мандатын тоо сондгой байхад л зөвшөөрнө. Нэрсийн жагсаалтыг эмэгтэй, эрэгтэй гэж сөөлжилсөн (“цахилгаан товчны” жагсаалт) байх ёстой. (Article 16).

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Араб Эмэгтэйчүүдийн Сургалт, Судалгааны төв. 1994 онд Араб Эмэгтэйчүүдийн Сургалт Судалгааны төв байгуулагдсан бөгөөд

Тунист төвтэй, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллага юм. Тус төв нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тэдний

¹⁶³ UAE Gender Balance Council, *Gender Balance Guide – Actions for UAE organizations. 2019.*

нийгмийн хүрээлэл, сүлжээг өргөтгөх, сургалт судалгаа, ухуулга сурталчилгааны үйл ажиллагаа эрхэлдэг байна¹⁶⁴.

Үндэсний Ардчилсан Хүрээлэн. Тунисын улс төрийн шилжилтэд эмэгтэйчүүдийн дуу хоолой, идэвхтэй оролцоог дэмжихийн тулд Үндэсний Ардчилсан Хүрээлэн (NDI) нь эмэгтэйчүүдэд зориулан өөрсдийн нам доторх эмэгтэйчүүдийн бодлого, мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар хэрхэн сурталчлах, таниулах талаар

зөвлөгөөн семинарыг зохион байгуулдаг байна. Тус семинар эмэгтэйчүүдийн манлайллын үр чадвараас гадна, зохион байгуулалт, харилцаа холбооны үр чадварыг сайжруулах хөтөлбөр мөн багтсан байна¹⁶⁵. Мөн сонгуульд нэр дэвшигч, байгууллагын удирдлагын түвшинд ажилладаг эмэгтэйчүүдэд зориусан сонгуулийн кампанит ажлыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах, удирдлага, манлайллын зуны сургалтыг зохион байгуулдаг байна¹⁶⁶.

14. ӨМНӨД АФРИК УЛСЫН ТҮРШЛАГА


Хүснэгт 2.43. Өмнөд Африк улсын улс төрийн зарим мэдээлэл

Засаглал	Парламент / Дээд,доод танхим
Сонгуулийн жил	5 (Сүүлийн сонгууль 2019 оны 5-р сар)
Сонгуулийн тогтолцоо	Пропорционал
Парламентын нийт суудал	397 (183 эм -46.1%)
Квотын төрөл	Хуульд заасан нэр дэвшигчдийн квоттой. Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд нэрсийн жагсаалтанд орсон нэр дэвшигчдийн 50 хувийг эмэгтэйчүүд байхаар зохицуулалт хийх. Улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг хүйсээр тэгш хуваарилах үүрэгтэй. (Нутгийн удирдлагын тухай хууль, Schedule 1, Section 11 [3]; Schedule 2, Sections 5 [3] & 17 [5]).
Бусад мэдээлэл	Африкийн Үндэсний конгресс (АҮК) 1994 онд болсон парламентын сонгуулиас өмнө 30 хувийн эмэгтэйчүүдийн квотыг нам дотроо тогтоосон ганц нам юм. 2006 онд АҮК Намынхаа дүрэмд сонгуульд бүтэц бүрт эмэгтэйчүүдийн 50 хувийн квот олгох тухай нэмэлт өөрчлөлт оруулсан. Одоогийн байдлаар АҮК нь Парламентын 264 суудалтай нам юм.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Өмнөд Африкийн Жендэрийн Эрх тэгш байдал ба Эмэгтэйчүүдийн чадавхыг сайжруулах Үндэсний бодлого.

Тус бодлогын баримт бичиг нь дараах агуулгатай байна.



¹⁶⁴ IDEA, Political finance and the equal participation of women in Tunisia: a situation analysis. Magnus Ohman 2016.

¹⁶⁵ Nihel Ben Amar. Women’s Political Participation in Tunisia. 2019 EUspring.

¹⁶⁶ UNDP. Democratic Governance. Promoting Gender Equality in Electoral Assistance: Lessons Learned in Comparative perspective- Country report for Tunisia. 2014.

“Эмэгтэйчүүдийн албан бус Парламент”. “Эмэгтэйчүүдийн албан бус Парламент” гэгдэх арга хэмжээ Парламент болон Орон нутгийн удирдлагын санаачлагаар Эмэгтэйчүүдийн сар болох жил бүрийн 8 дугаар сард зохион байгуулагддаг байна. Энэ арга хэмжээгээр эмэгтэйчүүд цуглаж жендэрийн асуудлаар хэлэлцэж, хуулийн зохицуулалтыг өөрчлөх санал оруулах, бусад санаачилга дэвшүүлэх боломжийг олгодог байна.

Ингэснээр эмэгтэйчүүдийг нийгмийн асуудалд санал, шийдэл, дуу хоолойгоо өргөх сэдлийг өгдөг байна. Энэ арга хэмжээг мэргэжилтнүүд дүгнэхдээ “нэг талаар эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх чухал арга хэмжээ хэдий ч гарсан санал, санаачлага, дуу хоолойг ажил хэрэг болгохгүй орхигдуулж байгаа нь тус арга хэмжээг энгийн ‘эмэгтэйчүүдийн ярилцлага’ болгож байна” гэсэн шүүмжлэл дагуулдаг ажээ¹⁶⁷. Хэдий энэ арга хэмжээ нь бэлэгдлийн шинжтэй байна

гэсэн шүүмжлэл хүртдэг ч нийгэмд тулгамдаж байгаа асуудлын талаар богино хугацаанд иргэд, эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсож, санал авч чадаж байгаа давуу талтай байна.

Үндэсний “Төрийн удирдлагын сургууль” (NSG). Засгийн газар 2013 оны 10-р сарын 21-ний өдөр Төрийн алба, захиргааны сайдын санаачилгаар Засгийн газрын Үндэсний сургуулийг байгуулсан бөгөөд тус сургуулийг төрийн албанд сонгогдсон эмэгтэйчүүдэд чиглэсэн сургалт, зөвөлгөө өгөх хөтөлбөр, ирээдүйн удирдагч эмэгтэйчүүдийн манлайлал, хэлэлцээр хийх үр чадварын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн хөгжүүлэх чиг үүрэгтэй байна¹⁶⁸.

Тус сургуулийн онцлог нь төрийн албаны удирдах албан тушаалтан, менежерүүдийн ахиц, дэвшлийг хянаж, мониторинг хийдэг бөгөөд богино хугацааны эрчимжүүлсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

15. КАБО-ВЕРДЕ УЛСЫН ТУРШЛАГА

Хүснэгт 2.44. Кабо-Верде улсын улс төрийн зарим мэдээлэл

Харьцуулсан үзүүлэлт	Жендэрийн тэгш бус байдлын индекс (GII)	Жагсаалт	Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Жагсаалт
Монгол улс	0.322	71/162	17.3%	127/193
Кабо-Верде улс	0.397	89/162	36.1%	36/193
Засаглал	Парламент/1 танхим			
Сонгуулийн жил	5 (Сүүлийн сонгууль 2021 оны 4-р сар)			
Сонгуулийн тогтолцоо	Пропорционал			
Парламентын нийт суудал	72 (26 эм -36.1%)			
Квотын төрөл	Үндэсний ассамблейд квотгүй, боловч доод танхимд хуульчилсан квотын зарчмыг хэрэгжүүлдэг			
Сонгуулийн тухай хууль	Санал болгож буй нэрсийн жагсаалт нь хүйсийн тэнцвэртэй байх ёстой. (415 (1)-р заалт 92/V/99, VII/2010-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан). Төрийн санхүүжилтийг зөвхөн 25 хүртлэх хувийн эмэгтэй нэр дэвшигч сонгогдсон тохиолдолд улс төрийн намд олгоно. (415 (2)-р заалт) Орон нутгийн сонгуульд оруулсан нэрсийн жагсаалтад улс төрийн намууд аль аль хүйсийн төлөөллийг тэнцвэртэй байхаар зохицуулна. (431 (1)-р зүйл)			

¹⁶⁷ Commission for Gender Equality. *The Bare Minimum. Commission for Gender Equality Report on South Africa's Compliance with CEDAW Committee 2011- Concluding Observations and Recommendations. Research Report 2020.*

¹⁶⁸ National School of Government (2016). *Course Directory*. http://www.thensg.gov.za/wp-content/uploads/2016/08/NSG_Course_Directory_Final-002.pdf. Accessed: 28.10.2019.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

“Парламентын эмэгтэй гишүүдийн эвсэл”. Парламент дахь эмэгтэйчүүдийн нэгдэл (Rede de Mulheres Parlamentares de Cabo Verde, RMPCV) 2019 оны 1 сараас эхлэн “Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль”-ийн төслийг боловсруулан өргөн барихаар ажиллаж байгаа бөгөөд тус хуулиар Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, жендэрийн тэгш боломж, тэгш оролцоо, үүнд их хуралд эмэгтэйчүүдийг дэмжих 50 хувийн квот тогтоох талаар тусгасан байна.

Хуулийн төслийн хүрээнд Жендэрийн тэгш эрх, шудрага ёсны Институт(ICIEG) тай хамтран эмэгтэйчүүдэд чиглэсэн олон төрлийн сургалт зохион байгуулж байгаагаас жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, үйл ажиллагааны төлөвлөөг боловсруулахад эмэгтэйчүүдийн оролцоо, тэдний мэдлэг чадвараа ашиглах боломжийг бүрдүүлж байгаа сургалт онцлог байгаа юм. Төрийн бодлого боловсруулах үйл явцад эмэгтэйчүүдийг сурган, чадавхжуулах нь тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах ач холбогдолтой гэж үзсэн байна¹⁶⁹.

Улс орнуудын шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор олон төрлийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан нь үр дүнд хүргэх нэг нөхцөл болсон байна. Тэр дундаа нийгмийн хангамж, эдийн засгийн чадавхыг сайжруулах гэх мэт нийгмийн суурь асуудлаас эхлэн хөндсөн нь үр дүнд хүргэсэн байна.

Улс орнуудын хэрэгжүүлсэн онцлох санаачлага, төсөл хөтөлбөр арга хэмжээнүүдийг ерөнхийлөн ажиглавал дараахтай адил бүлэглэж болохоор байна.

1. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг дэмжих бодлого, хөтөлбөр
 - a. Ажил-Амьдралын тэнцвэрийг хангах- Хүүхэд, ахмад настанг асрах нөхцөл, аав/нөхрийн үүрэг, хариуцлагын ухамсрыг дэмжих бодлого гэх мэт
 - b. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр

- эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр
2. Эмэгтэйчүүдийн манлайллын сургалт, чадавхыг бэхжүүлэх бодлого хөтөлбөр
 - a. Эмэгтэйчүүдийн манлайллын сургууль, институт
 - b. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх судалгаа, сургалт
3. Улс төрийн намын эмэгтэйчүүдийг дэмжих бодлого, хөтөлбөр
 - a. Сонгуульд нэр дэвшигчийн нэр жагсаалтыг “Цахилгаан товч”-ны зарчмын дагуу боловсруулах
 - b. Сонгуулийн зардал- Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангах, Эмэгтэй нэр дэвшигч нарт үзүүлэх тэтгэлэг.
4. Сонгогчийн боловсролыг дэмжих хөтөлбөр
 - a. Эмэгтэй хүн шийдвэр гаргах түвшинд ажиллах ач холбогдол, жендэрийн хэвшмэл ойлголтыг халах арга хэмжээ
 - b. Хэвлэл мэдээллийн салбартай хийх хамтын ажиллагаа
 - c. Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа
5. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн нэгдсэн мэдээллийн сан
 - a. Эмэгтэй удирдагч, манлайлагч нарын нэгдсэн мэдээллийн сан байгуулан, хүртээмжтэй ажлын байрыг бий болгох замаар тэдний нийгмийн идэвх, чадавхыг нэмэгдүүлэх
 - b. Парламент дахь эмэгтэйчүүдийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, ололт амжилт, үйл ажиллагааны талаар олон нийтэд танилцуулан, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.

¹⁶⁹ [iknowpolitics.org https://www.iknowpolitics.org/en/news/world-news/cabo-verde-female-parliamentarians-deliver-documents-ministries-advance-gender](https://www.iknowpolitics.org/en/news/world-news/cabo-verde-female-parliamentarians-deliver-documents-ministries-advance-gender)

ДҮГНЭЛТ

Монгол Улс эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар нэлээдгүй хүчин чармайлт гаргаж, НҮБ болон бусад олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, тэдгээрийн зарчим, заалтуудыг үндэсний хууль тогтоомж, бодлого хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлж ирсэн байна. Гэвч жендэрийн зөрүүтэй байдлын индексээр 2021 онд 156 орноос 69 дүгээр байранд, улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр 156 орноос 116 дугаар байранд жагссан¹⁷⁰ бөгөөд дэлхийн болон Азийн дунджаас доогуур байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

2021 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улс парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувиар нийт 193 орноос (17.3 хувь) 127 дугаарт жагсаж байна¹⁷¹.

УИХ-д нэр дэвшигчдийн тоог авч үзвэл орон нутгийн тойргуудад нийслэл Улаанбаатар хотын тойрогтой харьцуулахад харьцангуй цөөн тооны эмэгтэйчүүд нэр дэвшиж байна.

Сүүлийн 4 удаагийн УИХ-ын сонгуульд давхардсан тоогоор нийтдээ 1814 хүн нэр дэвшсэнээс 430 нь буюу 23.7 хувь нь эмэгтэйчүүд байжээ. Үүнээс орон нутгийн тойрогт нэр дэвшигчдийн 18 хувь нь л эмэгтэйчүүд байгаа бол, нийслэл Улаанбаатар хотын тойргуудад нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэйчүүд байна.

Орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагад шат ахих тусам эмэгтэйчүүдийн төлөөлөл багасаж байна. Аймаг, нийслэлийн ИТХ-д эмэгтэй төлөөлөгчид дөнгөж 15 хувийг эзэлж байна. Харин сум, дүүргийн ИТХ-ын хувьд эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь 2016 онд 27.1 хувь, 2020 онд 28.62 хувь болжээ.

Цаашид аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасан хүйсийн квотыг нэмэгдүүлэх, эмэгтэй нэр дэвшигч, төлөөлөгчдийг дэмжих бодлого хөтөлбөрийг улс төрийн намууд дотооддоо авч

хэрэгжүүлэх, улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох шаардлага тавигдаж байна.

2021 оны байдлаар Монгол Улсын Төрийн албанд 208864 албан хаагч ажиллаж байгаагийн дийлэнх буюу 61.65¹⁷² хувь нь эмэгтэйчүүд байгаа боловч шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь ЖТБТХ-д заасан квотыг хангаж чадахгүй байна. Тухайлбал, улс төрийн албан тушаалд ажиллаж буй нийт албан хаагчдын 23.9 хувь, төрийн захиргааны тэргүүн түшмэлийн албан тушаалд ажиллаж буй нийт албан хаагчдын 25.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ нь төрийн нийт албан хаагчдын дунд эмэгтэйчүүдийн эзэлж буй дунджаас 37.7–35.9 хувиар бага байна¹⁷³.

Судалгааны тайлангуудад хийсэн шинжилгээнээс үзэхэд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлаж байгаа хүчин зүйлсийг институцийн хүчин зүйлстэй холбон үзсэн байна. Түүнчлэн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог зохицуулсан бодлого, эрх зүйн орчны шинжилгээг ихэнх судалгааны ажлуудад хийсэн бол олон улсын туршлага, сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын бодлого үйл ажиллагаатай холбож судалсан судалгааны ажил олон биш ажээ.

Мөн судалгааны тайлангуудад дурдсан дүгнэлт, зөвлөмжүүдийг төрийн байгууллага, улс төрийн намууд үйл ажиллагаандаа хэрхэн тусган хэрэгжүүлдэг талаар мэдээлэл байхгүй байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хийгдсэн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсад Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

¹⁷⁰ World Economic Forum “Global Gender Gap Report 2021”

¹⁷¹ Олон улсын парламентын холбоо. Global data on National Parliaments. June-July 2021 archive site.

¹⁷² Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны мэдээ. 2021 он.

¹⁷³ Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны мэдээ. 2021 он.

- Улс төрийн намуудын дүрэм, журмаар эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн зохицуулалт маш сул, түүний хэрэгжилт хангалтгүй байна.
- Улс төрийн намд төрөөс олгох санхүүгийн дэмжлэгийг ямар зорилгыг хангахад олгож байгаа, хэн хуваарилах, хэнд тайлагнах нь тодорхой бус, үр дүнгийн үнэлгээ, үүрэг хариуцлагатай уялдуулсан зохицуулалт байхгүй байна. Улс төрийн намын санхүүжилтийн өнөөгийн нөхцөл, бодит байдал нь хүйсийн тэгш байдлыг дэмжихгүй байна.
- “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль” (2020)-д Комиссын гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна гэсэн заалтыг оруулж, комиссын гишүүдийн 2/3 нь эмэгтэйчүүд томилогдсон бөгөөд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд 2021 оноос 1 эмэгтэй гишүүн томилогдон ажиллаж байна. Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний механизмын гол багана болох эдгээр комисс, зөвлөлийн бүрэлдэхүүнд ийнхүү өөрчлөлт орсон нь хуулийн хэрэгжилтийг хангахад том ахиц болно хэмээн үзэж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд хорооны гишүүний тухай, Төрийн албаны тухай хуульд Төрийн албаны зөвлөлийн тухай хэсэгт хорооны гишүүн, зөвлөлийн гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх тухай заалт байхгүй байгааг өөрчлөх цаг болжээ.
- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлсэд институцийн шинжтэй хүчин зүйлсээс гадна нийгмийн тогтсон хандлага, жендэрийн хэвшмэл ойлголт, эмэгтэйчүүдийн олон нийтэд танигдах, хүлээн зөвшөөрөгдөх

байдал, эмэгтэйчүүдийн эдийн засгийн болон ажил, амьдралын (ар гэр) тэнцвэрт байдал, сонгуулийн компани ажлын санхүүжилтийн асуудал зэрэг нийгмийн шинжтэй хүчин зүйлс нөлөөлж байгаа тухай дүгнэлт чанарын судалгаанд оролцогчдын мэдээлэлд хамгийн олон давтамжтайгаар дурдагдсан байна.

Судалгааны ажлын хүрээнд авч үзсэн олон улсын туршлагаас үзэхэд дэлхийн улс орнууд үндсэн хууль болон бусад хуулиндаа тэгш байдлын зарчмыг тусгаж, хүйсийн квотыг хуульчлан удаа дараа өөрчлөлт оруулах, улс төрийн намын санхүүжилтийн талаар болон нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт үйлдэх тусгай дүрэм журам батлан мөрдүүлэх зэрэг хөшүүрэг ашиглаж байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийг дэмжих төрөл бүрийн бодлого хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, улс төр болон шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Улс орнуудын туршлагаас үзэхэд зөвхөн квотыг хуульчилснаар асуудлыг шийдэхгүй гэдэг нь харагдаж байна. Харин дараах цогц арга хэмжээг бодлогын түвшинд хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрчээ. Үүнд:

- Үндсэн хууль болон бусад хуулинд хүйсийн квотыг тусган хуульчлахдаа хариуцлагын механизмыг тодорхой зааж өгсөн байна. Хуульчилсан квотын хувь хэмжээ улам бүр нэмэгдсээр байгаа төдийгүй, олон улс оронд улс төрийн намын сайн дурын квотыг хэрэгжүүлэн үр дүнд хүрч байна. Квотыг хуульчилсан 59 орноос 14 улс 50 хувь, 13 улс 40-49 хувь, 27 улс 30-39 хувь, 4 улс 20-25 хувийг хуульчилсан байна. Ихэнх улс орнууд сонгуулийн тухай хууль, улс төрийн намын тухай хууль гэх мэт органик хуулиндаа квотын хэмжээг тусгасан байна. Үүнээс Буркино-Фасо улс Квотын тухай хууль гэсэн тусгайлсан хуультай байгаа сонирхолтой байна.

- Квот болон эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих асуудлыг улс төрийн намын санхүүжилтийн асуудалтай уяж өгсөн нь үр дүнгээ өгч байна. Төсвийн дэмжлэгээр дамжуулан улс төрийн намыг төлөвшихөд нөлөөлөхөөс гадна эмэгтэйчүүд, залуучууд гэх мэт зорилтот бүлгүүдийн төлөөллийг бүх шатны сонгуульд өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, дэмжих, жендэрийн тэгш байдлыг хангах шаардлага тавьж байна.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих төрөл бүрийн хөтөлбөрүүдийг төрийн бодлогоор дэмжин хэрэгжүүлж байна. Карьер болон гэр бүлийн асуудлыг хослуулан дэмжих бодлогыг хэрэгжүүлсэн улс орнуудад энэ нь үр дүнгээ өгчээ. Зарим улс орнууд эмэгтэйчүүдийг ажил, албан тушаал эрхлэх, улс төрд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэхийн тулд эцэг, эхэд нь адилхан цалинтай чөлөө өгөх, хүүхэд төрмөгц нь яслид өгөх боломж олгох, ахмад настныг асрах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэхийн тулд ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангахад нь дэмжлэг үзүүлэх талаар тодорхой зохицуулалтыг хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байна. Энэ нь эмэгтэйчүүдийг хүүхэд, гэр бүл, ажлын карьертаа зэрэг анхаарах боломжийг бүрдүүлжээ.

Харин зарим улс орнууд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихийн тулд олон төрлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр боловсруулсан хэдий ч тэдгээрийг хэрэгжүүлэх механизмыг нарийвчлан тогтоогоогүйн улмаас амжилтанд хүрээгүй тохиолдлууд цөөнгүй байна. Мөн эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх, шийдвэр гаргах түвшин дэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, дэмжих үүргийг иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудад шилжүүлэн, хэт “найдан” орхисны улмаас амжилт олоогүй тохиолдлууд элбэг байна.

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулахад дараах саналыг оруулахаар зөвлөмжилж байна.

1. Сонгуулийн тухай хуульд хүйсийн квотыг нэмэгдүүлж, хуульчлах асуудлаар:
 - a. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (2019) хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т заасан¹⁷⁴ 20 хувийг 30-аас доошгүй хувь байхаар хуульчлах;
 - b. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай (2020) хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан квотыг 40 хувиас доошгүй байхаар хуульчлах;
 - c. Сонгуулийн пропорционал тогтолцооны хувьд хуулиудад нэр дэвшигчийн нэрсийн жагсаалт гаргах хэсэгт, нэрсийн жагсаалтад цахилгаан товчны зарчим баримтлах, эсвэл 1-3 дахь жагсаалтад нэг хүйсийн төлөөлөл 2-оос илүүгүй байх, 4-7 дахь жагсаалтад 4-өөс илүүгүй байх гэх мэт зарчмыг хэрэглэх;
 - d. Улс төрийн намын тухай хуулийн 5 дүгээр зүйл, намын үйл ажиллагааны зарчимд хэсгийн 5.1.3-т заасан “гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох” гэсэн зарчмыг үндэслэн намын дүрэмд тусгах нийтлэг зүйлд “бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, намын зохион байгуулалтын аливаа удирдах байгууллагад сонгогдох аль нэг хүйсийн төлөөлөл 50 хувь байх”- аар хуульд хатуу зааж өгөх.
2. Улс төрийн намын санхүүжилтийн асуудлаар:

Олон улсын туршлагаас харахад улс төр дэх жендэрийн тэгш байдлыг хангах, квотыг хэрэгжүүлэх асуудлыг улс төрийн намын санхүүжилттэй холбож өгснөөр үр дүнд хүрсэн байдал нэлээдгүй орнуудад харагдаж байна. Харин Монгол Улсын хувьд улс төрийн намуудад олгох төсвийн дэмжлэгийн зарчим, зориулалт нь тодорхой бус, хэн хуваарилах, хэнд тайлагнах, үр дүнгийн үнэлгээ, үүрэг хариуцлагатай уялдуулсан зохицуулалт байхгүй байна. Иймд:

 - a. Улс төрийн намын санхүүжилтийг тусад нь “Улс төрийн санхүүжилтийн хууль”- аар зохицуулах;
 - b. Улс төрийн санхүүжилтийн тухай хуульд санхүүгийн зарчмыг тусгахдаа Төсвийн тухай хуульд нийцүүлэн “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, “ил тод байдлыг хангах, “хариуцлагатай” байх зарчмыг тусгах, мөн “хүйсийн тэгш байдлыг хангах” зарчмыг оруулах (эсвэл санхүүжилт олгох нэг болзол, нөхцөл болгохоор тусгах);

¹⁷⁴ Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.

- с. Зорилтот санхүүжилтийн асуудлыг тусгай бүлэг болгож оруулах, Төрөөс улс төрийн санхүүжилт, төсвийн дэмжлэгийн талаар баримтлах бодлого нь Зорилтот бүлгийг дэмжих нэг зорилгыг хангаж байхаар үзэл баримтлалд тусгах¹⁷⁵;
- d. Улс орнуудын жишгээр парламентад сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоогоор тухайн намд төрөөс олгох санхүүжилтийг тодорхой хувиар (5-10 хувь байж болно) нэмж олгодог байх тухай заалтыг оруулах;
- e. Эмэгтэйчүүдийг олноор нэр дэвшүүлсэн намд сонгуулийн санхүүгийн дэмжлэгийг тодорхой хувиар нэмэгдүүлэн олгодог байх заалтыг тусгах;
- f. Олон нийтийн хэвлэл мэдээллээр сонгуулийн сурталчилгааны үнэгүй цагийн багадаа 10 хувийг эмэгтэй нэр дэвшигч нарт нэмж зарцуулах, Намын нийт сонгуулийн сурталчилгаанд зарцуулах хөрөнгийн 5-аас доошгүй хувийг эмэгтэй нэр дэвшигч нарт нэмэлтээр зарцуулах, талаар сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
- g. Улс төрийн намуудын төсвөөс өгөх санхүүжилтийн ил тод байдал, тайлагналын механизмыг тодорхой болгож, өмнөх жилийн тайланд үндэслэн дараагийн жилийн санхүүжилтийг өгдөг байх;
- h. Зорилтот санхүүжилтийг дээр дурдсан хууль болон намын дүрэмд заасан бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, намын зохион байгуулалтын аливаа удирдах байгууллагад сонгогдох аль нэг хүйсийн төлөөлөл 50 хувь байх” гэсэн заалтын хэрэгжилтийг үндэслэн олгодог байх. Хэрвээ тухайн жилд тухайн намын бүх шатны удирдах байгууллагад нэг хүйсийн төлөөлөл 50-аас бага байгаа тохиолдолд тухайн намын санхүүжилтийг бүхэлд нь олгохгүй байх заалт оруулах.
3. Улс төрийн намын тухай хуульд оруулах бусад санал:
- a. Аливаа сонгуульд нэр дэвшүүлэх нэрсийн жагсаалтад дараалсан 5 нэр дэвшигч тутамд нэг хүйсийн төлөөлөл 3-аас илүүгүй байхаар хуульчлах
- b. Улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн аудит хийж байх талаар хуульчлах;
- c. Улс төрийн намууд дүрмээрээ ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийг биелүүлэх үүргийг тусгах;
- d. Улс төрийн намуудын дүрэмд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохицуулсан заалтыг нарийвчлан тусгах талаар хуульд зааж, эрэгтэй эмэгтэй гишүүдэд сонгогдох эрхийг хангах тэгш гараа, боломжийг бүрдүүлэх.
- Улс төрийн санхүүжилтийн хуулийг тусад нь батлах боломжгүй тохиолдолд улс төрийн санхүүжилттэй холбоотой аливаа дүрэм, журмыг хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах хөшүүрэг болгох зорилт тавих.

¹⁷⁵ Жендэрийн тэгш оролцоо, цөөнхийн төлөөллийг улс төрд хангах зорилгын үүднээс эмэгтэйчүүд, залуучууд, нутгийн уугуул иргэдийг дэмжиж тодорхой хувийг төсвөөс санхүүжүүлдэг туршлага олон улсад бий. Тухайлбал Намуудад очих төсвийн дэмжлэгээс Чили, Өмнөд Солонгост 10%¹⁹, Финландад 12%-ийг²⁰ эмэгтэй улс төрчдийг дэмжихэд зарцуулдаг бол Колумбид Парламентад суудалтай намууд нийт төсвийн дэмжлэгийнхээ 5%-ийг эмэгтэйчүүдийн бүлгийг дэмжихэд зориулдаг²¹. Португаль, Ирланд, Франц, Италид эмэгтэйчүүдийн нэр дэвшүүлэх квотоо баримтлахгүй эсвэл тэдний улс төрийн оролцоог хязгаарлах аливаа бодлого хэрэгжүүлбэл төсвийн дэмжлэгийг бууруулах үндэслэл болдог байна. Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эсрэг үнэлгээ. Судалгааны тайлан. 2018 он.

4. Зарим хуульд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар санал болгож байна.

Хуулийн заалт	Одоо байгаа	Өөрчлөх буюу нэмэлт оруулах санал
1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)		
8 дугаар зүйлийн 8.2. дахь хэсэг	Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.	Бүх шатны сонгуульд намаас нэр дэвшсэн эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг тодорхой хувиар нэмж олгох.
8 дугаар зүйлийн 8.3.	Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна	Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна
10 дугаар зүйлийн 10.1.1	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх;	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газарт 25, аймаг, нийслэл, сум, дүүрэгт 40 хувиас, хороонд 50 хувиас доошгүй байх;
10 дугаар зүйлийн 10.1.2	Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;	Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 30 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 30 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 50 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 50 хувиас доошгүй байх;
Нэмж оруулах шаардлагатай заалт		
1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)		
Аймаг нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын НБ дарга нарын 40-өөс доошгүй хувь байхаар нэмж оруулах		
2. УИХ-ын сонгуулийн тухай хууль (2019)		
30 дугаар зүйлийн 30.2	...нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.	...нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 30-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
3. Улс төрийн намын тухай хууль (2015)		
11 дүгээр зүйлийн 11.2.8	Сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах зарчим баримтлах	намын зохион байгуулалтын аливаа удирдах байгууллагад сонгогдох аль нэг хүйсийн төлөөлөл 50 хувь байх зарчмыг баримтлах
4. Төрийн албаны тухай хууль (2017)		
68 дугаар зүйлийн 68.1	Зөвлөлийн гишүүн. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны таван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.	Зөвлөлийн гишүүн. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны таван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Гишүүдийн бүрэлдэхүүн хүйсийн тэгш байдлыг хангасан байна.
5. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)		
4 дүгээр зүйлийн 4.1.	4.1. Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны, долоо нь орон тооны бус байна.	4.1. Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны, долоо нь орон тооны бус байна. Хорооны гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд энэ хуулийн 4.1-д заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хуулиуд

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. 2011 он
2. Сонгуулийн тухай хууль.
3. Улс төрийн намын тухай хууль. 2005 он
4. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль. 2020
5. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль” (МУИХ, 2020)
6. “Төрийн албаны тухай хууль”
7. “Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль” (МУИХ, 2020)

УИХ, Засгийн газраас гаргасан бодлого, хөтөлбөр, тайлангууд

1. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
2. Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр,
3. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр. 2017 он
4. “Засгийн газрын ажиллагааны хөтөлбөрүүд” 2012-2016, 2016-2020 он
5. Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагааны тайлангууд
6. ХЭҮК- ийн тайлангууд
7. Бусад

Улс төрийн намуудын дүрэм

1. МАН- ын хичээн эрмэлзэх зүйл.
2. АН-ын дүрэм
3. ХҮН намын дотоод дүрэм

Хоёр. Өмнө хийгдсэн судалгааны тайлангууд

